



БОЛОВСРОЛ,
ШИНЖЛЭХ УХААНЫ
ЯАМ



THE WORLD BANK
IBRD • IDA | WORLD BANK GROUP



ASIAN
DEVELOPMENT
BANK



БОЛОВСРОЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ ЯАМ
БОЛОВСРОЛЫН ҮНЭЛГЭЭНИЙ ТӨВ

СУУРЬ, БҮРЭН ДУНД БОЛОВСРОЛЫН ХИЧЭЭЛ, СУРГАЛТЫН ҮР ДҮНГ ҮНЭЛЭХ ШАЛГУУР

ЭРҮҮЛ МЭНД

АНХДУГААР ХЭВЛЭЛ

УЛААНБААТАР 2021



БОЛОВСРОЛ,
ШИНЖЛЭХ УХААНЫ
ЯАМ



THE WORLD BANK
IBRD • IDA | WORLD BANK GROUP



ASIAN
DEVELOPMENT
BANK



БОЛОВСРОЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ ЯАМ
БОЛОВСРОЛЫН ҮНЭЛГЭЭНИЙ ТӨБ

СУУРЬ, БҮРЭН ДУНД БОЛОВСРОЛЫН ХИЧЭЭЛ, СУРГАЛТЫН ҮР ДҮНГ ҮНЭЛЭХ ШАЛГУУР

ЭРҮҮЛ МЭНД

АНХДУГААР ХЭВЛЭЛ

УЛААНБААТАР 2021

ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

Эрх зүйн баримт бичгүүд	8
Боловсролын үнэлгээ	18

СУУРЬ БОЛОВСРОЛЫН ТҮВШИН

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ. VI АНГИ

1.1. VI ангийн эрүүл мэндийн хичээлийн суралцахуйн үр дүн.....	23
1.2. Үнэлгээний нэгж тус бүрийн суралцахуйн үр дүнгийн шалгуур, гүйцэтгэлийн түвшин	23
Үнэлгээний нэгж 1. Хувийн эрүүл ахуй ба орчны эрүүл мэнд	23
Үнэлгээний нэгж 2. Хооллолт ба хөдөлгөөн.....	24
Үнэлгээний нэгж 3. Сэтгэцийн эрүүл мэнд	25
Үнэлгээний нэгж 4. Хорт зуршил	26
Үнэлгээний нэгж 5. Бэлгийн болон нөхөн үржихүйн эрүүл мэнд	27
Үнэлгээний нэгж 6. Аюулгүй байдал, анхны тусламж.....	28

ХОЁРДУГААР БҮЛЭГ. VII АНГИ

2.1. VII ангийн эрүүл мэндийн хичээлийн суралцахуйн үр дүн.....	29
Үнэлгээний нэгж 1. Хувийн эрүүл ахуй ба орчны эрүүл мэнд	29
Үнэлгээний нэгж 2. Хооллолт ба хөдөлгөөн.....	30
Үнэлгээний нэгж 3. Сэтгэцийн эрүүл мэнд	31
Үнэлгээний нэгж 4. Хорт зуршил	32
Үнэлгээний нэгж 5. Бэлгийн болон нөхөн үржихүйн эрүүл мэнд	32
Үнэлгээний нэгж 6. Аюулгүй байдал, анхны тусламж.....	34

ГУРАВДУГААР БҮЛЭГ. VIII АНГИ

3.1. VIII ангийн эрүүлийн мэндийн хичээлийн суралцахуйн үр дүн.....	35
Үнэлгээний нэгж 1. Хувийн эрүүл ахуй ба орчны эрүүл мэнд	35
Үнэлгээний нэгж 2. Хооллолт ба хөдөлгөөн.....	36
Үнэлгээний нэгж 3. Сэтгэцийн эрүүл мэнд	37
Үнэлгээний нэгж 4. Хорт зуршил	38
Үнэлгээний нэгж 5. Бэлгийн болон нөхөн үржихүйн эрүүл мэнд	39
Үнэлгээний нэгж 6. Аюулгүй байдал, анхны тусламж.....	40

ДӨРӨВДҮГЭЭР ХЭСЭГ. IX АНГИ

4.1. IX ангийн эрүүл мэндийн хичээлийн суралцахуйн үр дүн	42
4.2. Үнэлгээний нэгж тус бүрийн суралцахуйн үр дүнгийн шалгуур, гүйцэтгэлийн түвшин	42
Үнэлгээний нэгж 1. Хувийн эрүүл ахуй ба орчны эрүүл мэнд	42
Үнэлгээний нэгж 2. Хооллолт ба хөдөлгөөн	43
Үнэлгээний нэгж 3. Сэтгэцийн эрүүл мэнд	44
Үнэлгээний нэгж 4. Хорт зуршил	45
Үнэлгээний нэгж 5. Бэлгийн болон нөхөн үржихүйн эрүүл мэнд	46
Үнэлгээний нэгж 6. Аюулгүй байдал, анхны тусламж.....	47

БҮРЭН ДУНД БОЛОВСРОЛЫН ТҮВШИН

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ. X АНГИ

1.1. X ангийн эрүүл мэндийн хичээлийн суралцахуйн үр дүн	51
1.2. Үнэлгээний нэгж тус бүрийн суралцахуйн үр дүнгийн шалгуур, гүйцэтгэлийн түвшин	51
Үнэлгээний нэгж 1. Хувийн эрүүл ахуй ба орчны эрүүл мэнд	51
Үнэлгээний нэгж 2. Хооллолт ба хөдөлгөөн	52
Үнэлгээний нэгж 3. Сэтгэцийн эрүүл мэнд	53
Үнэлгээний нэгж 4. Хорт зуршил	54
Үнэлгээний нэгж 5. Бэлгийн болон нөхөн үржихүйн эрүүл мэнд	54
Үнэлгээний нэгж 6. Аюулгүй байдал, анхны тусламж.....	56

ХОЁРДУГААР ХЭСЭГ. XI АНГИ

2.1. XI ангийн эрүүл мэндийн хичээлийн суралцахуйн үр дүн	57
2.2. Үнэлгээний нэгж тус бүрийн суралцахуйн үр дүнгийн шалгуур, гүйцэтгэлийн түвшин	57
Үнэлгээний нэгж 1. Хувийн эрүүл ахуй ба орчны эрүүл мэнд	57
Үнэлгээний нэгж 2. Хооллолт ба хөдөлгөөн	58
Үнэлгээний нэгж 3. Сэтгэцийн эрүүл мэнд	59
Үнэлгээний нэгж 4. Хорт зуршил	60
Үнэлгээний нэгж 6. Аюулгүй байдал, анхны тусламж.....	62

ГУРАВДУГААР ХЭСЭГ. XII АНГИ

3.1. XII ангийн эрүүл мэндийн хичээлийн суралцахуйн үр дүн	64
3.2. Үнэлгээний нэгж тус бүрийн суралцахуйн үр дүнгийн шалгуур, гүйцэтгэлийн түвшин	64
Үнэлгээний нэгж 1. Хувийн эрүүл ахуй ба орчны эрүүл мэнд	64
Үнэлгээний нэгж 2. Хооллолт ба хөдөлгөөн	65
Үнэлгээний нэгж 3. Сэтгэцийн эрүүл мэнд	66
Үнэлгээний нэгж 4. Хорт зуршил	67
Үнэлгээний нэгж 5. Бэлгийн болон нөхөн үржихүйн эрүүл мэнд	68
Үнэлгээний нэгж 6. Аюулгүй байдал, анхны тусламж	69



МЭНДЧИЛГЭЭ

*Эрхэм баян-эрдэм мэдлэгийг түгээн
дэлгэрүүлэгч эрдэмтэн багш нар аа!*

Хурдацтай хувьсан өөрчлөгдөж буй өнөөгийн нийгэмд зохицон амьдрах хувь хүний эрэлтийг нийгмийн хэрэгцээтэй уялдуулан хөгжүүлэхэд дэлхийн улс орнууд ихээхэн анхаарч, боловсролын тогтолцоогоо улам бүр боловсронгуй болгож байна.

Сургалтын хөтөлбөрт суралцагчийн суралцах чадварын хөгжил, шинжлэх ухааны мэдлэг, ойлголтын эзэмшилт, аливаа зүйлийг судлах сонирхол, идэвх зүтгэлд гарч буй ахиц амжилтыг үнэлэхээр үнэлгээний зорилтыг тодорхойлсон бөгөөд суралцагчийн үнэлгээний журамд “үнэлгээ нь шалгуурт суурилсан” байхаар заасан.

Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2021 оны “Шалгуур үзүүлэлт батлах тухай” А/180 дугаар тушаалаар ерөнхий боловсролын сургуулийн хичээл, сургалтын үр дүнг үнэлэх шалгуурыг боловсролын түвшин, анги, хичээл бүрээр сургалтын хөтөлбөрийн хүрэх үр дүнд нийцүүлэн боловсруулж, баталлаа.

Энэхүү шалгуур үзүүлэлт батлагдсанаар суралцагчийн ахиц амжилтыг ижил шалгуураар үнэлэх /суралцагчдын ялгаатай байдлыг тодорхойлох/, хичээлийн бэлтгэлийг чанартай хангах /нэгж, ээлжит хичээлийн төлөвлөлт хийх/ зэрэг багш, суралцагч, эцэг эх, асран хамгаалагчийн хамтын ажиллагааг сайжруулах, эргэх холбоотой ажиллах боломж бүрдэх юм.

Оюунлаг, чадварлаг, бүтээлч шинэ эриний “Монгол хүн” бүтээх гол цөм, тулах цэг нь болсон багш, боловсролын ажилтан та бүхэнд эрүүл энх, амжилт бүтээлийн дээдийг хүсэн ерөөе.

Энэхүү гарын авлагыг боловсруулахад оролцсон эрдэмтэн багш, судлаач нар болон техникийн дэмжлэг үзүүлсэн Азийн Хөгжлийн банкны “Эдийн засгийн үед боловсролын чанар, хүртээмжийг сайжруулах төсөл”, Дэлхийн банкны “Бага боловсролын шинэчлэл” төслийн хамт олонд талархал илэрхийлье.

БОЛОВСРОЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ ЯАМ

Лувсанцэрэнгийн ЭНХ-АМГАЛАН
Боловсрол, шинжлэх ухааны сайд



МЭНДЧИЛГЭЭ

Боловсролын үнэлгээний тогтолцоог боловсронгуй болгох үйлсэд оюун ухаан, хүч хөдөлмөрөө зориулан ажиллаж байгаа эрдэмтэн багш, боловсролын ажилтан, судлаачид та бүхнийхээ энэ өдрийн амар амгаланг айлтгая.

Суралцагчдад хаана, ямар орчинд суралцаж байгаагаас үл хамааран ижил шалгуур, ижил арга, аргачлалаар сурлагын амжилт, ахицаа бодитой тодорхойлуулах хэрэгцээ ямагт байдаг. Суралцагчийн эзэмшсэн мэдлэг, чадвар, хандлага төлөвшлийг бодитой, шинжлэх ухаанчаар үнэлж дүгнэн үнэлгээний үр дүнг сургалтын үйл ажиллагаанд үр нөлөөтэйгээр хэрэглэх нь манай орны төдийгүй дэлхийн улс орнуудын багш нарт ч сорилт хэвээр байна.

2018 онд БСШУС-ын (хуучнаар) сайдын А/425 дугаар тушаалаар баталсан “Ерөнхий боловсролын сургуулийн суралцагчийн болон сургалтын чанарын үнэлгээний журам”-д суралцагчийн үнэлгээг шалгуурт суурилсан бөгөөд суралцагчийн сурах хүсэл эрмэлзэл, сурлагын ахиц, амжилтыг дэмжиж, тэднийг хөгжүүлэхэд чиглэсэн байхаар тодорхойлсон нь дээрх хэрэгцээ, шаардлагыг хангах нөхцөлийг бүрдүүлсэн.

Үнэлгээний шалгуур нь хичээл, сургалтын үр дүнд суралцагчийн юу мэддэг, юу чаддаг, яаж хийж хэрэглэх ёстойг тодорхойлж өгсөн суралцахуй, багшлахуйн ач холбогдолтой “үнэлгээний гол хэрэгсэл” юм. Багш та үнэлгээний шалгуурыг сургалтын үйл ажиллагаанд бүтээлчээр хэрэглэснээр суралцагчийн гүйцэтгэлд тулгуурлан сурлагын амжилт, ахиц, өөрчлөлтийн талаар бодитой, үр нөлөөтэй үнэлэлт, дүгнэлт хийж тэдэнд ямар дэмжлэг, хэрхэн үзүүлэхээ тодорхойлох бүрэн боломж бүрдэнэ.

Боловсролын үнэлгээний төв нь хичээл тус бүрээр эрдэмтэн, багш, судлаачдын баг бүрдүүлэн хичээл, сургалтын үр дүнг үнэлэх шалгуурыг боловсролын түвшин, судлагдахуун бүрээр үнэлгээний нэгжийн түвшинд анх удаагаа боловсруулж та бүхний гар дээр хүргэж байна.

Үнэлгээний шалгуурыг олон улсын түвшинд боловсролын үнэлгээ, тэр дундаа суралцагчийн үнэлгээ, үнэлгээний шалгуур чиглэлээр баримталж буй онол, үзэл баримтлалд тулгуурлан өөрийн орны сургалтын хөтөлбөр, багшлахуй, суралцахуйн онцлогийг харгалзан боловсруулсан.

Боловсролын үнэлгээний тогтолцоог сайжруулахад үнэтэй хувь нэмэр оруулах эрхэм багш та бүхний үйлс нь улам өөдөө байж, боловсролын хөгжлийн төлөө сэтгэл, зүтгэл нэгдэн урагшилна гэдэгт итгэл дүүрэн байгаагаа илэрхийлье.

БОЛОВСРОЛЫН ҮНЭЛГЭЭНИЙ ТӨВ

Лхагвасүрэнгийн ГАНБАТ
Захирал

МОНГОЛ УЛСЫН БОЛОВСРОЛ, СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААН,
СПОРТЫН САЙДЫН А/425 ТООТ ТУШААЛ



Захиргааны хэм хэмжээний
актын улсын нэгдсэн санд
2018 оны 02 сарын 23-ны
өдрийн 3267 дугаарт бүртгэв.

МОНГОЛ УЛСЫН БОЛОВСРОЛ,
СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААН, СПОРТЫН
САЙДЫН ТУШААЛ

2018 оны 06 сарын 29 өдөр

Дугаар А/425

Улаанбаатар хот

Г Журам шинэчлэн батлах тухай Г

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.2 дахь хэсэг, Бага, дунд боловсролын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1, 9.2, 9.3 дахь хэсэг, Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 3 дугаар бүлгийн 3.2.9 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Ерөнхий боловсролын сургуулийн суралцагчийн болон сургалтын чанарын үнэлгээний журам”-ыг хавсралтаар баталсугай.

2. “Ерөнхий боловсролын сургуулийн суралцагчийн болон сургалтын чанарын үнэлгээний журам”-ыг 2018-2019 оны хичээлийн жилээс эхлэн өмчийн бүх хэлбэрийн бага, суурь, бүрэн дунд боловсрол эзэмшүүлэх сургалтын байгууллагад мөрдсүгэй.

3. Энэхүү журмыг албан бус сургалтын дүйцсэн хөтөлбөрөөр суралцаж буй суралцагчдыг үнэлэхэд баримталсугай.

4. Энэхүү тушаалаар батлагдсан журмын хэрэгжилтийг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангаж ажиллахыг Ерөнхий боловсролын бодлогын газар /Т.Ням-Очир/, Боловсролын үнэлгээний төв /Ж.Ган-Эрдэнэ/, нийслэлийн Боловсролын газар, аймгуудын Боловсрол, соёл, урлагийн газарт тус тус даалгасугай.

5. Журмыг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлыг жил бүр улсын төсөвт тусгаж ажиллахыг Санхүү, хөрөнгө оруулалтын газар /Х.Галсанхүү/, Боловсролын үнэлгээний төв /Ж.Ган-Эрдэнэ/-д тус тус үүрэг болгосугай.

6. Журам шинэчлэн батлагдсантай холбогдуулан Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайдын 2013 оны “Журам, загвар шинэчлэн батлах тухай” А/309 дүгээр тушаалаар батлагдсан “Ерөнхий боловсролын сургуулийн суралцагчийн болон чанарын үнэлгээний журам”-ыг хүчингүй болсонд тооцсугай.

САЙД




Ц.ЦОГЗОЛМАА

1553

МОНГОЛ УЛСЫН БОЛОВСРОЛ, СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААН,
СПОРТЫН САЙДЫН А/425 ТООТ ЖУРМЫН ХАВСРАЛТ

Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын
2018 оны 06 дугаар сарын 29-ний өдрийн
А/425 дугаар тушаалын хавсралт



**ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛИЙН СУРАЛЦАГЧИЙН БОЛОН
СУРГАЛТЫН ЧАНАРЫН ҮНЭЛГЭЭНИЙ ЖУРАМ**

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Өмчийн бүх хэлбэрийн ерөнхий боловсролын сургуулийн суралцагчийн мэдлэг, чадварын ахиц амжилт, үр дүн, төлөвшлийг үнэлж, дүгнэх, хөндлөнгийн хяналт, чанарын үнэлгээ хийхэд энэхүү журмыг баримтална.

1.2. Суралцагчийн үнэлгээ нь сурлагын ахиц, амжилтыг үнэлж, сургалтын арга хэлбэр, зохион байгуулалтад тохируулга хийх; анги дэвших болон сургууль төгсөх шалгалт /цаашид "улсын шалгалт" гэх/ нь сургалтын хөтөлбөрийн хэрэгжилтийн үр дүнг үнэлж, сургуулийн үйл ажиллагаа, багшийн арга зүй, ур чадварыг сайжруулах; чанарын үнэлгээ нь боловсролын чанар, үр дүнг тодорхойлж, бодлого, төлөвлөлтийг боловсронгуй болгоход тус тус чиглэнэ.

Хоёр. Үнэлгээнд баримтлах зарчим

2.1. Үнэлгээ нь шударга, бодитой, хөндлөнгийн нөлөөллөөс ангид, шалгуурт суурилсан, суралцагчийн сурах хүсэл эрмэлзэл, сонирхол, ур чадвар, ахиц, амжилтыг дэмжсэн, урамшуулах, хөгжүүлэхэд чиглэсэн байх;

2.2. Үнэлж дүгнэх үйл ажиллагаа нь зорилготой, сургалтын хөтөлбөрт нийцсэн, суралцагчийн нас, сэтгэхүй, хөгжлийн ялгаатай байдал, онцлог хэрэгцээг харгалзсан, агуулга, хэлбэр нь уян хатан, багш, суралцагч, эцэг эх, асран хамгаалагчид ойлгомжтой, нээлттэй, ил тод байх;

2.3. Анги дэвших болон улсын шалгалтын сэдэв, даалгавар нь танин мэдэхүйн түвшинд нийцсэн, тохирц, найдварыг шалгасан, нууцлалыг хадгалсан, шалгуулагчдыг хүндэтгэсэн, найдвартай байх.

Гурав. Суралцагчийн мэдлэг, чадвар, төлөвшлийн үнэлгээ

3.1. Суралцагчийн үнэлгээ нь тэдний эзэмшсэн мэдлэг, чадварын ахиц, төлөвшил, хандлагын өөрчлөлтийг тооцох, сургууль, багшийн үйл ажиллагааг үнэлж, дүгнэх, сургалтын чанар, үр дүнг сайжруулахад чиглэнэ.

3.2. Суралцагчийн үнэлгээ нь оношлох, явцын, үр дүнгийн гэсэн төрөлтэй байх бөгөөд үнэлгээ нь шалгуурт суурилсан байна.

3.3. "Шалгуурт суурилсан үнэлгээ" нь суралцагчийн амжилтын түвшинг хүрэх үр дүнтэй харьцуулан үнэлэхэд чиглэнэ.

3.4. Хичээл, сургалтын үр дүнг үнэлэх шалгуурыг боловсролын түвшин, анги, хичээл бүрээр боловсролын эрдэм шинжилгээ, арга зүйн байгууллага, боловсролын үнэлгээний байгууллага хамтран боловсруулж, батална.

3.5. Оношлох үнэлгээ нь хичээлийн жилийн эхэнд эсвэл нэгж хичээл, бүлэг сэдэв эхлэхийн өмнө суралцагчийн мэдлэг, чадварын түвшинг тандах зорилгоор хийх үнэлгээ байна. Оношлох үнэлгээг ажиглалт, ярилцлага, хэлэлцүүлэг, асуулт, сорил, судалгаа гэх мэт хэлбэрээр хийнэ.

МОНГОЛ УЛСЫН БОЛОВСРОЛ, СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААН, СПОРТЫН САЙДЫН А/425 ТООТ ЖУРМЫН ХАВСРАЛТ

3.6. Явцын үнэлгээ нь суралцахуйг дэмжих, сайжруулах зорилгоор хичээл, сургалтын явцад тогтмол хийх үнэлгээ байна.

3.7. Явцын үнэлгээг хичээлийн явцад суралцагчийн суралцах үйлийг дэмжихэд чиглэсэн ажиглалт, асуулт, ярилцлага, хэлэлцүүлэг, бие даах ажил, рубрик, суралцагчийн өөрийн болон бусад суралцагчийн үнэлгээ гэх мэт арга, хэлбэрээр багш хийнэ. Явцын үнэлгээг сургалтын баримт бичиг /багшийн журнал/-т стандарт бус тэмдэглэгээгээр тэмдэглэж болно.

3.8. Үр дүнгийн үнэлгээг сурлагын амжилтын үр дүнг хэмжих зорилгоор бүлэг сэдвийн төгсгөл болон хагас жил /II улирлын төгсгөл/, хичээлийн жилийн эцэс /IV улирлын төгсгөл/-т хийнэ. Анги дэвших, улсын шалгалт нь үр дүнгийн үнэлгээ байна.

3.9. Үр дүнгийн үнэлгээг аман болон бичгийн шалгалт, сорил, туршилт, судалгааны ажил, тайлан, төсөлт ажил, илтгэл, эссэ, бүтээл, биечлэн хийж гүйцэтгэх зэрэг хэлбэрээр хийнэ.

3.10. Суралцагчийн мэдлэг, чадвар, төлөвшлийн ахиц амжилт, өөрчлөлтийг үнэлэхэд I, II ангид оношлох болон явцын үнэлгээ, III-XII ангид оношлох, явцын, үр дүнгийн үнэлгээний төрлийг ашиглана.

3.11. Үр дүнгийн үнэлгээ нь тухайн хичээл, судлагдахууны агуулгын хүрээнд дараах 8 түвшинтэй байна.

Түвшин	Үнэлгээ, хувиар	Үнэлгээний түвшний шалгуур
VIII	90-100	- Шинжлэх ухааны юмс үзэгдэл, нэр томьёо, ухагдахуун, хууль зарчим, зүй тогтлыг бүрэн ойлгож, шинжлэх ухааны үг хэллэг ашиглан аливаа асуудлыг тайлбарлах, тодорхойлох, үнэлэлт дүгнэлт өгөх, санал гаргах түвшинд эзэмшсэн - Эзэмшсэн мэдлэг ойлголтоо асуудал шийдвэрлэх, мэдээлэл боловсруулах ямар ч нөхцөлд хэрэглэдэг - Таамаглал /асуудал, асуулт/ дэвшүүлэн шинжлэн судлах үйлээ төлөвлөдөг - Асуудал шийдвэрлэх, мэдээлэл боловсруулах оновчтой аргыг сонгон хэрэглэдэг - Асуудал, мэдээлэлд дүн шинжилгээ хийж, эргэцүүлэн бодож дүгнэлт гаргадаг, түүнийгээ шинжлэх ухааны үүднээс оновчтой илэрхийлдэг
VII	80-89	- Шинжлэх ухааны юмс үзэгдэл, нэр томьёо, ухагдахуун, зарчим, хууль, зүй тогтол, хоорондын хамаарлыг ойлгож эзэмшсэн - Эзэмшсэн мэдлэг ойлголтоо танил бус нарийн төвөгтэй нөхцөлд хэрэглэдэг - Таамаглал /асуудал, асуулт/ дэвшүүлэн шинжлэн судлах үйлээ төлөвлөдөг - Асуудал шийдвэрлэх, мэдээлэл боловсруулах оновчтой аргыг сонгодог - Асуудал, мэдээлэлд дүн шинжилгээ хийж, эргэцүүлэн бодож дүгнэлт гаргадаг, түүнийгээ оновчтой илэрхийлдэг
VI	70-79	- Шинжлэх ухааны юмс үзэгдэл, нэр томьёо, ухагдахуун, зарчим, хууль зүй тогтлыг ойлгосон - Эзэмшсэн мэдлэг ойлголтоо танил төвөгтэй нөхцөлд хэрэглэдэг - Таамаглал /асуудал, асуулт/ дэвшүүлж, шинжлэн судлах үйлийг зааврын дагуу төлөвлөдөг - Асуудлыг шийдвэрлэх, мэдээллийг боловсруулах тохирох аргыг сонгон хэрэглэдэг - Асуудал, мэдээлэлд дүн шинжилгээ хийж, эргэцүүлэн бодож дүгнэлт гаргадаг
V	60-69	- Шинжлэх ухааны нэр томьёо, ухагдахуун, зарчим, хуулийг ойлгосон - Эзэмшсэн мэдлэг ойлголтоо шинэ нөхцөлд зааврын дагуу хэрэглэдэг - Таамаглал /асуудал, асуулт/ дэвшүүлж, шинжлэн судлах, төлөвлөхөд оролцдог - Асуудал шийдвэрлэх, мэдээлэл боловсруулах тохирох аргыг сонгодог. - Асуудал, мэдээллийг эргэцүүлэн бодож, гол санааг илэрхийлдэг
IV	50-59	- Шинжлэх ухааны нэр томьёо, ухагдахуун, зарчмыг бүрэн ойлгосон. - Эзэмшсэн мэдлэг ойлголтоо танил нөхцөлд хэрэглэдэг - Асуулт асуух, асуудал таамаглал дэвшүүлж, шинжлэн судлах үйлд оролцдог. - Асуудал шийдвэрлэх, мэдээлэл боловсруулах аргыг сонгон хэрэглэхийг хичээдэг. - Асуудал, мэдээллийг эргэцүүлэн бодож, санал бодлоо энгийн байдлаар илэрхийлдэг

МОНГОЛ УЛСЫН БОЛОВСРОЛ, СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААН, СПОРТЫН САЙДЫН А/425 ТООТ ЖУРМЫН ХАВСРАЛТ

III	40-49	• Шинжлэх ухааны нэр томьёо, ухагдахуун, зарчмыг ойлгох, тайлбарлах түвшинд эзэмшсэн • Эзэмшсэн мэдлэг ойлголтоо танил, хялбар нөхцөлд хэрэглэдэг • Бусдын дэмжлэгтэй, зааврын дагуу хялбар асуудлыг шийдвэрлэдэг • Асуулт асууж, таамаглал дэвшүүлдэг
II	30-39	• Шинжлэх ухааны нэр томьёо, ухагдахууныг таних, нэрлэх, цээжлэх түвшинд эзэмшсэн • Эзэмшсэн мэдлэг ойлголтоо заавар, аргачлалын дагуу ашигладаг
I	0-29	• Шинжлэх ухааны нэр томьёо, ухагдахууныг таних, нэрлэх түвшинд эзэмшсэн

3.12. I-II ангид суралцагчийн тухайн хичээлийн жилд хүрсэн үр дүнг явцын үнэлгээнд үндэслэн анги удирдсан багш дүгнэн хувийн хэрэгт бичиж, эцэг эх, асран хамгаалагчид танилцуулна.

3.13. III-XII ангийн суралцагчийг бүлэг сэдвийн төгсгөлд, хичээлийн жилийн II, IV улирлын эцэст тус тус багш үнэлнэ. Энэхүү үнэлгээний үр дүн /хувь/-г ангийн журналд тэмдэглэнэ. IV улирлын эцэст хийсэн үнэлгээ /хувь/ нь жилийн эцсийн дүн байна.

3.14. III-XII ангийн жилийн эцсийн дүн болон анги дэвших, улсын шалгалтын дүнг ангийн журнал, суралцагчийн хувийн хэрэгт анги удирдсан багш тус тус тэмдэглэнэ.

3.15. Тусгай хэрэгцээт боловсролын сургалтын төлөвлөгөө, хөтөлбөрөөр суралцаж буй суралцагчийг тухайн төлөвлөгөө, хөтөлбөрт нийцсэн шалгуураар үнэлнэ. Шалгуурыг боловсролын эрдэм шинжилгээ, арга зүйн байгууллага, боловсролын үнэлгээний байгууллага хамтран боловсруулна.

3.16. Хөгжлийн бэрхшээлийн онцлог, суралцах чадамжид суурилсан ганцаарчилсан сургалтын төлөвлөгөө, хөтөлбөрөөр суралцаж буй суралцагчийн хөгжлийн ахиц, өөрчлөлтийг явцын үнэлгээгээр үнэлнэ. Суралцагчийн анги дэвших, сургууль төгсөх асуудлыг явцын үнэлгээнд үндэслэн, энэхүү журмын 4.6-д заасан шалгалтын комисс шийдвэрлэнэ.

3.17. Ерөнхий боловсролын сургууль, боловсролын асуудал эрхэлсэн орон нутгийн байгууллага багшид зөвлөн туслах зорилгоор суралцагчийн мэдлэг, чадварын түвшинд хөндлөнгийн үнэлгээ, хяналт-шинжилгээ хийж болно. Энэхүү үнэлгээ, хяналт-шинжилгээ нь тухайн байгууллагын жилийн ажлын төлөвлөгөөнд тусгагдсан байна.

3.18. Суралцагчийн төлөвшилийг хичээл, хичээлээс гадуурх сургалтын ажилд оролцсон байдал, идэвх санаачилгын талаарх хичээл заадаг болон анги удирдсан багшийн тэмдэглэл, баримт нотолгоонд үндэслэн дараах чиглэлээр дүгнэж, суралцагчийн хувийн хэрэгт бичнэ.

- санал бодлоо илэрхийлэх, бусдыг хүндэтгэн харилцах, зөрчил, маргааныг эв зүйгээр шийдвэрлэх байдал;
- бие даан сурах арга барил, бусадтай хамтран ажиллах;
- шинжлэн судлах хүсэл эрмэлзэл, сонирхол, оролцоо;
- соёл, уламжлалаа дээдлэх, асуудал шийдвэрлэх чадвар, бүтээлч, ажил хэрэгч байдал;
- хувийн болон орчны эрүүл ахуй, аюулгүй амьдрах, байгальтай харьцах, хамгаалах, нийгмийн харилцаанд оролцох хандлагад гарч буй өөрчлөлт;
- шинэ орчин, харилцаанд дасан зохицох чадварт гарч буй өөрчлөлт.

3.19. Анги удирдсан багш суралцагчийн мэдлэг, чадвар, төлөвшилийн үнэлгээний талаарх дүгнэлт, саналыг хичээлийн жилийн II, IV улирлын эцэст эцэг эх, асран хамгаалагчид танилцуулна.

МОНГОЛ УЛСЫН БОЛОВСРОЛ, СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААН, СПОРТЫН САЙДЫН А/425 ТООТ ЖУРМЫН ХАВСРАЛТ

3.20. Суралцагчийн мэдлэг, чадвар, төлөвшлийн үнэлгээний мэдээлэл нууцлалтай байх бөгөөд энэхүү мэдээлэлтэй багш, суралцагч, эцэг эх, асран хамгаалагч цахим болон бусад хэлбэрээр танилцах боломжийг сургууль бүрдүүлнэ.

Дөрөв. Анги дэвших шалгалт, түүний зохион байгуулалт

4.1. Анги дэвших шалгалт нь суралцагчийн мэдлэг, чадвар эзэмшилтийн түвшинг тогтооход чиглэнэ.

4.2. Сургууль нь энэхүү журмын 3.4-т заасан байгууллагаас баталсан шалгуурын дагуу дараах чиглэлээр журмын 3.9-д заасан хэлбэрээс сонгож анги дэвших шалгалтыг зохион байгуулна.

Боловсролын түвшин	Анги	Шалгалтын тоо	Шалгалтын чиглэл
Бага боловсрол	III	1	Нэгдмэл агуулга /III ангийн хөтөлбөрийн агуулгаар/
	IV	2	- Сургууль сонгох 1 хичээл - Нэгдмэл агуулга /шалгалттай хичээлээс бусад/
Суурь боловсрол	VI	2	- Монгол хэл, бичиг, уран зохиол /нэгдмэл агуулга/ - Математик - Сургууль сонгох 1 хичээл
	VII	3	- Монгол хэл, бичиг, уран зохиол /нэгдмэл агуулга/ - Математик - Сургууль сонгох 1 хичээл /шалгалтгүй хичээлээс/
	VIII	3	- Монгол хэл, бичиг, уран зохиол /нэгдмэл агуулга/ - Математик - Суралцагч сонгох 1 хичээл /шалгалтгүй хичээлээс/
Бүрэн дунд боловсрол	X	3	- Монгол хэл, бичиг, уран зохиол /нэгдмэл агуулга/ - Математик - Суралцагч сонгох 1 хичээл /хими, биологи, физик, газарзүй, нийгмийн ухаан, түүх, англи хэл, орос хэл хичээлээс/
	XI	3	- Монгол хэл, бичиг, уран зохиол /нэгдмэл агуулга/ - Математик - Сонгох хичээл /хими, биологи, физик, газарзүй, нийгэм судлал, түүх, англи хэл, орос хэл хичээлээс/

4.4. Журмын 3.4-т заасан байгууллагаас баталсан шалгуур болон “Анги дэвших шалгалтын бюпринт” /цаашид бюпринт гэх/, шалгалт зохион байгуулах нэгдсэн удирдамж, шалгалтын үр дүнд шинжилгээ хийх маягт, зөвлөмжийг боловсролын асуудал эрхэлсэн орон нутгийн байгууллага жил бүрийн 5 дугаар сарын 01-ний өдрийн дотор ерөнхий боловсролын сургуульд хүргүүлнэ.

4.5. Боловсролын асуудал эрхэлсэн орон нутгийн байгууллага нь ерөнхий боловсролын сургуулийн анги бүрийн сургалтын хөтөлбөрт нийцсэн “Даалгаврын нээлттэй сан” бүрдүүлж, өмчийн бүх хэлбэрийн сургуульд хүргэх, түүнийг хэрэглэх арга зүйгээр хангах ажлыг хичээлийн жилийн турш зохион байгуулна.

4.6. Анги дэвших болон улсын шалгалт зохион байгуулах ажлыг сургуулийн захирлын тушаалаар томилогдсон “Шалгалтын комисс” зохион байгуулна. Комиссын дарга нь сургуулийн захирал байх бөгөөд сургалтын менежер, багш, суралцагчийн эцэг эх, асран хамгаалагчийн төлөөллийг оролцуулна. Комиссын гишүүн эцэг эх, асран хамгаалагчийн төлөөлөл шалгалтын сэдэв, даалгавар боловсруулахад оролцохгүй.

МОНГОЛ УЛСЫН БОЛОВСРОЛ, СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААН, СПОРТЫН САЙДЫН А/425 ТООТ ЖУРМЫН ХАВСРАЛТ

4.7. Энэхүү журмын 4.6-д заасан шалгалтын комисс дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ.

4.7.1. анги дэвших шалгалт зохион байгуулах удирдамж, дэг боловсруулж, хэрэгжүүлэх;

4.7.2. анги дэвших шалгалттай холбогдон гарсан аливаа гомдол, маргааныг эцэслэн шийдвэрлэх;

4.7.3. шалгалтын үнэлгээ, дүн мэдээг боловсролын асуудал эрхэлсэн орон нутгийн байгууллагаас өгсөн зөвлөмж, маягтын дагуу нэгтгэн, шалгалт зохион байгуулж дууссанаас хойш 10 хоногийн дотор боловсролын салбарын мэдээллийн системд оруулах ажлыг удирдамжаар хангах, хяналт тавих.

4.8. Боловсролын асуудал эрхэлсэн орон нутгийн байгууллага нь анги дэвших шалгалтын үр дүнд шинжилгээ хийж, сургууль бүрд зөвлөмж боловсруулж, жил бүрийн 8 дугаар сарын 25-ны өдрийн дотор хүргүүлнэ.

4.9. Боловсролын асуудал эрхэлсэн орон нутгийн байгууллага нь анги дэвших шалгалтын дүнд үндэслэн зөвлөн туслах ажлын төлөвлөгөө боловсруулж хэрэгжүүлнэ.

4.10. Сургууль энэхүү журмын 4.8-д заасан зөвлөмжид үндэслэн сургалтын үйл ажиллагааг төлөвлөн явуулна.

Тав. Улсын шалгалт, түүний зохион байгуулалт

5.1. Улсын шалгалт нь бага, суурь, бүрэн дунд боловсролын сургалтын хөтөлбөрийн хэрэгжилт, сурлагын амжилтад хөндлөнгийн үнэлгээ, хяналт-шинжилгээ хийхэд чиглэнэ.

5.2. Улсын шалгалтын үр дүн нь бага, дунд боловсролын сургалтын үр ашиг тооцох, сурлагын амжилтыг сайжруулах суурь мэдээлэл болно.

5.3. Бага, суурь бүрэн дунд боловсролын түвшний төгсөх ангийн суралцагч дараах хичээлээр улсын шалгалт өгнө.

Боловсролын түвшин	Анги	Шалгалтын тоо	Шалгалтын агуулга
Бага боловсрол	V	3	1. Монгол хэл 2. Математик 3. Хүн ба байгаль
Суурь Боловсрол	IX	4	1. Монгол хэл, бичиг, уран зохиол /нэгдмэл агуулга/ 2. Математик 3. Сонгох шалгалт: /суралцагч аль нэгийг сонгоно./ • Байгалийн ухааны нэгдмэл агуулга • Нийгмийн ухаан, түүх /нэгдмэл агуулга/ 4. Гадаадхэл /англи хэл, орос хэл-аль нэгийг суралцагч сонгоно/
Бүрэн дунд боловсрол	XII	4	1. Монголхэл, бичиг, уран зохиол /нэгдмэл агуулга/ 2. Математик 3. Сонгох шалгалт /хими, биологи, физик, газарзүй, нийгмийн ухаан, түүх аль нэгийг сонгоно/ 4. Гадаад хэл /англи, орос хэл-аль нэгийг суралцагч сонгоно/

5.4. Улсын шалгалтын товыг боловсролын үнэлгээний байгууллагаас жил бүр тогтоох бөгөөд шалгалтыг улсын хэмжээнд зэрэг эхлүүлж, дуусгана.

5.5. Улсын шалгалтын үнэлгээг энэхүү журмын 3.11-д заасан үнэлгээгээр үнэлнэ.

МОНГОЛ УЛСЫН БОЛОВСРОЛ, СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААН, СПОРТЫН САЙДЫН А/425 ТООТ ЖУРМЫН ХАВСРАЛТ

5.7.Боловсролын үнэлгээний байгууллага нь "Улсын шалгалтын бюлпринт" /цаашид бюлпринт" гэх/, шалгалтын сэдэв боловсруулах, дүгнэх зөвлөмжийг жил бүрийн 5 дугаар сарын 15- ны өдрийн дотор баталгаажуулж, боловсролын асуудал эрхэлсэн орон нутгийн байгууллагад хүргүүлнэ.

5.8.Боловсролын үнэлгээний байгууллага нь бага, суурь, бүрэн дунд боловсролын анги бүрийн сургалтын хөтөлбөрт нийцсэн "Даалгаврын нээлттэй сан" /цаашид "даалгаврын сан" гэх/ бүрдүүлэх, шинэчлэх, баяжуулалт хийх ажлыг хариуцна.

5.9.Боловсролын асуудал эрхэлсэн орон нутгийн байгууллага нь "Улсын шалгалтын комисс"- ыг жил бүрийн 5 дугаар сарын 01 -ний өдрийн дотор байгуулна. Энэхүү комисс нь тухайн орон нутагт улсын шалгалт зохион байгуулах ажлыг удирдлага, арга зүйгээр хангаж, хяналт тавьж ажиллана.

5.10. Сургууль дээр улсын шалгалт зохион байгуулахтай холбогдуулан энэхүү журмын 4.6-д заасан шалгалтын комисс дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ.

5.10.1.улсын шалгалтын удирдамж, дэгийг боловсруулж, шалгалтыг зохион байгуулах;

5.10.2.шалгалт эхлэхээс 1 өдрийн өмнө энэхүү журмын 5.7-д заасан бюлпринт, зөвлөмжийн дагуу улсын шалгалтын сэдэв боловсруулж, нууцлалыг хариуцах;

5.10.3.шалгалтын дүн мэдээг боловсролын салбарын мэдээллийн системд оруулах ажлыг удирдан зохион байгуулж, хяналт тавих;

5.10.4.хөгжлийн бэрхшээлтэй суралцагч шалгалт өгөх тохиолдолд тэдний хөгжлийн онцлог, хэрэгцээнд тохирсон шалгалтын орчин бүрдүүлэх;

5.10.5.улсын шалгалттай холбогдон гарсан аливаа маргааныг эцэслэн шийдвэрлэх;

5.10.6.шалгалтын материал, тайланг сургуулийн архивт хүлээлгэн өгөх.

5.11.Шалгалт зохион байгуулах хугацаанд улсын болон олон улсын уралдаан, тэмцээнд оролцсон суралцагчийн улсын шалгалтын үнэлгээг нотлох баримтад үндэслэн жилийн эцсийн үнэлгээгээр тооцно.

5.12.Суралцагч өвчлөх, ар гэрийн гачигдал тохиолдох болон давагдашгүй хүчин зүйлийн улмаас шалгалт өгөөгүй эсвэл дутуу өгсөн тохиолдолд улсын шалгалтын үнэлгээг жилийн эцсийн үнэлгээгээр тооцож болно.

5.13.Боловсролын үнэлгээний байгууллага нь боловсролын салбарын мэдээллийн системд оруулсан улсын шалгалтын дүнд шинжилгээ хийж, жил бүрийн 10 дугаар сард багтаан, боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага болон боловсролын эрдэм шинжилгээ, арга зүйн байгууллагад тус тус хүргүүлнэ.

5.14.Журмын 5.9-д заасан "Улсын шалгалтын комисс" нь улсын шалгалт зохион байгуулсан тайланг нэгтгэн, шалгалт дууссанаас хойш 10 хоногийн дотор боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлнэ.

Зургаа. Чанарын үнэлгээ, түүний зохион байгуулалт

6.1.Бага, дунд боловсролын чанарын үнэлгээ нь суралцагчийн мэдлэг, чадварын түвшинг үндэсний түвшинд тогтоох, сурлагын амжилтад нөлөөлж буй хүчин зүйлийг судлах, боловсролын бодлогын хэрэгжилтийг үнэлэхэд чиглэнэ.

6.2.Чанарын үнэлгээг боловсролын үнэлгээний байгууллага зохион байгуулна.

6.3.Чанарын үнэлгээнд өмчийн бүх хэлбэрийн ерөнхий боловсролын сургуулийн нийт суралцагчийн 10-аас доошгүй хувийг хамруулна.

6.4.Боловсролын үнэлгээний байгууллага нь чанарын үнэлгээ зохион байгуулах товыг боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын саналыг үндэслэн тогтооно.

6.5.Чанарын үнэлгээг зохион байгуулах агуулгын хүрээ, шалгуурыг боловсролын үнэлгээний байгууллага, боловсролын эрдэм шинжилгээ, арга зүйн байгууллага хамтран жил бүрийн 01 дүгээр сард багтаан тогтооно.

6.6.Боловсролын үнэлгээний байгууллага нь чанарын үнэлгээг зохион байгуулах удирдамж, аргачлалыг жил бүрийн 2 дугаар сарын 15-ны өдрийн дотор боловсруулж, боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагаар баталгаажуулна.

МОНГОЛ УЛСЫН БОЛОВСРОЛ, СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААН, СПОРТЫН САЙДЫН А/425 ТООТ ЖУРМЫН ХАВСРАЛТ

6.7.Боловсролын үнэлгээний байгууллага нь чанарын үнэлгээний өгөгдлийн сан үүсгэх, дүн шинжилгээ хийж, тайлан, санал, дүгнэлтийг боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, боловсролын эрдэм шинжилгээ, арга зүйн байгууллага, багшийн мэргэжил дээшлүүлэх сургалт, арга зүйн байгууллага, боловсролын асуудал эрхэлсэн орон нутгийн байгууллагад тус тус хүргүүлнэ.

6.8.Чанарын үнэлгээний үр дүнд үндэслэн энэхүү журмын 6.7-д заасан байгууллага бодлого боловсруулах, зөвлөн туслах ажлыг зохион байгуулна.

6.9.Боловсролын асуудал эрхэлсэн орон нутгийн байгууллага, ерөнхий боловсролын сургуулийн удирдлага чанарын үнэлгээний тайланд үндэслэн сурлагын амжилтыг сайжруулах төлөвлөгөө гаргаж ажиллана.

6.10.Боловсролын асуудал эрхэлсэн орон нутгийн байгууллага нь чанарын үнэлгээг зохион байгуулахад бүх талын дэмжлэг үзүүлж ажиллана.

Долоо. Бусад

7.1.Аливаа төрийн бус байгууллага, иргэний нийгмийн байгууллага боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын зөвшөөрөлгүйгээр суралцагчийн мэдлэг, чадвар, төлөшлийг үнэлэх, шалгалт зохион байгуулахыг хориглоно.

---oOo---

МОНГОЛ УЛСЫН БОЛОВСРОЛ, СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААН,
СПОРТЫН САЙДЫН А/180 ТООТ ТУШААЛ



МОНГОЛ УЛСЫН
БОЛОВСРОЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ
САЙДЫН ТУШААЛ

2021 оны 05 сарын 14 өдөр

Дугаар А/180

Улаанбаатар хот

Шалгуур үзүүлэлт батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Боловсролын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.1.2, 28.1.8 дахь заалт, Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын 2018 оны "Журам шинэчлэн батлах тухай" А/425 дугаар тушаалаар батлагдсан "Ерөнхий боловсролын сургуулийн суралцагчийн болон сургалтын чанарын үнэлгээний журам"-ын 3.4 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ НЬ:


1. Ерөнхий боловсролын сургуулийн суралцагчийн хичээл, сургалтын үр дүнг үнэлэх шалгуурыг хавсралтаар баталсугай.

2. Суралцагчийн хичээл, сургалтын үр дүнг энэхүү тушаалаар баталсан "Ерөнхий боловсролын сургуулийн суралцагчийн хичээл, сургалтын үр дүнг үнэлэх шалгуур"-ыг баримтлан 2021-2022 оны хичээлийн жилээс эхлэн үнэлсүгэй.

3. Шалгуурын дагуу үнэлгээ хийх арга зүйн зөвлөмжийг боловсруулж, ерөнхий боловсролын сургуулийн багш, удирдах ажилтныг арга зүйн удирдлагаар хангаж ажиллахыг Бага, дунд боловсролын газар /Т.Ням-Очир/, Боловсролын үнэлгээний төв /Л.Ганбат/, аймаг, нийслэлийн Боловсрол, соёл, урлагийн газрын дарга нарт үүрэг болгосугай.

4. Энэхүү тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн нарийн бичгийн дарга Д.Батбаатарт даалгасугай.

САЙД



Л.ЭНХ-АМГАЛАН

142110643

СУРАЛЦАГЧИЙН ҮНЭЛГЭЭ
(*Student assessment*)

Сурлагын амжилтын түвшнийг тогтоох, мэдлэг, чадвар, хандлага төлөвшлийн ахиц, өөрчлөлтийг бодитой үнэлэх, тэдэнд тулгарч буй бэрхшээлийг илрүүлж дэмжлэг үзүүлэх, урамшуулах үйл явц;

ШАЛГУУР
(*Criteria*)

Зорилт, стандартын биелэлтийг тодорхойлоход ашигладаг жишиг үзүүлэлт эсвэл түвшин;
(UNESCO-CEPES, 2007)

ҮНЭЛГЭЭНИЙ ШАЛГУУР
(*Assessment criteria*)

Суралцахуйн үр дүнд хүрэхэд шаардлагатай тодорхой мэдлэг, чадвар, хандлагыг тодорхойлдог.

ОНОШЛОХ ҮНЭЛГЭЭ
(*Diagnostic assessment*)

Хичээл, сургалтын эхэнд суралцагчдын өмнөх мэдлэг, чадвар, хандлага төлөвшлийг тандах зорилгоор хийгдэх үнэлгээ;

ЯВЦЫН ҮНЭЛГЭЭ
(*Formative assessment*)

Багш, суралцагчийн зүгээс суралцагчийн “суралцахуй”-г танин мэдэх, хариу үйлдэл үзүүлэх зорилгоор сургалтын явц /ээлжит хичээл/-д хийгдэх үнэлгээ;

ҮР ДҮНГИЙН ҮНЭЛГЭЭ
(*Summative assessment*)

Хичээл, сургалт /нэгж, хагас жил, жилийн эцэст г.м тодорхой хугацааны/-ын дараа үнэлгээний шалгуурт хүрсэн байдлыг тогтоож, цаашид суралцахуй болон багшлахуйд анхаарах зүйлийг тодорхойлох зорилгоор хийгдэх үнэлгээ;

СУРАЛЦАГЧИЙН ҮНЭЛГЭЭ

Боловсролын үнэлгээний нэг чухал хэсэг нь суралцагчийн үнэлгээ юм. Энэ нь суралцагчийн суралцах үйл ажиллагаа /суралцахуй/-ны талаарх мэдээлэл цуглуулах, сайжруулах, шаардлагатай тохиолдолд шийдвэр гаргах зорилгоор системтэй мэдээлэл цуглуулах, дүн шинжилгээ хийх, үнэлэлт дүгнэлт хийх үйл явц юм. Багш нар хичээл сургалтын явцад суралцагчийг үнэлж журналд дүн тавих, нэгж, бүлэг сэдвийн дараа шалгалт /сорилго¹/ авах, засаж оноожуулах /хэмжилт хийх²/, үнэлж дүгнэх³ зэрэг байнга хийдэг ажил нь үнэлгээний үйл явцад хамаарна.

Бид үнэлгээний шалгалт авах, дүн тавих үйл явцыг хийдэг боловч шалгалтаар дамжуулан суралцахуйн талаар ямар ач холбогдолтой мэдээлэл цуглуулж буй, үр дүнд шинжилгээ хийх, шинжилгээний үр дүнг сургалтын үйл ажиллагаанд бүтээлчээр хэрэглэх байдлыг орхигдуулж ирсэн. Суралцагчийн үнэлгээг зөвхөн дүн тавихын тулд хийж ирсэн тогтсон ойлголт, хандлагыг өөрчлөх хэрэгцээ байна.

Суралцагчийн үнэлгээ гэдэгт “суралцагчийн сурлагын амжилтын түвшнийг тогтоох, мэдлэг, чадвар, хандлага төлөвшилийн ахиц, өөрчлөлтийг бодитой үнэлэх, түүнд тулгарч буй бэрхшээлийг илрүүлж дэмжлэг үзүүлэх, урамшуулах үйл явц”-ыг ойлгоно.

Хичээл, сургалтын өдөр тутмын болон тодорхой хугацааны /бүлэг сэдэв, хагас жил, жилийн эцэс/ дараа хийдэг бүх төрлийн үнэлгээ “шалгуур”-т суурилсан байна.

ШАЛГУУРТ СУУРИЛСАН ҮНЭЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ШАЛГУУР

Багш нарын хувьд “үнэлгээ”-г шалгуурт суурилсан байдлаар үр дүнтэй хийхийн тулд үнэлгээний шалгуур болон шалгуурт суурилсан үнэлгээний талаарх мэдлэг ойлголтоо өргөжүүлэн гүнзгийрүүлэх шаардлагатай.

Суралцахуйн үр дүнд эзэмшвэл зохих мэдлэг, чадвар, хандлага төлөвшилд баримжаалж боловсруулсан тодорхой шалгуур (хүрэх үр дүн)-тай харьцуулж суралцагчийн сурлагын амжилтыг үнэлэх үйл явцыг шалгуурт суурилсан үнэлгээ /criterion referenced assessment/ гэдэг. Өөрөөр хэлбэл суралцагчийн гүйцэтгэлийг бусад суралцагчтай бус зөвхөн үнэлгээний шалгууртай харьцуулж үнэлж, дүгнэх үйл явц гэсэн үг.

Үнэлгээний шалгуур нь:

- Суралцахуйн үр дүнд нийцсэн сурагчийн гүйцэтгэлийг хэрхэн тодорхойлохыг зааж өгдөг.
- Сурагч суралцахуйн үр дүнг амжилттай эзэмшсэнийг харуулахын тулд юуг хийж чадаж байгаагийн товч илэрхийлэл
- Суралцахуйн үр дүн бүрийг эзэмшсэн байх тодорхой, хоёрдмол утгагүй нотолгоог бий болгох зорилготой.

1 Сорилго нь бүх суралцагчдыг тодорхой хугацааны дараа зохион байгуулдаг, асуултын багцаас тогтсон үнэлгээний тодорхой төрөл юм. Сорилго нь тоон болон ямар нэг ангиллын хэмжээсийг ашиглан суралцагчийн нэг ба хэд хэдэн шинж чанарыг хэмжих, илэрхийлэх гэсэн системтэй арга хэрэгсэл юм.

2 Хэмжилт нь сорилго, эсвэл үнэлгээний төрлийн үр дүнг тусгай дүрэм (жишээлбэл, зөв хариултыг тоолох, оноо өгөх г.м)-ийн дагуу тоогоор илэрхийлдэг. Ихэнхдээ оноо өгөх /scoring/ гэж тодорхойлдог.

3 Үнэлгээний мэдээллийг хэрэглэн, тогтсон шалгуур үзүүлэлтэд харгалзах чансааг тодорхойлох үйл явц

Өөрөөр хэлбэл, үнэлгээний шалгуур гэдэг нь сургалтын явцад суралцагч бүрийн эзэмшвэл зохих мэдлэг, чадвар, хандлага төлөвшил буюу хүрэх үр дүн юм.

Үнэлгээний шалгуур нь дараах ач холбогдолтой. Үүнд:


- Суралцагчийн сурлагын амжилтыг үнэлж, дүгнэх ижил хэмжүүрийг тодорхой, ил тод болгох.
- Үнэлгээг зөв, бодитой хийх боломж бүрдэх.
- Даалгавар боловсруулахад баримжаа болох.
- Тухайн суралцагчийн суралцахуйн давуу, сул тал, тулгамдаж буй бэрхшээлийн талаарх мэдээллийг цуглуулах.
- Суралцахуйн арга зүйг төлөвлөх, хэрэгжүүлэх замаар багшлахуйг сайжруулах боломжийг бүрдүүлэх.
- Суралцагчийг ижил шалгуураар үнэлж, тэдний ахиц амжилт, өөрчлөлтийг хянах боломж олгох.

Үнэлгээний шалгуур нь дараах шаардлагад⁴ нийцсэн байна. Үүнд:

- Боловсролын түвшин, анги, судлагдахуун бүрээр залгамж холбоотой, эрэмбэ ахисан байх
- ЕБС-ийн багш нар шууд авч ашиглах боломжтой байхаар боловсруулсан байх
- Оролцогч бүх тал /суралцагч, багш, эцэг эх, асран хамгаалагч гэх мэт/-д ойлгогдохоор товч тодорхой, оновчтой энгийн үг хэллэгээр бичсэн байх
- Давхцалгүй, нэг нэгнээсээ ялгаатай байх
- Суралцагчдад юу хийхийг тодорхой ойлгуулахуйц үйл /түлхүүр үг/ үгсийг ашигласан байх. Жишээ нь: эмхэтгэх, бий болгох, бүтээх, төлөвлөх, дахин боловсруулах, шинжлэх, дизайн хийх, сонгох, ашиглах, хэрэглэх, үзүүлэх, бэлтгэх, ашиглах, тооцоолох, тайлбарлах, урьдчилан таамаглах, харьцуулах, шүүмжлэх гэх мэт
- Сурагчийн гүйцэтгэл нь ажиглагдахуйц, хэмжигдэхүйц байхаар үг сонгох


ХИЧЭЭЛ, СУРГАЛТЫН ҮР ДҮНГ ҮНЭЛЭХ ШАЛГУУРЫН БҮТЭЦ

Ерөнхий боловсролын сургуулийн түвшинд хичээл, сургалтын үр дүнг үнэлэх шалгуурыг сургалтын хөтөлбөрийн хүрэх үр дүнд тулгуурлан дараах бүтэцтэйгээр боловсруулсан.



⁴ Эх сурвалж: Боловсролын салбарын хөгжил-Боловсролын чанарт нөлөөлж буй сургуулийн хүчин зүйлс" судалгааны эцсийн тайлан, 1.14 дэх бүлэг. Азийн хөгжлийн банкны техник туслалцааны төсөл, 2017 он.

ХИЧЭЭЛ, СУРГАЛТЫН ҮР ДҮНГ ҮНЭЛЭХ ШАЛГУУР



СУУРЬ БОЛОВСРОЛЫН ТҮВШИН

ЭРҮҮЛ МЭНД

ХИЧЭЭЛ, СУРГАЛТЫН ҮР ДҮНГ ҮНЭЛЭХ ШАЛГУУР

Нэгдүгээр бүлэг - VI анги
Хоёрдугаар бүлэг - VII анги
Гуравдугаар бүлэг - VIII анги
Дөрөвдүгээр - IX анги

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ. VI АНГИ

1.1. VI АНГИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ХИЧЭЭЛИЙН СУРАЛЦАХУЙН ҮР ДҮН

Үнэлгээний зорилт	Суралцахуйн үр дүн
Мэдлэг ойлголт	- Шүд эрүүл байх нь хүний биеийн эрхтэн тогтолцоонд болон гоо сайханд нөлөөлдөг болох, түгээмэл тохиолддог халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх, дотуур хувцас, ариун цэврийн хэрэглэлийг өөртөө тохируулан зөв сонгож, хэрэглэх талаар мэдлэгтэй болно. - Хоол хүнсний илчлэг чанарын талаар мэдлэгтэй болно. - Мэдрэмж, эерэг ба сөрөг сэтгэл хөдлөлийн талаар ойлголттой болно. - Эмийг эмчийн заавраар хэрэглэхийн ач холбогдлын талаар ойлголттой болно. - Үерхэл нөхөрлөл, хайраа үр дүнтэй илэрхийлэх арга зам, жендэрийн хэвшмэл ойлголтын талаар мэддэг болно. - Гэртээ болон хичээлээс гадуурх үйл ажиллагааны үед тохиолдож болох аюул эрсдэлээс өөрийгөө болон бусдыг хамгаалах талаар мэдлэгтэй болно.
Чадвар	- Шүдээ тогтмол зөв угаах, түгээмэл тохиолддог халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх, дотуур хувцас, ариун цэврийн хэрэглэлийг өөртөө тохируулан зөв сонгож, хэрэглэх чадвартай болно. - Илчлэг багатай болон ихтэй хүнсийг шошго ашиглан ялган тодорхойлох чадвартай болно. - Мэдрэмж, сэтгэл хөдлөлөө үр дүнтэй зохицуулж чаддаг болно. - Өдөр бүр тогтмол дасгал хөдөлгөөн хийж хэвшихийн давуу талыг тодорхойлдог. - Эрүүл ба эрүүл бус харилцааг ялгаж чаддаг болно. - Үе тэнгийнхний дарамт шахалтыг шийдвэрлэж, гутаан доромжлох, ялгаварлан гадуурхах, жендэрийн хэвшмэл ойлголтын сөрөг үр дагаварт дүн шинжилгээ хийж чаддаг болно. - Гэртээ болон хичээлээс гадуурх үйл ажиллагааны үед тохиолдож болох аюул эрсдэлийг таамаглаж түүнээс хамгаалах арга замуудыг тодорхойлох чадвартай болно.
Хандлага	- Халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх, эрүүл мэндээ хамгаалах, өөрийн болон бусдын эрүүл мэндийн төлөө санаа тавих хандлагатай болно. - Илчлэгийн хэмжээг харгалзан хоол хүнсээ сонгож, зохистой хэрэглээг хэвшүүлнэ. - Эмийн буруу хэрэглээнээс татгалздаг болно. - Бусдад хүндэтгэлтэй ханддаг болно. - Шаардлагатай тохиолдолд бусдад туслах, анхны тусламж үзүүлэх хандлагатай болно.

1.2. ҮНЭЛГЭЭНИЙ НЭГЖ ТУС БҮРИЙН СУРАЛЦАХУЙН ҮР ДҮНГИЙН ШАЛГУУР, ГҮЙЦЭТГЭЛИЙН ТҮВШИН

Үнэлгээний нэгж 1. Хувийн эрүүл ахуй ба орчны эрүүл мэнд

№	Суралцахуйн зорилт	Суралцахуйн үр дүн
1	6,01.а. Шүдний бүтэц, үүргийг хоол боловсруулах эрхтэн тогтолцоо болон гоо сайхантай холбон тайлбарлах, шүд цайруулах, пааландах үйлчилгээний давуу, сул талыг тайлбарлах	Сурагч шүд эрүүл байх нь хүний биеийн эрхтэн тогтолцоонд болон гоо сайханд нөлөөлдгийг тайлбарладаг болно.
2	6,01.б. Түгээмэл тохиолддог гэдэсний халдварт өвчнийг нэрлэж, халдвар дамжих зам, илрэх шинж тэмдэг, урьдчилан сэргийлэх арга замыг тайлбарлах	Сурагч түгээмэл тохиолддог халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх арга замуудыг тайлбарладаг болно.
3	6,01.в. Дотуур хувцсаа зөв сонгох, түүний эрүүл ахуйн (угаах, арчлах хадгалах) охид ариун цэврийн хэрэглэлийг зөв сонгох, хэрэглэх	Сурагч дотуур хувцас, ариун цэврийн хэрэглэлийг өөртөө тохируулан зөв сонгож хэрэглэхийн ач холбогдлыг тайлбарладаг болно.

ХИЧЭЭЛ, СУРГАЛТЫН ҮР ДҮНГ ҮНЭЛЭХ ШАЛГУУР

№	Суралцахуйн үр дүн	Суралцахуйн үр дүнгийн шалгуур
1	Сурагч шүд эрүүл байх нь хүний биеийн эрхтэн тогтолцоонд болон гоо сайханд нөлөөлдгийг тайлбарладаг болно.	Сурагч эрүүл шүдтэй байхын ач холбогдлыг хүний хоол боловсруулах эрхтэн тогтолцоо болон гоо сайхантай холбон тайлбарладаг.
2	Сурагч түгээмэл тохиолддог халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх арга замыг тайлбарладаг болно.	Сурагч гэдэсний халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх арга замыг тайлбарладаг.
3	Сурагч дотуур хувцас, ариун цэврийн хэрэглэлийг өөртөө тохируулан зөв сонгож хэрэглэхийн ач холбогдлыг тайлбарладаг болно.	Сурагч дотуур хувцас, ариун цэврийн хэрэглэлийг зөв сонгож хэрэглэхийн ач холбогдлыг тайлбарладаг.

Гүйцэтгэлийн түвшин

Суралцахуйн үр дүнгийн шалгуур	Гүйцэтгэлийн түвшин			
	I	II	III	IV
Сурагч эрүүл шүдтэй байхын ач холбогдлыг хүний хоол боловсруулах эрхтэн тогтолцоо болон гоо сайхантай холбон тайлбарладаг.	Шүд эрүүл байхын ач холбогдлыг жагсаан бичдэг.	Шүд хорхойтох өвчин нь хоол боловсруулах эрхтэн тогтолцоонд нөлөөлдөг эрсдэлт хүчин зүйлтэй хэрхэн холбоотой болохыг тайлбарлаж, задлан шинжилдэг.	Шүд цайруулах, пааландах зэрэг гоо сайхны үйлчилгээний давуу ба сул талыг хэлэлцэж эрсдэлээс зайлсхийх алхмуудыг шийдвэрлэдэг.	Шүдээ зөв арчилж эрүүл байдлаа хадгалах нь гоо сайхны эмчилгээ, үйлчилгээнд хамрагдсанаас илүү болохыг бусдад сурталчилдаг.
Сурагч гэдэсний халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх арга замуудыг тайлбарладаг.	Гэдэсний халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх аргуудаас 3-аас доошгүйг нэрлэдэг.	Гэдэсний халдварт өвчний үед илрэх шинж тэмдэг, халдвар дамжих замыг зурагт үзүүлэн ашиглан тайлбарладаг.	Гэдэсний халдварт өвчин гарах шалтгаан, сөрөг үр дагаврыг жишээ гарган тайлбарлаж, задлан шинжилдэг.	Гэдэсний халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх арга замуудын талаар бусдад зориулан зөвлөмж гаргадаг.
Сурагч дотуур хувцас, ариун цэврийн хэрэглэлийг зөв сонгож хэрэглэхийн ач холбогдлыг тайлбарладаг.	Дотуур хувцасны эрүүл ахуйн дэглэмээс 3-4-ийг нэрлэдэг.	Эрүүл ахуйн дэглэмийг сахихын ач холбогдлыг үнэлж өөрт тохирсон дотуур хувцсаа сонгохын давуу талыг судалж, тайлбар хийдэг.	Дотуур хувцсыг шошго ашиглан хэрхэн зөв угаах, арчлах, хадгалах талаар бусдад сурталчилдаг.	Ариун цэврийн хэрэглэлийг шошго ашиглан хэрхэн сонгох талаар зөвлөмж бичиж бусдад тусалдаг.

Үнэлгээний нэгж 2. Хооллолт ба хөдөлгөөн

№	Суралцахуйн зорилт	Суралцахуйн үр дүн
1	6.02.а. Хүнсний бүтээгдэхүүний илчлэг чанарыг харгалзан аюулгүй байдлыг ханган зохистой хооллох	Сурагч энэ нэгжийг үзсэний дараа нас, бие махбодын онцлогт тохирсон илчлэг бүхий хоол хүнс, дасгал хөдөлгөөний үеийн усны хэрэглээг зохицуулдаг болно.
2	6.02.б. Биеийн өсөлт хөгжлөө дэмжих идэвхтэй хөдөлгөөн тогтмол хийх үед усны хэрэглээг хянаж зохицуулах	

№	Суралцахуйн үр дүн	Суралцахуйн үр дүнгийн шалгуур
1	Сурагч энэ нэгжийг үзсэний дараа нас, бие махбодын онцлогт тохирсон илчлэг бүхий хоол хүнс, дасгал хөдөлгөөний үеийн усны хэрэглээг зохицуулдаг болно.	Хүнсэнд агуулагдах уураг, өөх тос, нүүрс-ус зэрэг шимт бодисын хэмжээг үндэслэн хоногийн хоолоор авах илчлэгийг тооцоолдог
2		Өөрийн биеийн онцлог болон дасгал хөдөлгөөний үед хэрэглэх усны хэмжээг тооцоолдог.

Гүйцэтгэлийн түвшин

Суралцахуйн үр дүнгийн шалгуур	Гүйцэтгэлийн түвшин			
	I	II	III	IV
Хүнсэнд агуулагдах уураг, өөх тос, нүүрс-ус зэрэг шимт бодисын хэмжээг үндэслэн хоногийн хоолоор авах илчлэгийг тооцоолдог.	Хүнсний бүтээгдэхүүний шошго ашиглан илчлэг багатай болон ихтэй байгааг нэрлэдэг.	100гр хүнсэнд агуулагдах шимт бодисын хэмжээг үндэслэн өглөөний цайндаа хэрэглэдэг хүнсний бүтээгдэхүүний илчлэгийг тооцоолдог.	100 гр хүнсэнд агуулагдах шимт бодисын хэмжээг ашиглан өдөр ба оройн хоолны илчлэгийн хэмжээг тооцоолдог.	100 гр хүнсэнд агуулагдах шимт бодисын хэмжээг үндэслэн нэг өдрийн хоолны илчлэгийг харьцуулан дүгнэлт хийдэг.
Өөрийн биеийн онцлог болон дасгал хөдөлгөөний үед хэрэглэх усны хэмжээг тооцоолдог.	Өдөрт уудаг нийт шингэний жагсаалт гарган усны хэмжээг тооцоолдог.	Биеийн жинд тохирох болон дасгал хөдөлгөөний үед хэрэглэх усны хэмжээг зөв тооцоолдог	Дасгал хөдөлгөөн хийх үед хэрэглэх усны хэмжээг тооцоолсноор хүний биед ус ямар чухлыг тайлбарладаг	Дасгал хөдөлгөөн хийх үед биеэс ус, шингэн ихээр алдагдсанаас болж үүсэх эрсдлээс сэргийлэх алхмуудыг томъёолдог

Үнэлгээний нэгж 3. Сэтгэцийн эрүүл мэнд

№	Суралцахуйн зорилт	Суралцахуйн үр дүн
1	6,03.а. Мэдрэмж, эерэг, сөрөг сэтгэл хөдлөлөө таньж мэдэх ба эергээр илэрхийлэх	Сурагч янз бүрийн нөхцөлд өөрийн мэдрэмж, сэтгэл хөдлөлөө эергээр үр дүнтэй зохицуулж чаддаг болно.
2	6,03.б. Сэтгэл хөдлөлөө зүй бусаар илэрхийлэхээс зайлсхийх, уур бухимдлаа зохицуулах	

№	Суралцахуйн үр дүн	Суралцахуйн үр дүнгийн шалгуур
1	Сурагч янз бүрийн нөхцөлд өөрийн мэдрэмж, сэтгэл хөдлөлөө эергээр үр дүнтэй зохицуулж чаддаг болно.	Янз бүрийн нөхцөлд үүсэх мэдрэмжээ илэрхийлдэг. Сэтгэл хөдлөлөө эерэг арга замаар зохицуулдаг.

ХИЧЭЭЛ, СУРГАЛТЫН ҮР ДҮНГ ҮНЭЛЭХ ШАЛГУУР

Гүйцэтгэлийн түвшин

Суралцахуйн үр дүнгийн шалгуур	Гүйцэтгэлийн түвшин			
	I	II	III	IV
Янз бүрийн нөхцөлд үүсэх мэдрэмжээ илэрхийлдэг.	Эерэг болон сөрөг мэдрэмжээ илэрхийлэх зааварт тусгасан үг хэллэгийг хэлдэг.	Өгсөн нөхцөлд эерэг болон сөрөг мэдрэмжээ илэрхийлэх оновчтой хувилбарыг сонгодог.	Эерэг болон сөрөг мэдрэмжээ оновчтой илэрхийлэх үг хэллэгийг тодорхой хэдэн нөхцөлд хэрэглэдэг.	Эерэг болон сөрөг мэдрэмжээ оновчтой илэрхийлэх үг хэллэгийг ямар ч тохиолдолд чөлөөтэй хэрэглэдэг.
Сэтгэл хөдлөлөө эерэг арга замаар зохицуулдаг.	Өгсөн нэг нөхцөлийг харгалзахгүйгээр сэтгэл хөдлөлөө зохицуулах эерэг аргыг нэрлэж тайлбарладаг.	Өгсөн нөхцөлд нийцүүлэн сэтгэл хөдлөлөө зохицуулах эерэг аргыг хэрэглэж ашиглах оролдлого хийдэг.	Өгсөн нөхцөлийн хүрээнд сэтгэл хөдлөлөө зохицуулах өөрт тохирох эерэг аргыг оновчтой сонгон хэрэглэдэг.	Өгсөн ямар ч нөхцөлийн хүрээнд сэтгэл хөдлөлөө зохицуулах эерэг аргыг үр дүнтэй хэрэглэдэг.

Үнэлгээний нэгж 4. Хорт зуршил

№	Суралцахуйн зорилт	Суралцахуйн үр дүн
1	6.04.а. Цахим хэрэгслийг хэтрүүлэн хэрэглэхээс татгалзах	Сурагч энэ нэгжийг үзсэний дараа дэлгэцийн донтолт, түүний үр дагаврыг шүүн хэлэлцэх замаар цахим хэрэгслийг зөв тохируулан хэрэглэдэг болно.
2	6.04.б. Эмийг эмчийн заавраар хэрэглэхийн ач холбогдол, дур мэдэн хэрэглэхийн хор уршгийг тодорхой жишээгээр харьцуулан тайлбарлах	Сурагч энэ нэгжийг үзсэний дараа эмийн гаж нөлөө, түүний үр дагаврын баримтад үндэслэн эмийн зохисгүй хэрэглээний хор уршгийг тодорхойлдог болно.

№	Суралцахуйн үр дүн	Суралцахуйн үр дүнгийн шалгуур
1	Сурагч энэ нэгжийг үзсэний дараа дэлгэцийн донтолт, түүний үр дагаврыг шүүн хэлэлцэх замаар цахим хэрэгслийг зөв тохируулан хэрэглэдэг болно.	Хувь хүний эрүүл мэндэд цахим донтолтын үзүүлэх сөрөг нөлөөг үндэслэн түүнээс татгалзах аргуудыг тодорхойлдог.
2	Сурагч энэ нэгжийг үзсэний дараа эмийн гаж нөлөө, түүний үр дагаврын баримтад үндэслэн эмийн зохисгүй хэрэглээний хор уршгийг тодорхойлдог болно.	Хүний эрүүл мэндэд эмийг эмчийн заавраар болон дур мэдэн хэрэглэснээр гарах нөлөөг тайлбарладаг.

Гүйцэтгэлийн түвшин

Суралцахуйн үр дүнгийн шалгуур	Гүйцэтгэлийн түвшин			
	I	II	III	IV
Хувь хүний эрүүл мэндэд цахим донтолтын үзүүлэх сөрөг нөлөөг үндэслэн түүнээс татгалзах аргуудыг тодорхойлдог.	Цахим хэрэгслийн давуу, сул талыг нэрлэдэг.	Цахим донтолтын үед бие махбод, сэтгэл зүйд гарах өөрчлөлтийг тайлбарладаг.	Цахим донтолтоос татгалзах аргуудыг жишээ баримт дээр үндэслэн тодорхойлдог.	Эцэг эх, гэр бүлийн бусад гишүүдийн цахим хэрэглээ зохистой эсэхэд дүгнэлт хийж, зөв зохистой хэрэглээг тэдэнд тайлбарлах

Хүний эрүүл мэндэд эмийг эмчийн заавраар болон дур мэдэн хэрэглэснээр гарах нөлөөг тайлбарладаг	Эмийг эмчийн заавраар хэрэглэхийн ач холбогдлыг тайлбарладаг.	Эмийг эмчийн зааврын дагуу болон дур мэдэн хэрэглэснээс гарах үр дагаврыг эх сурвалж ашиглан тайлбарладаг	Эмийн зөв хэрэглээг хэвшүүлэхэд эмч, эмийн санч, эцэг эх, өөрийн үүрэг оролцоог ялган эмийн гаж нөлөөнөөс болж биед учрах нөлөөг бусдад тайлбарладаг.	Эм уухгүйгээр дасгал хөдөлгөөн, амин дэмээр баялаг хоол хүнс зэргээр дархлаагаа дэмжих талаар бусдад таниулан сурталчилдаг.
---	---	---	---	---

Үнэлгээний нэгж 5. Бэлгийн болон нөхөн үржихүйн эрүүл мэнд

№	Суралцахуйн зорилт	Суралцахуйн үр дүн
1	6,05.а. Эрүүл ба эрүүл бус харилцаа холбооны шинжийг ялгах, үе тэнгийнхний дарамт шахалтыг шийдвэрлэх талаар дүрийн тоглолт хийж үзүүлэх, үерхэл нөхөрлөл, хайраа илэрхийлэх арга замыг тусган харуулах	Сурагч өгсөн нөхцөлийг ашиглан найз нөхдийн хүрээнд үерхэл нөхөрлөл, хайраа тодорхой, хэрхэн үр дүнтэй илэрхийлэхийг үзүүлнэ. Сурагч бодит жишээн дээр дүн шинжилгээ хийх замаар үе тэнгийнхний дарамт шахалт, ялгаварлан гадуурхалт, жендэрийн хэвшмэл ойлголтын сөрөг үр дагаврыг оновчтой тодорхойлж чаддаг болно.
2	6,05.б. Гутаан доромжлол, ялгаварлан гадуурхалтыг тайлбарлаж, тэдгээрийн сөрөг үр дагаврыг тодорхойлох; бүх хүн өвөрмөц бөгөөд үнэ цэнэтэй учраас хүндэтгэлтэй хандах хэрэгтэй гэдгийг хүлээн зөвшөөрөх	
3	6,05.в. Жендэрийн хэм хэмжээ ба хэвшмэл ойлголт, тэдгээрийн үр дагаварт дүн шинжилгээ хийх	

№	Суралцахуйн үр дүн	Суралцахуйн үр дүнгийн шалгуур
1	Сурагч өгсөн нөхцөлийг ашиглан найз нөхдийн хүрээнд үерхэл нөхөрлөл, хайраа тодорхой, хэрхэн үр дүнтэй илэрхийлэхийг үзүүлнэ.	Үерхэл нөхөрлөл, хайраа үгээр болон үйлдлээр оновчтой илэрхийлдэг.
2	Сурагч бодит жишээн дээр дүн шинжилгээ хийх замаар үе тэнгийнхний дарамт шахалт, ялгаварлан гадуурхалт, жендэрийн хэвшмэл ойлголтын сөрөг үр дагаврыг оновчтой тодорхойлж чаддаг болно.	Үе тэнгийнхний дарамт шахалт, ялгаварлан гадуурхалтын сөрөг үр дагаврыг тайлбарладаг. Жендэрийн хэвшмэл ойлголтын сөрөг үр дагаврыг тодорхойлдог.

Гүйцэтгэлийн түвшин

Суралцахуйн үр дүнгийн шалгуур	Гүйцэтгэлийн түвшин			
	I	II	III	IV
Сурагч ахуйн осол, гэмтлийн үед яаралтай тусламжийг үзүүлэхийн ач холбогдлыг тайлбарладаг.	Ахуйн болон гэнэтийн осол гэмтлийн жагсаалт гарган бичдэг.	Ахуйн осол гарахад нөлөөлдөг хүчин зүйлүүд, шалтгаан, үр дагаврыг судалж эх сурвалж ашиглан тайлбарладаг.	Гал гарах, тог, цахилгаанд цохиулах үед орчноо үнэлж дүгнэдэг.	Шаардлагатай тохиолдолд бусдад анхны тусламж үзүүлэх, нэн түрүүнд юу хийх талаар төлөвлөгөө боловсруулдаг.
Үерхэл нөхөрлөл, хайраа үгээр болон үйлдлээр оновчтой, илэрхийлдэг.	Үерхэл нөхөрлөл, хайраа үгээр болон үйлдлээр зохистой илэрхийлэх аргыг хэлдэг.	Үерхэл нөхөрлөл, хайраа зааварт тусгасны дагуу үгээр болон үйлдлээр илэрхийлдэг.	Өгөгдсөн нөхцөлд үерхэл нөхөрлөл, хайраа үгээр болон үйлдлээр илэрхийлдэг.	Ямар ч нөхцөлд үерхэл нөхөрлөл, хайраа үгээр болон үйлдлээр үр дүнтэй илэрхийлдэг.

ХИЧЭЭЛ, СУРГАЛТЫН ҮР ДҮНГ ҮНЭЛЭХ ШАЛГУУР

Үе тэнгийнхний дарамт шахалт, ялгаварлан гадуурхалтын сөрөг үр дагаврыг тайлбарладаг.	Үе тэнгийнхний дарамт шахалт, ялгаварлан гадуурхалтын хувь хүнд үзүүлэх сөрөг үр дагаврыг нэрлэж, жишээ гаргадаг.	Үе тэнгийнхний дарамт шахалт, ялгаварлан гадуурхалтын хувь хүнд үзүүлэх сөрөг үр дагаврыг бодит жишээн дээр тайлбарладаг.	Үе тэнгийнхний дарамт шахалт, ялгаварлан гадуурхалтын хувь хүн, гэр бүл, нийгэмд үзүүлэх сөрөг үр дагаврыг задлан шинжилж, тайлбарладаг.	Үе тэнгийнхний дарамт шахалт, ялгаварлан гадуурхалтын бүх түвшинд үзүүлэх сөрөг үр дагаврын уялдаа холбоог гарган тайлбарладаг.
Жендэрийн хэвшмэл ойлголтын сөрөг үр дагаврыг тодорхойлдог.	Жендэрийн хэвшмэл ойлголтын хувь хүнд үзүүлэх сөрөг үр дагаврыг нэрлэж, жишээ гарган тодорхойлдог.	Жендэрийн хэвшмэл ойлголтын хувь хүн, гэр бүлд үзүүлэх сөрөг үр дагаврыг бодит жишээн дээр дүн шинжилгээ хийж тодорхойлдог.	Жендэрийн хэвшмэл ойлголтын хувь хүн, гэр бүл, нийгэмд үзүүлэх сөрөг үр дагаврыг задлан шинжилж, тодорхойлдог.	Жендэрийн хэвшмэл ойлголтын бүхий л түвшинд үзүүлэх сөрөг үр дагаврын уялдаа холбоог гарган задлан шинжилж, тодорхойлдог.

Үнэлгээний нэгж 6. Аюулгүй байдал, анхны тусламж

№	Суралцахуйн зорилт	Суралцахуйн үр дүн
1	6.06.а. Гэртээ болон хичээлээс гадуурх үйл ажиллагааны үед тохиолдож болох аюул эрсдлээс өөрийгөө болон бусдыг хамгаалах	Сурагч гэртээ болон хичээлээс гадуурх үйл ажиллагааны үед тохиолдож болох аюул эрсдэлийг таамаглаж түүнээс хамгаалах арга замуудыг тодорхойлдог болно.

№	Суралцахуйн үр дүн	Суралцахуйн үр дүнгийн шалгуур
1	Сурагч гэртээ болон хичээлээс гадуурх үйл ажиллагааны үед тохиолдож болох аюул эрсдэлийг таамаглаж түүнээс хамгаалах арга замуудыг тодорхойлдог болно.	Сурагч ахуйн осол, гэмтлийн үед яаралтай тусламжийг үзүүлэхийн ач холбогдлыг тайлбарладаг.

Гүйцэтгэлийн түвшин

Суралцахуйн үр дүнгийн шалгуур	Гүйцэтгэлийн түвшин			
	I	II	III	IV
Сурагч ахуйн осол, гэмтлийн үед яаралтай тусламжийг үзүүлэхийн ач холбогдлыг тайлбарладаг.	Ахуйн болон гэнэтийн осол гэмтлийн жагсаалт гарган бичдэг.	Ахуйн осол гарахад нөлөөлдөг хүчин зүйлүүд, шалтгаан, үр дагаврыг судалж эх сурвалж ашиглан тайлбарладаг.	Гал гарах, тог, цахилгаанд цохиулах үед орчноо үнэлж дүгнэдэг.	Шаардлагатай тохиолдолд бусдад анхны тусламж үзүүлэх, нэн түрүүнд юу хийх талаар төлөвлөгөө боловсруулдаг.

ХОЁРДУГААР БҮЛЭГ. VII АНГИ

2.1. VII АНГИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ХИЧЭЭЛИЙН СУРАЛЦАХУЙН ҮР ДҮН

Үнэлгээний зорилт	Суралцахуйн үр дүн
Мэдлэг ойлголт	Хүүхдийн хувцасны эрүүл ахуйн шаардлага, дотуур хувцас болон биеийн тамирын хувцасны эрүүл ахуй, охид, хөвгүүдийн бэлгийн бойжилтын үеийн эрүүл ахуйн дэглэмийн талаар мэдлэгтэй болно. Хоолны “Гэр зөвлөмж”, хооллох нэгжийн талаар ойлголттой болно. Өөртөө итгэлтэй харилцахын давуу талыг мэддэг болно. Архи болон тамхины найрлага, тэдгээрийн бие бялдрын өсөлт, гоо сайханд үзүүлэх сөрөг нөлөөний талаар мэдлэгтэй болно. Бэлгийн амьдрал, түүний бүрэлдэхүүн хэсэг, жирэмсний шинж тэмдэг, ургийн хөгжлийн шатыг тайлбарлаж чаддаг болно. Сургууль дээр хичээлийн хэрэгсэл, багаж төхөөрөмжтэй ажиллах аюулгүй ажиллагааны дүрмийн талаар мэдлэгтэй болно.
Чадвар	Хувцасны болон охид, хөвгүүдийн бэлгийн бойжилтын үеийн эрүүл ахуйн дэглэмийг сахих чадвартай болно. Хоол хүнсэнд агуулагдах бичил шимт бодисын ач холбогдлыг мэдсэнээр хоол хүнсээ тохируулан, аюулгүй зөв хэрэглэдэг болно. Бусдад халамж анхаарал тавьж байгаагаа үгээр, үйлдлээр тодорхой илэрхийлж, өөртөө итгэлтэй, үр дүнтэй харилцаж чаддаг болно. Архи тамхины хор нөлөөг ухамсарлан түүнээс зайлсхийх, эергээр татгалзах чадвар эзэмшинэ. Хайр, үерхэл нөхөрлөл, шохоорлолтой холбоотой сэтгэл хөдлөлөө ялгаж, зохицуулж чаддаг болно. Хүчирхийллийн үр дагаврыг тодорхойлж, бусдад тайлбарлаж чаддаг болно. Сургууль болон олон нийтийн газар аюулгүй байдлаа хангахын ач холбогдлыг ухаарч хэрэгжүүлэх чадвар эзэмшинэ.
Хандлага	Хувцасны болон охид, хөвгүүдийн бэлгийн бойжилтын үеийн эрүүл ахуйн дэглэмийг сахиж, охид ариун цэврийн хэрэглэлийг зөв сонгож, хэрэглэдэг болно. Хөдөлгөөний хомсдолын сөрөг нөлөөг ухаарч дасгал хөдөлгөөн тогмол хийдэг болно. Бусдад анхаарал халамж хэрэгтэй нөхцөл байдалд мэдрэмжтэй ханддаг болно. Архи тамхины сөрөг нөлөөг ухамсарлах, бусдад нөлөөлөх хандлага бий болно. Хүчирхийллийн үед бусдаас тусламж авах нь чухал, хүчирхийллийг бууруулж, таслан зогсооход хүн бүр хувь нэмэр оруулах хэрэгтэйг ухаарна. Олон нийтийн газар биеэ зөв авч явах, аливаа эрсдэлээс өөрийгөө болон бусдыг хамгаалах хандлагатай болно.

Үнэлгээний нэгж 1. Хувийн эрүүл ахуй ба орчны эрүүл мэнд

№	Суралцахуйн зорилт	Суралцахуйн үр дүн
1	7,01.а. Бэлгийн бойжилтын үеийн бэлгэ эрхтний ариун цэвэр, эрүүл ахуйн дэглэм, түүнийг сахихын ач холбогдлыг тайлбарлах	Сурагч бэлгийн бойжилтын үеийн бэлгэ эрхтний ариун цэвэр, эрүүл ахуйн дэглэм сахихын ач холбогдлыг тайлбарладаг болно.
2	7,01.б. Хувийн эрүүл ахуйг сахих талаар аав, ээж, асран хамгаалагчид болон сургуулийн багш, захирал нарт хүсэлт бичих	Сурагч хувийн эрүүл ахуйг сахихад эцэг эх, асран хамгаалагчид болон сургуулийн үүрэг, оролцоог тодорхойлдог болно.

ХИЧЭЭЛ, СУРГАЛТЫН ҮР ДҮНГ ҮНЭЛЭХ ШАЛГУУР

№	Суралцахуйн үр дүн	Суралцахуйн үр дүнгийн шалгуур
1	Сурагч бэлгийн бойжилтын үеийн бэлгэ эрхтний ариун цэвэр, эрүүл ахуйн дэглэм сахихын ач холбогдлыг тайлбарладаг болно.	Сурагч шилжилтийн насны үеийн охид, хөвгүүдийн бэлгийн бойжилтын үеийн эрүүл ахуйн дэглэмийн онцлогийг тайлбарладаг.
2	Сурагч хувийн эрүүл ахуйг сахихад эцэг эх, асран хамгаалагчид болон сургуулийн үүрэг, оролцоог тодорхойлдог болно.	Сурагч хувийн эрүүл ахуйг сахихад эцэг эх, асран хамгаалагч болон сургуулийн багш, удирдлагуудын үүрэг оролцоог тайлбарладаг.

Гүйцэтгэлийн түвшин

Суралцахуйн үр дүнгийн шалгуур	Гүйцэтгэлийн түвшин			
	I	II	III	IV
Сурагч шилжилтийн насны үеийн охид, хөвгүүдийн бэлгийн бойжилтын үеийн эрүүл ахуйн дэглэмийн онцлогийг тайлбарладаг.	Охид, хөвгүүдийн хувийн эрүүл ахуйн дэглэмийн онцлог, ялгааг жагсааж бичдэг.	Бэлгийн бойжилтын үеийн эрүүл ахуйн дэглэмийг сахихын ач холбогдлыг судалж үнэлдэг.	Бэлгийн бойжилтын үеийн эрүүл ахуйн дэглэмийг сахихгүйгээс гарах сөрөг үр дагаврыг шүүн хэлэлцдэг.	Охид, хөвгүүдийн бэлгийн бойжилтын үеийн бэлгэ эрхтний ариун цэвэр, эрүүл ахуйн дэглэмийн талаар зөвлөмж бичдэг.
Сурагч хувийн эрүүл ахуйг сахихад эцэг эх, асран хамгаалагч болон сургуулийн багш, удирдлагуудын үүрэг оролцоог тайлбарладаг.	Хувийн эрүүл ахуйг сахихад эцэг, эх, асран хамгаалагч болон сургуулийн багш, удирдлагуудын үүрэг оролцоог тоочдог.	Хувийн эрүүл ахуйг сахихад эцэг, эх, асран хамгаалагч болон сургуулийн багш, удирдлагуудад эх сурвалж ашиглан хүсэлт бичиж, танилцуулдаг.	Хувийн эрүүл ахуйг сахихад эцэг, эх, асран хамгаалагч болон багш, удирдлагуудын үүрэг оролцоог судалж өөрийн үзэл бодлоо илэрхийлэн шийдвэрлэдэг.	Хувийн эрүүл ахуйг дэмжихэд эцэг, эх, асран хамгаалагч болон багш, сургуулийн удирдлагуудын оролцоо түүний ач холбогдлыг бусдад сурталчилдаг.

Үнэлгээний нэгж 2. Хооллолт ба хөдөлгөөн

№	Суралцахуйн зорилт	Суралцахуйн үр дүн
1	7,02.а. “Гэр зөвлөмж”-ийн дагуу хооллох нэгжийг харгалзан, хоолны дэглэм зохион хэрэгжүүлэх	Сурагч энэ нэгжийг үзсэний дараа эрүүл мэндийн эрсдэл, хөдөлгөөний хомсдол зэргээс сэргийлэх зорилгоор зөвлөмжийн дагуу хоол хүнс, болон дасгал хөдөлгөөнийг тохируулан хэрэглэдэг болно.
2	7.02б. Хүнсний эрүүл ахуйн шаардлагыг мэдэж, хоол, хүнсээр дамжин халдварлах өвчин болон хоолны хордлогоос сэргийлэх	
3	7,02.в. Хөдөлгөөний хомсдолоос сэргийлж, дасгал хийхэд амин дэм, эрдсийг тохиромжтой хэмжээгээр зөвлөмжийн дагуу хэрэглэх	

№	Суралцахуйн үр дүн	Суралцахуйн үр дүнгийн шалгуур
1	Сурагч энэ нэгжийг үзсэний дараа эрүүл мэндийн эрсдэл, хөдөлгөөний хомсдол зэргээс сэргийлэх зорилгоор зөвлөмжийн дагуу хоол хүнс, болон дасгал хөдөлгөөнийг тохируулан хэрэглэдэг болно.	Гэр зөвлөмжийн дагуу хооллох нэгжийг үндэслэн хоногт болон дасгал хөдөлгөөний үед шимт бодис, амин дэм, эрдсийг тохиромжтой хэмжээгээр хэрэглэхийн ач холбогдлыг тайлбарладаг.
2		Хүнсний эрүүл ахуйн шаардлага хангахгүйн улмаас хоолны хордлого, хоол хүнсээр дамжих халдварт өвчин үүсдэг болохыг жишээ баримтад үндэслэн тодорхойлдог.

Гүйцэтгэлийн түвшин

Суралцахуйн үр дүнгийн шалгуур	Гүйцэтгэлийн түвшин			
	I	II	III	IV
1а. “Гэр” зөвлөмжийн дагуу хооллох нэгжийг үндэслэн хоногт болон дасгал хөдөлгөөний үед шимт бодис, амин дэм, эрдсийг тохиромжтой хэмжээгээр хэрэглэхийн ач холбогдлыг тайлбарладаг.	“Гэр” зөвлөмж дэх хүнсний бүлгүүдийг зурагт үзүүлэн ашиглан ялган тайлбарладаг.	“Гэр” зөвлөмжийн дагуу өөрсдийн хоол хүнсэндээ амин дэмүүд, эрдсийн эх үүсвэр болсон хүнсийг хэрэглэж байгаа эсэх талаар эх сурвалж ашиглан тайлбарладаг.	Хоол хүнсийг нэгж хэмжээнд дүйцүүлэн хэрэглэснээр хоногт болон дасгал хөдөлгөөний үед хэрэглэх шимт бодис, амин дэм, эрдсийг ямар хоол хүнснээс авч болох талаар жишээ баримтад үндэслэн тайлбарладаг.	Хоногт болон дасгал хөдөлгөөний үед хоол хүнсээр авах шимт бодис, амин дэм, эрдсийн зохистой харьцаа алдагдсан үед өвчин эмгэгт хүргэж болох, түүнээс сэргийлэх арга замыг бусдад таниулдаг.
1б. Хүнсний эрүүл ахуйн шаардлага хангахгүйн улмаас хоолны хордлого, хоол хүнсээр дамжих халдварт өвчин үүсдэг болохыг жишээ баримтад үндэслэн тодорхойлдог.	Хоол хүнсээр дамжин халдварлах өвчнүүдийг нэрлэдэг.	Хоол хүнсээр дамжин халдварлах өвчний үүсэх шалтгаан, нөхцөл, илрэх шинж тэмдгийг тодорхойлдог.	Хоол хүнсээр дамжин халдварлах өвчин, хоолны хордлогоос сэргийлэх арга замуудыг хадгалалт, боловсруулалт, хувийн эрүүл ахуйн шаардлагыг үндэслэн тайлбарладаг.	Хоолны хордлогын үед үзүүлэх анхны тусламжийн зарчим, аргачлалыг хялбаршуулсан зөвлөмж хэлбэрээр боловсруулдаг.

Үнэлгээний нэгж 3. Сэтгэцийн эрүүл мэнд

№	Суралцахуйн зорилт	Суралцахуйн үр дүн
1	7,03.а. Өөртөө итгэлтэйгээр бусадтай эерэг харилцах	Сурагч бусадтай харилцахдаа өөртөө итгэлтэй байх ба анхаарал халамж тавьж байгаагаа үг, үйлдлээрээ оновчтой харуулдаг болно.
2	7,03.б. Бусдад анхаарал халамж тавьж буйгаа үгээр болон үйлдлээр илэрхийлэх	

№	Суралцахуйн үр дүн	Суралцахуйн үр дүнгийн шалгуур
1	Сурагч бусадтай харилцахдаа өөртөө итгэлтэй байх ба анхаарал халамж тавьж байгаагаа үг, үйлдлээрээ оновчтой харуулдаг болно.	- Өөртэй итгэлтэй харилцааг үгэн ба үгэн бус хэлбэрийг хослуулан илэрхийлдэг. - Бусдад анхаарал халамж тавьж байгаагаа илэрхийлэх үг хэллэг, үйлдэл хийдэг.

Гүйцэтгэлийн түвшин

Суралцахуйн үр дүнгийн шалгуур	Гүйцэтгэлийн түвшин			
	I	II	III	IV
Өөртөө итгэлтэй харилцаж байгааг илэрхийлэх үг хэллэг, дохио зангаа, биеийн хөдөлгөөн, нүүрний хувирал, дуу хоолойны өнгийг оновчтой хослуулан хэрэглэдэг.	Өгсөн нөхцөлд нүдний харц, дуу хоолойны өнгө, дохио зангаа, биеийн хөдөлгөөн, үгийн сонголт нь хоорондоо сайн нийцэхгүй	Өгсөн нөхцөлд нүдний харц, дуу хоолойны өнгө, дохио зангаа, биеийн хөдөлгөөн, үгийн сонголтыг нийцүүлэн илэрхийлэх оролдлого хийдэг.	Өгсөн нөхцөлд нүдний харц, дуу хоолойны өнгө, дохио зангаа, биеийн хөдөлгөөн, үгийн сонголтыг нийцүүлэн өөртөө итгэлтэйгээр хослуулан илэрхийлэхийг хичээдэг.	Ямар ч нөхцөлд нүдний харц, дуу хоолойны өнгө, дохио зангаа, биеийн хөдөлгөөн, үгийн сонголтыг нийцүүлэн өөртөө итгэлтэйгээр хослуулан илэрхийлдэг.

ХИЧЭЭЛ, СУРГАЛТЫН ҮР ДҮНГ ҮНЭЛЭХ ШАЛГУУР

Бусдад анхаарал халамж тавих үг хэллэг эсвэл үйлдлийг нөхцөлд нь тохируулан оновчтой хэрэглэдэг.	Өгсөн нөхцөлд бусдад анхаарал халамж тавих ганц нэг үг хэлдэг.	Өгсөн нөхцөлд бусдад анхаарал халамж тавих үг хэллэг, үйлдлийг хэрэглэх оролдлого хийдэг.	Бусдад анхаарал халамж тавих үг хэллэг, үйлдлийг өгсөн нөхцөлд тохируулан хийдэг.	Янз бүрийн нөхцөлд бусдад анхаарал халамж тавих үг хэллэг, үйлдлийг чөлөөтэй хэрэглэж ашигладаг.
--	--	---	---	--

Үнэлгээний нэгж 4. Хорт зуршил

№	Суралцахуйн зорилт	Суралцахуйн үр дүн
1	7,04.а. Бие бялдын өсөлт хөгжил, гоо сайханд архи, тамхи нөлөөлдөг болохыг тодорхойлох	Сурагч энэ нэгжийг үзсэний дараа архи тамхины сөрөг үр дагаврын талаарх баримтад үндэслэн хүний биеийн өсөлт, гоо сайханд үзүүлэх хор уршгийг тодорхойлдог болно.
2	7,04.б. Архи, тамхи хэрэглэхээс эелдгээр татгалзах	

№	Суралцахуйн үр дүн	Суралцахуйн үр дүнгийн шалгуур
1	Сурагч энэ нэгжийг үзсэний дараа архи, тамхины сөрөг үр дагаврын талаарх баримтад үндэслэн хүний биеийн өсөлт, гоо сайханд үзүүлэх хор уршгийг тодорхойлдог болно.	Архи тамхины найрлага, биеийн өсөлт, хөгжил, гоо сайханд үзүүлэх сөрөг нөлөөг тайлбарладаг.

Гүйцэтгэлийн түвшин

Суралцахуйн үр дүнгийн шалгуур	Гүйцэтгэлийн түвшин			
	I	II	III	IV
Архи тамхины найрлага, биеийн өсөлт, хөгжил, гоо сайханд үзүүлэх сөрөг нөлөөг тайлбарладаг.	Архи, тамхинд агуулагдах бодисууд хүний биед ямар сөрөг нөлөө үзүүлдэг болохыг нэрлэдэг.	Архи, тамхины хүний биеийн өсөлт, гоо сайханд үзүүлэх урт, богино хугацааны нөлөөг харьцуулан дүгнэлт гаргадаг.	Архи тамхи хүний эрхтнүүдийг гэмтээж ямар өвчин үүсгэдэг, гоо сайхан, гадаад үзэмжид хэрхэн нөлөөлдөг болохыг жишээ баримтад үндэслэн тайлбарладаг.	Архи тамхины хүний биеийн өсөлт болон гоо сайхан үзүүлэх сөрөг нөлөөг үндэслэн татгалзах арга замыг бусдад зөвлөдөг.

Үнэлгээний нэгж 5. Бэлгийн болон нөхөн үржихүйн эрүүл мэнд

№	Суралцахуйн зорилт	Суралцахуйн үр дүн
1	7,05.а. Бэлгийн амьдрал нь хүний амьдралын салшгүй хэсэг бөгөөд хүйс, соёл, шашин нөлөөлдөг болохыг таних	- Хүний бэлгийн амьдралын бүрэлдэхүүн хэсэг, бэлгийн амьдралд нөлөөлөх зүйлийг зөв ялган тодорхойлж чаддаг болно. - Үр тогтолт, жирэмслэлт, ургийн хөгжлийн үе шатыг шинжлэх ухааны нэр томъёо ашиглан зөв тайлбарлаж чаддаг болно. - Үерхэл нөхөрлөл, хайр, шохоорхлын үед илрэх сэтгэл хөдлөлийг үр дүнтэй зохицуулж чаддаг болно. - Янз бүрийн нөхцөлд үйлдэгдэх хүчирхийллийн хэлбэр, үр дагаврыг өгсөн нөхцөлийн хүрээнд тодорхойлж чаддаг болно.
2	7,05.б. Нөхөн үржихүйн үйл явц, жирэмслэлт нь бэлгийн хавьтлын үр дүн болохыг ойлгож, жирэмсний шинж тэмдэг болон ургийн хөгжлийн үе шатыг тайлбарлах	
3	7,05.в. Үерхэл нөхөрлөл, дотно харилцаа хэрхэн бий болдгийг тайлбарлах; хайр, үерхэл нөхөрлөл, шохоорхолтой холбоотой сэтгэл хөдлөлийг ялгаж, түүнийг зохицуулах аргыг жишээгээр үзүүлэх	
4	7,05.г. Хүчирхийлэл нь хүний эрхийн зөрчил, хууль бус, буруу зүйл болохыг таньж мэдэх, дотно харилцаа бүхий хүмүүсийн хооронд үйлдэгддэг хүчирхийллийн хэлбэр, үр дагаврыг тодорхойлж, түүнтэй холбоотой өөрийн туршлага, үнэт зүйлийн талаар эргэцүүлэх	

№	Суралцахуйн үр дүн	Суралцахуйн үр дүнгийн шалгуур
1	Хүний бэлгийн амьдралын бүрэлдэхүүн хэсэг, бэлгийн амьдралд нөлөөлөх зүйлийг зөв ялган тодорхойлж чаддаг болно.	- Хүний бэлгийн амьдралын бүрэлдэхүүн хэсэг тус бүрт хамаарагдах зүйлсийг ангилан тодорхойлдог - Бэлгийн амьдралд нийгэм, соёл, шашны үзүүлэх нөлөөг ялган тодорхойлдог.
2	Үр тогтолт, жирэмслэлт, ургийн хөгжлийн үе шатыг шинжлэх ухааны нэр томьёо, үг хэллэг ашиглан зөв тайлбарлаж чаддаг болно.	Үр тогтох үйл явц, жирэмсний шинж тэмдэг, ургийн хөгжлийн үе шатыг шинжлэх ухааны нэр томьёо, үг хэллэг ашиглан зөв тайлбарладаг.
3	Үерхэл нөхөрлөл, хайр, шохоорхлын үед илрэх сэтгэл хөдлөлийг үр дүнтэй зохицуулж чаддаг болно.	- Үерхэл нөхөрлөл, хайр, шохоорхлыг ялгадаг - Хайр, шохоорхлын үеийн сэтгэл хөдлөлөө зохицуулдаг.
4	Янз бүрийн нөхцөлд үйлдэгдэх хүчирхийллийн хэлбэр, үр дагаврыг өгсөн нөхцөлийн хүрээнд тодорхойлж чаддаг болно.	Хүчирхийллийн хэлбэр, үр дагаврыг тодорхойлдог.

Гүйцэтгэлийн түвшин

Суралцахуйн үр дүнгийн шалгуур	Гүйцэтгэлийн түвшин			
	I	II	III	IV
Хүний бэлгийн амьдралын бүрэлдэхүүн хэсэг тус бүр хамаарагдах зүйлсийг ангилан тодорхойлдог.	Хүний бэлгийн амьдралын 5 бүрэлдэхүүн хэсэг болон түүнд хамаарагдах зүйлсээс жишээлэн нэрлэдэг.	Хүний бэлгийн амьдралын 5 бүрэлдэхүүн хэсэг ба хамаарагдах зүйлсийг ангилан тодорхойлохыг оролддог.	Хүний бэлгийн амьдралын 5 бүрэлдэхүүн хэсгийг тайлбарлаж, тус бүрт хамаарагдах зүйлсийг зөв ангилан тодорхойлдог.	Хүний бэлгийн амьдралын 5 бүрэлдэхүүн хэсгийг тайлбарлаж, тус бүрт хамаарагдах зүйлсийг зөв ангилан жишээ баримт гарган тайлбарладаг.
Бэлгийн амьдралд нийгэм, соёл, шашны үзүүлэх нөлөөг ялган тодорхойлдог.	Нийгэм, соёл, шашны үзүүлэх нөлөөг бэлгийн амьдралын 1-2 асуудлын хүрээнд жишээгээр хэлдэг.	Нийгэм, соёл, шашны үзүүлэх эерэг, сөрөг нөлөөг бэлгийн амьдралын 2-3 асуудлын хүрээнд тодорхойлохыг оролддог.	Нийгэм, соёл, шашны үзүүлэх эерэг, сөрөг нөлөөг бэлгийн амьдралын олон асуудал дээр жишээ гарган тодорхойлдог.	Нийгэм, соёл, шашны үзүүлэх эерэг, сөрөг нөлөө, гарах үр дагаврыг бэлгийн амьдралын олон асуудал дээр үндэслэл нотолгоотой тодорхойлдог.
Үр тогтох үйл явц, жирэмсний шинж тэмдэг, ургийн хөгжлийн үе шатыг шинжлэх ухааны нэр томьёо, үг хэллэг ашиглан зөв тайлбарладаг.	Үр тогтох үйл явц, жирэмсний эрт үед илрэх шинж тэмдэг, ургийн хөгжлийн үе шатыг энгийн үг хэллэг ашиглан нэрлэдэг.	Үр тогтох үйл явц, жирэмсний эрт үед илрэх шинж тэмдэг, ургийн хөгжлийн үе шатыг шинжлэх ухааны зарим нэр томьёо ашиглан тайлбарлахыг оролддог.	Үр тогтох үйл явц, жирэмсний эрт үед илрэх шинж тэмдэг, ургийн хөгжлийн үе шатыг шинжлэх ухааны ихэнх нэр томьёог зөв ашиглан тайлбарладаг.	Үр тогтох үйл явцыг схемчлэн, жирэмсний эрт үед илрэх шинж тэмдэг, ургийн хөгжлийн үе шатын онцлогийг шинжлэх ухааны нэр томьёо ашиглан бүрэн гүйцэд, зөв тайлбарладаг.
Үерхэл нөхөрлөл, хайр, шохоорхлыг ялгадаг.	Үерхэл нөхөрлөл, хайр, шохоорхлын ганц нэг жишээ хэлдэг.	Үерхэл нөхөрлөл, хайр, шохоорхлыг жишээ гарган ялгах оролдлого хийдэг.	Үерхэл нөхөрлөл, хайр, шохоорхол тус бүрийн мөн чанарыг тайлбарлаж ялгадаг.	Үерхэл нөхөрлөл, хайр, шохоорхол тус бүрийн мөн чанарыг тодорхой гаргаж, бодит жишээ, үндэслэл дээр тулгуурлан ялгадаг.

ХИЧЭЭЛ, СУРГАЛТЫН ҮР ДҮНГ ҮНЭЛЭХ ШАЛГУУР

Хайр, шохоорхлын үеийн сэтгэл хөдлөлөө зохицуулдаг.	Хайр, шохоорхлын үеийн сэтгэл хөдлөлийг хэрхэн зохицуулах талаар тайлбарладаг.	Хайр, шохоорхлын үеийн сэтгэл хөдлөлийг ялган зохицуулах оролдлого хийдэг.	Хайр, шохоорхлын үеийн сэтгэл хөдлөлийг ялган 1-2 тодорхой алхам хийдэг.	Хайр, шохоорхлын үеийн сэтгэл хөдлөлийг ялган нөхцөл байдалд тохируулан зохицуулах үр дүнтэй арга хэрэглэдэг.
Хүчирхийллийн хэлбэр, үр дагаврыг тодорхойлдог.	Хүчирхийллийн 1-2 хэлбэр, хувь хүнд гарах ганц нэг үр дагаврыг тодорхойлдог.	Хүчирхийллийн 2-3 хэлбэр, хувь хүн, гэр бүлд гарах үр дагаврыг тодорхойлдог.	Хүчирхийллийн 3-4 хэлбэр, хувь хүн, гэр бүл, олон нийтийн хүрээнд гарах үр дагаврыг тодорхойлдог.	Хүчирхийллийн бүх хэлбэр, хувь хүн, гэр бүл, олон нийт, нийгэмд гарах үр дагаврыг нотолгоонд суурилан тодорхойлдог.

Үнэлгээний нэгж 6. Аюулгүй байдал, анхны тусламж

№	Суралцахуйн зорилт	Суралцахуйн үр дүн
1	7.06.а. Сургуулийн орчинд (туршилт хичээл, завсарлагааны үеэр) болон нийтийн тээврээр зорчих үеийн эрсдэлээс сэргийлж, шаардлагатай тохиолдолд анхны тусламж үзүүлэх	Сурагч сургуулийн орчинд болон нийтийн тээврээр зорчих үеийн эрсдэлийг тодорхойлж, шаардлагатай тохиолдолд анхны тусламж үзүүлэхийн ач холбогдлыг тайлбарладаг болно.

№	Суралцахуйн үр дүн	Суралцахуйн үр дүнгийн шалгуур
1	Сурагч сургуулийн орчинд болон нийтийн тээврээр зорчих үеийн эрсдэлийг тодорхойлж, шаардлагатай тохиолдолд анхны тусламж үзүүлэхийн ач холбогдлыг тайлбарладаг.	Сурагч шаардлагатай тохиолдолд анхны тусламжийн тохирох аргыг зөв сонгож, гүйцэтгэдэг.

Гүйцэтгэлийн түвшин

Суралцахуйн үр дүнгийн шалгуур	Гүйцэтгэлийн түвшин			
	I	II	III	IV
Сурагч шаардлагатай тохиолдолд анхны тусламжийн тохирох аргыг зөв сонгож, гүйцэтгэдэг.	Сургуулийн орчинд хийх туршилтын хичээл, завсарлагааны үед болон нийтийн тээврээр зорчих үед гардаг эрсдлийг тоочдог.	Сургуулийн орчинд хийх туршилтын хичээл, завсарлагааны үед болон нийтийн тээврээр зорчих үед эрсдэлд хүргэдэг хүчин зүйлүүд, шалтгаан, үр дагаврыг тодорхойлдог.	Сургуулийн орчинд хийх туршилтын хичээл, завсарлагааны үед болон нийтийн тээврээр зорчих үед гарах эрсдлийг үнэлж, анхны тусламжийн тохирох аргыг зөв сонгож гүйцэтгэдэг.	Сургуулийн орчинд туршилтын хичээл, завсарлагааны үед болон нийтийн тээврээр зорчих үед тохиолдож болох эрсдлийн талаар аюулгүй ажиллагааны зөвлөмж бичдэг.

ГУРАВДУГААР БҮЛЭГ. VIII АНГИ

3.1. VIII АНГИЙН ЭРҮҮЛИЙН МЭНДИЙН ХИЧЭЭЛИЙН СУРАЛЦАХУЙН ҮР ДҮН

Үнэлгээний зорилт	Суралцахуйн үр дүн
Мэдлэг ойлголт	- Сүрьеэ өвчин түүнээс урьдчилан сэргийлэх, дархлаажуулалт, вакцины товлолын талаар мэдлэгтэй болно. - Хоолны нэгжийг зөв тооцож гэр бүлийн гишүүддээ тохирсон хоол сонгоход тусалдаг. - Сэтгэцийн хувьд эрүүл байхын ач холбогдлыг тайлбарлаж чаддаг болно. - Архи тамхины богино ба урт хугацааны сөрөг нөлөөг харьцуулан тайлбарладаг - Бэлгийн чиг баримжаа, хүйсийн баримжаа илэрхийллийн талаар тайлбарлаж чаддаг болно. - Тэмцээн уралдааны үед зориулалтын хувцас, хэрэглэл хэрэглэхийн ач холбогдол, шаардлагатай тохиолдолд үзүүлэх анхны тусламжийн талаар мэдлэгтэй болно.
Чадвар	- Сүрьеэгийн халдвараас урьдчилан сэргийлэх, вакцинд хамрагдахын ач тусыг тайлбарлах чадвартай болно. - Өөрийн бие махбодын онцлог, насны бүлэг тохируулан хоолоо сонгож сурна. - Буруу хооллолт, хөдөлгөөний хомсдолоос үүдэлтэй таргалалт, чихрийн шижин өвчнөөс урьдчилан сэргийлэх чадвартай болно. - Асуудал бэрхшээлийн учир шалтгааныг олж, шийдвэрлэх оновчтой аргыг сонгож чаддаг болно. - Бэлгийн чиг баримжаа, хүйсийн баримжаа илэрхийллийн талаарх буруу ташаа ойлголтыг няцаадаг болно. - Тэмцээн, уралдааны үед зориулалтын хэрэгслийг зааврын дагуу зөв зохистой хэрэглэж, эрсдлээс сэргийлэх, шаардлагатай нөхцөлд өөртөө болон бусдад анхны тусламж үзүүлдэг болно.
Хандлага	- Сүрьеэгийн халдвараас урьдчилан сэргийлэх, эрүүл мэндэд үзүүлэх дархлаажуулалтын нөлөөг сурталчлах, дархлаажуулалтад тогтмол хамрагдах талаар бусдад зөвлөн туслах хандлагатай болно. - Сэтгэцийн эрүүл мэндийн янз бүрийн асуудлын үед мэргэжлийн хүнд хандах хандлагатай болно. - Дам тамхидалтаас сэргийлэх, өөрийнхөө эрүүл мэндийг хамгаалахын тулд бусдад шаардлага тавьж сурна. - Өөрийн болон бусдын бэлгийн чиг баримжаа, хүйсийн баримжаа илэрхийллийг хүлээн зөвшөөрч, хүндэтгэдэг болно. - Аливаа эрсдэлээс өөрийгөө болон бусдыг хамгаалах, анхны тусламжийг зааврын дагуу зөв хийж, өөрийн болон бусдын амь насыг аврах, бусдын сайн сайхны төлөө сайн үйлс бүтээх хандлагатай болно.

Үнэлгээний нэгж 1. Хувийн эрүүл ахуй ба орчны эрүүл мэнд

№	Суралцахуйн зорилт	Суралцахуйн үр дүн
1	8,01.а. Хувцасны төрөл, үүрэг, ач холбогдлыг мэдэх, хувцсаа төрөл зориулалтаар нь тохируулан өмсдөг байх, арчлах, хадгалах арга замыг тодорхойлох	Сурагч хувцсаа төрөл, зориулалтаар нь өөртөө тохируулан өмсдөг болно.
2	8,01.б. Сүрьеэ өвчний үүсгэгч, илрэх шинж тэмдэг, ялгаа, халдвараас урьдчилан сэргийлэх	Сурагч сүрьеэгийн халдвараас өөрийгөө болон бусдыг хамгаалах, урьдчилан сэргийлэх арга замуудыг өөрийн үгээр тайлбарладаг болно.
3	8,01.в. Дархлаажуулалтын ач холбогдлыг тодорхойлох, түүнд хамрагдахын ач тус, эрүүл мэндэд үзүүлэх нөлөөг бусдад сурталчлах	Сурагч дархлаажуулалтад хамрагдахын ач холбогдол, эрүүл мэндэд үзүүлэх нөлөөллийг зөв тодорхойлдог болно.

ХИЧЭЭЛ, СУРГАЛТЫН ҮР ДҮНГ ҮНЭЛЭХ ШАЛГУУР

№	Суралцахуйн үр дүн	Суралцахуйн үр дүнгийн шалгуур
1	Сурагч хувцсаа төрөл, зориулалтаар нь өөртөө тохируулан өмсдөг болно.	Сурагч хувцсаа төрөл, зориулалтаар нь өмсөхийн ач холбогдлыг тайлбарладаг.
2	Сурагч сүрьеэгийн халдвараас өөрийгөө болон бусдыг хамгаалах, урьдчилан сэргийлэх арга замуудыг өөрийн үгээр тайлбарладаг болно.	Сурагч сүрьеэгийн халдвараас урьдчилан сэргийлэх, өөрийгөө болон бусдыг хамгаалах арга замуудыг тайлбарладаг.
3	Сурагч дархлаажуулалтад хамрагдахын ач холбогдол, эрүүл мэндэд үзүүлэх нөлөөллийг зөв тодорхойлдог болно.	Сурагч дархлаажуулалтын эрүүл мэндэд үзүүлэх нөлөөллийг зөв тодорхойлдог болно.

Гүйцэтгэлийн түвшин

Суралцахуйн үр дүнгийн шалгуур	Гүйцэтгэлийн түвшин			
	I	II	III	IV
Сурагч хувцсаа төрөл, зориулалтаар нь өмсөхийн ач холбогдлыг тайлбарладаг.	Хувцасны төрөл, үүрэг, ач холбогдлыг тоочсон жагсаалт гаргадаг.	Хувцсыг төрөл зориулалтаар нь ангилж, арчлах, хадгалах арга замыг эх сурвалж ашиглан тайлбарладаг.	Хувцсаа нөхцөл байдалдаа тохируулан өмсөхийн ач холбогдлыг судалж, өөртөө тохирсон хувцсаа сонгож өмсөхийн давуу талыг үнэлдэг.	Эрүүл мэндээ дэмжин хувцасны эрүүл ахуйн шаардлагыг тогтмол сахихын ач холбогдлын талаар бусдад таниулан сурталчилдаг.
Сурагч сүрьеэгийн халдвараас урьдчилан сэргийлэх, өөрийгөө болон бусдыг хамгаалах арга замыг тайлбарладаг.	Сүрьеэ өвчний үүсгэгч, илрэх шинж тэмдгийг тоочдог.	Сүрьеэгийн халдварлах замыг харуулсан бүдүүвч зохиож зураг дээр тайлбарладаг.	Сүрьеэ өвчний сөрөг үр дагаврын талаар баримтад үндэслэн дүн шинжилгээ хийдэг.	Сүрьеэ өвчнөөс урьдчилан сэргийлэх арга замууд, урьдчилан сэргийлэх үзлэг шинжилгээнд хамрагдахын ач холбогдлын талаар зөвлөмж бичиж бусдад сурталчилдаг.
Сурагч дархлаажуулалтын эрүүл мэндэд үзүүлэх нөлөөллийг зөв тодорхойлдог болно.	Дархлаажуулалт түүний ач холбогдлыг тоочдог.	Дархлаажуулалтад хамрагдахын ач холбогдлыг өөрийн үгээр тайлбарладаг.	Вакцин нь урьдчилан сэргийлэх, эмчилгээний зорилготой болохыг эх сурвалж ашиглан судалж дүгнэлт хийдэг.	Эрүүл мэндэд үзүүлэх дархлаажуулалтын нөлөөг сурталчилах, дархлаажуулалтад тогтмол хамрагдахын ач холбогдлын талаар бусдад зөвлөн тусладаг.

Үнэлгээний нэгж 2. Хооллолт ба хөдөлгөөн

№	Суралцахуйн зорилт	Суралцахуйн үр дүн
1	8.02а. Насны бүлэг, хувийн онцлогийг харгалзан хоол хүнсний хэрэглээг хянан зохицуулах	Сурагч энэ нэгжийг үзсэний дараа халдварт бус өвчин түүний эрсдэлээс сэргийлэх зорилгоор хоол хүнс, дасгал хөдөлгөөнийг насны бүлэг, хувийн онцлогт тохируулан хэрэглэж чаддаг болно.
2	8.02.б.Хөдөлгөөний идэвх эрчмээ тохируулан дасгал тогмол хийж, таргалалт, чихрийн шижин өвчнөөс сэргийлэх	

№	Суралцахуйн үр дүн	Суралцахуйн үр дүнгийн шалгуур
1	Сурагч энэ нэгжийг үзсэний дараа халдварт бус өвчин түүний эрсдлээс сэргийлэх зорилгоор хоол хүнс, дасгал хөдөлгөөнийг насны бүлэг, хувийн онцлогт тохируулан хэрэглэж чаддаг болно.	Өөрийн насны бүлэг, бие бялдрын онцлогт тохируулан “Эрүүл хооллох таваг” зөвлөмжийг ашиглан өдөр тутмын хоолны дэглэм зохиодог.
2		Таргалалт, чихрийн шижин өвчнөөс сэргийлэхэд хоолны болон хөдөлгөөний дэглэмийн үзүүлэх нөлөөг тодорхойлдог.

Гүйцэтгэлийн түвшин

Суралцахуйн үр дүнгийн шалгуур	Гүйцэтгэлийн түвшин			
	I	II	III	IV
Өөрийн насны бүлэг, бие бялдрын онцлогт тохируулан “Эрүүл хооллох таваг” зөвлөмжийг ашиглан өдөр тутмын хоолны дэглэм зохиодог.	Өдөр тутамд хэрэглэдэг хоол хүнсийг уураг, өөх тос, нүүрс-ус агуулсан байдлаар ангилдаг.	Эрүүл хооллох таваг зөвлөмжийг ашиглан өөрийн нас, хүйсний онцлогт тохирсон илчлэг, нэгж бүхий хоол хүнс агуулсан өдөр тутам хэрэглэх хоолны дэглэм зохиодог.	Эрүүл хооллох таваг зөвлөмжид хоол хүнсний эзлэх хувийг тооцож гаргаснаар өөрсдийн нэг удаагийн хооллолтоо хэрхэн өөрчилж болох хувилбарыг боловсруулдаг.	Өөрийн насны болон жирэмсэн эмэгтэй, хөхүүл эх, спортоор хичээллэдэг зэрэг бүлгийн хүмүүст хоол хүнсний хэрэгцээ өөр байдаг шалтгааныг тайлбарлан тус бүрт тохирсон хоолны дэглэм боловсруулдаг.
Таргалалт, чихрийн шижин өвчнөөс сэргийлэхэд хоолны болон хөдөлгөөний дэглэмийн үзүүлэх нөлөөг тодорхойлдог.	Таргалалт болон чихрийн шижин үүсэх эрсдэлт хүчин зүйлүүд, урьдчилан сэргийлэх арга замыг тодорхойлдог.	Чихрийн шижин, таргалалт өвчний шалтгаан, эрүүл мэндийн хор нөлөөг судалгааны үр дүн ашиглан тодорхойлдог.	Таргалалт, чихрийн шижин халдварт бус өвчнөөс сэргийлэх арга зам нь эрүүл хооллолт, дасгал хөдөлгөөн болохыг жишээ баримтад үндэслэн хэлэлцдэг.	2-р хэлбэрийн чихрийн шижинг үүсгэх эрсдэлт хүчин зүйлүүд, түүний үед илрэх шинж тэмдгийг тодорхойлж хориглох хоол хүнс, болон хийх дасгал хөдөлгөөний дэглэм боловсруулж хэрхэн мөрдөх тухай бусдад таниулж, сурталчилдаг.

Үнэлгээний нэгж 3. Сэтгэцийн эрүүл мэнд

№	Суралцахуйн зорилт	Суралцахуйн үр дүн
1	8,03.а. Асуудал, бэрхшээлийг даван туулах арга замыг тодорхойлж, хэрэглэж турших	Асуудлыг өсвөр үеийнхний дунд нийтлэг тохиолдох жишээн дээр өгсөн аргачлалын дагуу шийдвэрлэж чаддаг болно.
2	8,03.б. Сэтгэцийн эрүүл мэндийг дэмжих, шаардлагатай тусламж үйлчилгээг хаанаас, ямар хэлбэрээр авах талаар бусдад зөвлөх	Сурагч өдөр тутамд сэтгэцийн эрүүл мэндээ хэрхэн дэмжих талаар гэр бүл, найз нөхөд, үе тэнгийнхэндээ тодорхой мэдээлэл өгч чаддаг болно.

№	Суралцахуйн үр дүн	Суралцахуйн үр дүнгийн шалгуур
1	Асуудлыг өсвөр үеийнхний дунд нийтлэг тохиолдох жишээн дээр өгсөн аргачлалын дагуу шийдвэрлэж чаддаг болно.	- Асуудал шийдвэрлэх оновчтой арга замыг зөв тодорхойлдог. - Асуудал шийдвэрлэх арга замыг үр дүнтэй ашигладаг.
2	Сурагч өдөр тутамд сэтгэцийн эрүүл мэндээ хэрхэн дэмжих талаар гэр бүл, найз нөхөд, үе тэнгийнхэндээ тодорхой мэдээлэл зөвлөгөө өгч чаддаг болно.	Сэтгэцийн эрүүл мэндийг дэмжих арга замын талаар бусдад зориулан мэдээлэл бэлтгэж, энгийн ойлгомжтой байдлаар тайлбарладаг.

ХИЧЭЭЛ, СУРГАЛТЫН ҮР ДҮНГ ҮНЭЛЭХ ШАЛГУУР

Гүйцэтгэлийн түвшин

Суралцахуйн үр дүнгийн шалгуур	Гүйцэтгэлийн түвшин			
	I	II	III	IV
Асуудал шийдвэрлэх оновчтой арга замыг зөв тодорхойлдог.	Өгсөн нөхцөлд асуудлыг шийдвэрлэх ганц нэг хувилбарыг нэрлэх төдий тодорхойлдог.	Өгсөн нөхцөлд асуудлыг шийдвэрлэх 1-2 хувилбар гаргаж, хэрхэн хэрэглэх алхмыг тодорхойлдог.	Бодит жишээ гарган асуудлыг шийдвэрлэх хэд хэдэн хувилбар гаргаж, тэдгээрийн давуу сул талыг тооцон тохирох хувилбарыг тодорхойлдог.	Ямар ч нөхцөлд асуудал шийдвэрлэх боломжтой нэлээд олон хувилбар гаргаж, тэдгээрийг давуу сул тал, үр дагаврыг тооцон оновчтой хувилбарыг тодорхойлдог.
Асуудал шийдвэрлэх арга замыг үр дүнтэй ашигладаг.	Асуудал шийдвэрлэх арга замыг тайлбарладаг.	Асуудал шийдвэрлэх арга замыг хийж үзүүлэх оролдлого хийдэг.	Асуудал шийдвэрлэх арга замыг санамсаргүйгээр зөв ашигладаг.	Асуудал шийдвэрлэх арга замыг нөхцөлдөө тохируулан өөртөө итгэлтэйгээр ашигладаг.
Сэтгэцийн эрүүл мэндийг дэмжих арга замын талаар бусдад зориулан мэдээлэл бэлтгэж, энгийн ойлгомжтой байдлаар тайлбарладаг.	Сэтгэцийн эрүүл мэндийг дэмжих ганц нэг аргыг багтаасан мэдээллийг бүтээлч бус байдлаар бэлтгэх ба мэдээллийг өөртөө итгэлгүйгээр тайлбарладаг.	Сэтгэцийн эрүүл мэндийг дэмжих ганц нэг арга замыг багтаасан мэдээллийг хүлээн авах гэж буй хүний онцлогийг харгалзан бэлтгэх оролдлого хийж, тайлбарлахыг хичээдэг.	Сэтгэцийн эрүүл мэндийг дэмжихийн ач холбогдол, дэмжих хэд хэдэн аргын талаарх мэдээллийг хүлээн авах гэж буй хүний онцлогт тохирсон хэлбэрээр энгийн ойлгомжтой үг хэллэг ашиглан бэлтгэж, тайлбарладаг.	Сэтгэцийн эрүүл мэнд гэж юуг хэлэх, түүнийг дэмжихийн ач холбогдол, дэмжих бүх арга замыг багтаасан мэдээллийг хүлээн авах гэж буй хүний онцлогт тохируулан энгийн ойлгомжтой үг хэллэг ашиглан бүтээлчээр бэлтгэж, өөртөө итгэлтэйгээр тайлбарладаг.

Үнэлгээний нэгж 4. Хорт зуршил

№	Суралцахуйн зорилт	Суралцахуйн үр дүн
1	8,04.а. Амьсгалын болон хоол боловсруулах эрхтэн тогтолцоонд архи, тамхи нөлөөлдөг болохыг туршилтаар илрүүлэх	Сурагч энэ нэгжийг үзсэний дараа эрүүл амьдрах, эрүүл мэндийн эрсдэлээс сэргийлэх зорилгоор архи, тамхины сөрөг нөлөө, түүнээс татгалзах, бусдад нөлөөлөхийн ач холбогдлыг тодорхойлдог болно.
2	8,04.б. Архи, тамхи хэрэглэхгүй байхыг ойр дотны хүмүүсээсээ хүсэх, бусдад нөлөөлөх	

№	Суралцахуйн үр дүн	Суралцахуйн үр дүнгийн шалгуур
1	Сурагч энэ нэгжийг үзэж судалсны дараа үзсэний дараа эрүүл амьдрах, эрүүл мэндийн эрсдэлээс сэргийлэх зорилгоор архи, тамхины сөрөг нөлөө, түүнээс татгалзах, бусдад нөлөөлөхийн ач холбогдлыг тодорхойлдог болно.	Хүний амьсгалын болон хоол боловсруулах эрхтнүүдэд тамхи, архины үзүүлэх урт богино хугацааны сөрөг нөлөөг харьцуулан тайлбарладаг.

Гүйцэтгэлийн түвшин

Суралцахуйн үр дүнгийн шалгуур	Гүйцэтгэлийн түвшин			
	I	II	III	IV
Хүний амьсгалын болон хоол боловсруулах эрхтнүүдэд тамхи, архины үзүүлэх урт богино хугацааны сөрөг нөлөөг харьцуулан тайлбарладаг.	Хүний эрхтэн тогтолцоонд архи тамхины үзүүлэх сөрөг нөлөөг нэрлэдэг.	Архи, тамхины нэг нь нөгөөгийнхөө үйлчлэлийг нэмэгдүүлснээс болж үүсэх сөрөг нөлөөг харьцуулан тайлбарладаг.	Хүний хоол боловсруулах, амьсгалах эрхтнүүдэд архи, тамхины үзүүлэх богино, урт хугацааны сөрөг нөлөөг жишээ баримтад үндэслэн харьцуулан тайлбарладаг.	Архи, тамхи нь эрүүл мэндэд сөргөөр нөлөөлөхөөс гадна гэр бүл, хүүхдийн хүмүүжил, эдийн засагт хэрхэн нөлөөлдөг талаар болон түүнээс татгалзах арга замыг тодорхойлдог.

Үнэлгээний нэгж 5. Бэлгийн болон нөхөн үржихүйн эрүүл мэнд

№	Суралцахуйн зорилт	Суралцахуйн үр дүн
1	8,05.а. Хувь хүний бэлгийн харилцааны талаарх шийдвэр өөрчлөгддөг болохыг ухаарч, түүнийг хүндэтгэх, эрүүл мэндээ дэмжих, хамгаалах талаар хариуцлагатай шийдвэр гаргах	- Сурагч кейс ашиглан бэлгийн харилцааны талаар аюул, эрсдэлгүй шийдвэр гаргадаг болно. - Өгсөн нөхцөлд тохируулан хүйсийн болон бэлгийн чиг баримжааг хүндэтгэж байгаагаа үг, үйлдлээрээ харуулж чаддаг болно. - Сурагч өгсөн нөхцөл дээр тулгуурлан бэлгийн харилцааны талаар зөвшилцөх үгэн болон үгэн бус харилцааны чадвараа харуулна.
2	8,05.б. Хүйсийн баримжаа, илэрхийллийг тайлбарлаж, өөрийн болон бусдын хүйсийн баримжаа, илэрхийллийг хүндэтгэж байгаагаа харуулах	
3	8,05.в. Бэлгийн чиг баримжааг тайлбарлаж, хүйсийн баримжаа илэрхийллээс ялгах; буруу ташаа ойлголтыг няцаах; ялгаатай байдлыг хүлээн зөвшөөрөх, хүндэтгэх	
4	8,05.г. Бэлгийн харилцааны талаар харилцан зөвшилцөх нь чухал болохыг ухаарах; зөвшилцлийг ялган таних; харилцан зөвшилцөх арга замыг жишээгээр үзүүлэх	

№	Суралцахуйн үр дүн	Суралцахуйн үр дүнгийн шалгуур
1	Сурагч кейс ашиглан бэлгийн харилцааны талаар аюул, эрсдэлгүй шийдвэр гаргадаг болно.	Бэлгийн харилцааны талаарх шийдвэрүүдээс аюулгүй, эрсдэлгүй хувилбарыг сонгодог.
2	Өгсөн нөхцөлд тохируулан хүйсийн болон бэлгийн чиг баримжааг хүндэтгэж байгаагаа үг, үйлдлээрээ харуулж чаддаг болно.	- Хүйсийн ба бэлгийн чиг баримжаатай холбоотой буруу ташаа ойлголтыг ялгадаг. - Бусдын хүйсийн ба бэлгийн чиг баримжааг хүндэтгэх үг хэллэг, үйлдлийг өөртөө итгэлтэйгээр хэрэглэдэг.
3	Сурагч өгсөн нөхцөл дээр тулгуурлан бэлгийн харилцааны талаар зөвшилцөх үгэн болон үгэн бус харилцааны чадвараа харуулна.	Бэлгийн харилцааны талаар зөвшилцөх үг хэллэг, үйлдлийг үр дүнтэй хэрэглэдэг.

ХИЧЭЭЛ, СУРГАЛТЫН ҮР ДҮНГ ҮНЭЛЭХ ШАЛГУУР

Гүйцэтгэлийн түвшин

Суралцахуйн үр дүнгийн шалгуур	Гүйцэтгэлийн түвшин			
	I	II	III	IV
Бэлгийн харилцааны талаарх шийдвэрүүдээс аюулгүй, эрсдэлгүй хувилбарыг сонгодог.	Бэлгийн харилцаатай холбоотой шийдвэрийн хувилбарыг шинжлэн судлалгүйгээр сонголт хийдэг.	Бэлгийн харилцаатай холбоотой шийдвэрийн хувилбар гаргаж сонгох оролдлого хийдэг.	Бэлгийн харилцааны үр дагаврыг тооцож, шийдвэрийн хувилбараас өөрийн мэдрэмжээр сонголт хийдэг.	Бэлгийн харилцааны үр дагаврыг тооцож, шийдвэрийн хувилбар тус бүрийг шинжлэн, оновчтой сонголт хийдэг.
Хүйсийн ба бэлгийн чиг баримжаатай холбоотой буруу ташаа ойлголтыг ялгадаг.	Хүйсийн ба бэлгийн чиг баримжааны талаарх зарим ташаа ойлголтыг мэддэг.	Хүйсийн ба бэлгийн чиг баримжааны талаарх ихэнх ташаа ойлголтыг ялгадаг.	Хүйсийн ба бэлгийн чиг баримжааны талаарх ташаа ойлголтыг бодит жишээ гарган ялгадаг.	Хүйсийн ба бэлгийн чиг баримжаатай холбоотой ташаа ойлголтыг үндэслэл нотолгоонд суурилан ялгадаг.
Бусдын хүйсийн ба бэлгийн чиг баримжааг хүндэтгэх үг хэллэг, үйлдлийг өөртөө итгэлтэйгээр хэрэглэдэг.	Бусдыг бэлгийн чиг баримжаа, хүйсийн баримжаагаар ялгаварлан гадуурхах үг хэллэг, үйлдэл хийдэггүй.	Бэлгийн ба хүйсийн баримжаагаар ялгах ёсгүй гэдгийг хэлдэг, бүх хүнтэй адил харилцахыг хичээдэг.	Бэлгийн ба хүйсийн баримжаа нь өөр өөр байсан ч хүн бүр адил тэгш эрхтэй гэдгийг хэлдэг, бүх хүнтэй адил харилцдаг.	Бэлгийн чиг баримжаа, хүйсийн баримжааг хүн өөрөө сонгох боломжгүй гэдгийг өөртэй итгэлтэй хэлдэг, ямар ч хүнийг байгаагаар нь хүлээн зөвшөөрч харилцдаг.
Бэлгийн харилцааны талаар зөвшилцөх үг хэллэг, үйлдлийг үр дүнтэй хэрэглэдэг.	Өгсөн нөхцөлд нөгөө хүнийхээ саналыг хагас дутуу сонсож, өөрийн санаа бодлыг хэлэх оролдлого хийдэг.	Өгсөн нөхцөлд нөгөө хүнийхээ саналыг сонсож, өөрийн санаа бодлыг хэлэх ба биеийн хэлэмж нь нийцэхгүй.	Бодит жишээн дээр нөгөө хүнийхээ саналыг бүрэн сонсож, өөрийн санаа бодлыг тодорхой хэлэх ба биеийн хэлэмжтэй нь тохиолдлоор нийцдэг.	Ямар ч нөхцөлд нөгөө хүнийхээ саналыг бүрэн гүйцэд сонсож, өөрийн санаа бодлыг ойлгомжтой, тодорхой хэлж, түүндээ нийцэх биеийн хэлэмжийг өөртөө итгэлтэйгээр илэрхийлдэг.

Үнэлгээний нэгж 6. Аюулгүй байдал, анхны тусламж

№	Суралцахуйн зорилт	Суралцахуйн үр дүн
1	8.06.а. Амьдрах орчинд болон уралдаан тэмцээний явцад тохиолдож болох гэмтэл бэртлээс сэргийлэх, хамгаалах багаж хэрэгслийг зөв хэрэглэх, шаардлагатай үед анхны тусламж үзүүлдэг болох	Сурагч амьдрах орчин болон уралдаан тэмцээний явцад тохиолдож болох гэмтлийн үед хамгаалах хэрэгслийг зөв хэрэглэж анхны тусламж үзүүлдэг болно.

№	Суралцахуйн үр дүн	Суралцахуйн үр дүнгийн шалгуур
1	Сурагч амьдрах орчин болон уралдаан тэмцээний явцад тохиолдож болох гэмтлийн үед хамгаалах хэрэгслийг зөв хэрэглэж анхны тусламж үзүүлдэг болно.	Сурагч шаардлагатай тохиолдолд хамгаалах хэрэгслийг зөв хэрэглэж анхны тусламж үзүүлдэг.

Гүйцэтгэлийн түвшин

суралцахуйн үр дүнгийн шалгуур	Гүйцэтгэлийн түвшин			
	I	II	III	IV
Сурагч шаардлагатай тохиолдолд хамгаалах хэрэгслийг зөв хэрэглэж анхны тусламж үзүүлдэг.	Амьдрах орчин болон уралдаан тэмцээний үед тохиолдож болох гэмтлийн төрлүүд түүнээс хамгаалах хэрэгслийн ялгагдах онцлог, хэрэглэх аргыг тоочдог.	Түлэгдэх, хөлдөх, нарших, осгох, цус алдах, үе мултрах, газар хөдлөлтөд үзүүлэх анхны тусламжийн арга хэмжээг тайлбарладаг.	Тохиолдож болох гэмтлийн эрсдлийг тодорхойлж үнэлдэг.	Шаардлагатай тохиолдолд хамгаалах хэрэгслийг зөв хэрэглэж анхны тусламж үзүүлэхийн ач холбогдлын талаар бусдад зөвлөн сурталчилдаг.

ДӨРӨВДҮГЭЭР ХЭСЭГ. IX АНГИ

4.1. IX АНГИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ХИЧЭЭЛИЙН СУРАЛЦАХУЙН ҮР ДҮН

Үнэлгээний зорилт	Суралцахуйн үр дүн
Мэдлэг ойлголт	- Халдварт ба халдварт бус өвчний эрсдэлт хүчин зүйлс, гоо сайхны бүтээгдэхүүн, үйлчилгээний талаар мэдлэгтэй болно. - Биеийн жингээ хянах энгийн аргуудын талаар мэдлэгтэй болно. - Мэргэжил сонгоход анхаарах зүйлийн талаар мэддэг болно. - Архи тамхи хэрэглэснээр зүрх судасны тогтолцоонд үүсэх эрсдэл, өвчлөлийн талаар мэдлэгтэй болно. - БЗДХ-ын дамжих зам, нийтлэг илрэх шинж тэмдэг, урьдчилан сэргийлэх арга замын талаар мэддэг болно. - Осол гэмтлийн үед үзүүлэх анхны тусламж, гал түймрийн шалтгаан, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн хэрэгцээний талаар мэдлэгтэй болно.
Чадвар	- Халдварт өвчнөөс сэргийлж, өдрийн дэглэм баримталж, эрүүл мэндээ хамгаалах чадвартай болно - Өөх тос, давс, чихрийн хэрэглээгээ хянаж, хоолны зохицлыг зөв сонгодог болно. - Нийгмийн янз бүрийн орчинд дасан зохицох чадвартай болно. - Архи тамхины хор уршгийг найз нөхөддөө тайлбарлах, ухуулах чадвар эзэмшинэ. - Гар утас, нийгмийн сүлжээг аюулгүй ашигладаг болно. - Байгалийн эрсдэлт үзэгдлээс сэргийлэх, бусдад тусламж дэмжлэг үзүүлж чаддаг болно.
Хандлага	- Халдварт ба халдварт өвчний эрсдэлт хүчин зүйлсээс зайлсхийж, халдвараас хамгаалах багаж хэрэгсэл болон гоо сайхны бүтээгдэхүүнийг зөв сонгож, хэрэглэж хэвшинэ. - Хоногийн хоолоор авах шимт бодисоо тооцдог, биеийн жингээ хянан зохицуулдаг болно. - Аливаа зүйлд бодитоор хандаж, эерэг аргаар даван туулах хандлагатай болно. - Архи тамхинаас татгалзаж өөрийн болон бусдын эрүүл мэндийг хамаалах эерэг хандлагатай болно. - Бэлгийн амьдралтай холбоотой үнэт зүйл, итгэл үнэмшлийн ялгаатай байдлыг хүндэтгэдэг болно. - Байгалийн эрсдэлт үзэгдлийн үед шаардлагатай тохиолдолд өөртөө болон бусдад тусламж үзүүлэх хандлагатай болно.

4.2. ҮНЭЛГЭЭНИЙ НЭГЖ ТУС БҮРИЙН СУРАЛЦАХУЙН ҮР ДҮНГИЙН ШАЛГУУР, ГҮЙЦЭТГЭЛИЙН ТҮВШИН

Үнэлгээний нэгж 1. Хувийн эрүүл ахуй ба орчны эрүүл мэнд

№	Суралцахуйн зорилт	Суралцахуйн үр дүн
1	9,01.а. Халдварт болон халдварт бус өвчний эрсдэлт зан үйлийг тодорхойлох, сэргийлэх арга замыг үзүүлэх	Сурагч халдварт болон халдварт бус өвчний эрсдэлт зан үйлийг тодорхойлж, халдвараас хамгаалах багаж хэрэгслийг зөв хэрэглэдэг болно.
2	9,01.б. Халдвараас хамгаалах нэг удаагийн багаж хэрэгслийг зөв, зохистой хэрэглэх талаар сурталчлах	
3	9,01.в. Гоо сайхнаа хамгаалах, өөрт тохирсон гоо сайхны бүтээгдэхүүнийг сонгохын ач холбогдлыг мэдэх	Сурагч өөрт тохирсон гоо сайхны бүтээгдэхүүн, хэрэгсэл, гоо сайхнаа хамгаалах арга, гоо заслын үйлчилгээг сонгож хэрэглэхийн ач холбогдлыг жишээн дээр тайлбарладаг болно.

№	Суралцахуйн үр дүн	Суралцахуйн үр дүнгийн шалгуур
1	Сурагч халдварт болон халдварт бус өвчний эрсдэлт зан үйлийг тодорхойлж, халдвараас хамгаалах багаж хэрэгслийг зөв хэрэглэдэг болно.	Сурагч халдварт ба халдварт бус өвчний эрсдэлт зан үйлийг эрүүл ахуйн дэглэмтэй холбон судалж, халдвараас хамгаалах багаж хэрэгслийг зөв хэрэглэхийн ач холбогдлыг тайлбарладаг.
2	Сурагч өөрт тохирсон гоо сайхны бүтээгдэхүүн, хэрэгсэл, гоо сайхнаа хамгаалах арга, гоо заслын үйлчилгээг сонгож хэрэглэхийн ач холбогдлыг жишээн дээр тайлбарладаг болно.	Сурагч өөрийн үс болон арьсны онцлогт тохирсон гоо сайхны бүтээгдэхүүнийг сонгож хэрэглэхийн ач холбогдлыг тайлбарладаг.

Гүйцэтгэлийн түвшин

Суралцахуйн үр дүнгийн шалгуур	Гүйцэтгэлийн түвшин			
	I	II	III	IV
Сурагч халдварт ба халдварт бус өвчний эрсдэлт зан үйлийг эрүүл ахуйн дэглэмтэй холбон судалж, халдвараас хамгаалах багаж хэрэгслийг зөв хэрэглэхийн ач холбогдлыг тайлбарладаг.	Халдварт ба халдварт бус өвчинд хүргэдэг эрсдэлт зан үйлийг нэрлэдэг.	Өдрийн дэглэм баримталж биеийн дархлааг дэмжих нь халдварт ба халдварт бус өвчнөөс урьдчилан сэргийлдэг болохыг эх сурвалж баримтад үндэслэн дүн шинжилгээ хийж тайлбарладаг.	Эрүүл ахуйн дэглэм мөрдөөгүйгээс гарах сөрөг үр дагаврыг шүүн хэлэлцдэг.	Халдвараас хамгаалах багаж хэрэгслийг зөв хэрэглэхийн ач холбогдлыг бусдад сурталчилдаг.
Сурагч өөрийн үс болон арьсны онцлогт тохирсон гоо сайхны бүтээгдэхүүнийг сонгож хэрэглэхийн ач холбогдлыг тайлбарладаг.	Гоо сайхнаа хамгаалах энгийн аргуудыг тоочдог.	Өөрсдийн үс болон арьсны төрөл, онцлогийг судалж тодорхойлж чаддаг.	Үс болон арьс арчилгааны бүтээгдэхүүн түүнд тавигдах үндсэн шаардлагыг судалж, дүгнэлт хийдэг.	Гоо сайхнаа хамгаалах, өөрт тохирсон гоо сайхны бүтээгдэхүүнийг зөв сонгохын ач холбогдлын талаар зөвлөмж бичдэг.

Үнэлгээний нэгж 2. Хооллолт ба хөдөлгөөн

№	Суралцахуйн зорилт	Суралцахуйн үр дүн
1	9.02.а Хоногийн хоолны шимт бодисын хэрэгцээ, уламжлалыг харгалзан зохистой хооллох	Сурагч энэ нэгжийг үзсэний дараа эрүүл мэндийн эрсдэлээс сэргийлэх зорилгоор биеийн жингийн индекс, хоногт шаардлагатай шимт бодисын хэрэгцээ, уламжлалыг харгалзан хоол хүнсээ тохируулан хэрэглэдэг болно.
2	9.02.б. Хоолны дэглэм баримталж, биеийн жингээ зохицуулан зүрх судас, ясны сийрэгжилт, хавдар, харшил зэрэг өвчлөлөөс сэргийлэх	

№	Суралцахуйн үр дүн	Суралцахуйн үр дүнгийн шалгуур
1	Сурагч энэ нэгжийг үзсэний дараа эрүүл мэндийн эрсдлээс сэргийлэх зорилгоор биеийн жингийн индекс, хоногт шаардлагатай шимт бодисын хэрэгцээ, уламжлалыг харгалзан хоол хүнсээ тохируулан хэрэглэдэг болно.	Уламжлалт монгол хоолны эрүүл мэндэд үзүүлэх эерэг сөрөг нөлөө болон хоорондоо үл зохицох хоол хүнсийг ялган тодорхойлдог.
2		Зүрх судас, яс сийрэгжилт, хавдар, харшил зэрэг халдварт бус өвчнөөс сэргийлэхэд биеийн жингийн индекс, хүнсний шимт бодисын хэрэгцээ, зохистой хооллолтын үзүүлэх эерэг нөлөөг тодорхойлдог.

ХИЧЭЭЛ, СУРГАЛТЫН ҮР ДҮНГ ҮНЭЛЭХ ШАЛГУУР

Гүйцэтгэлийн түвшин

Суралцахуйн үр дүнгийн шалгуур	Гүйцэтгэлийн түвшин			
	I	II	III	IV
Уламжлалт монгол хоолны эрүүл мэндэд үзүүлэх эерэг сөрөг нөлөө болон хоорондоо үл зохицох хоол хүнсийг ялган тодорхойлдог.	Монгол уламжлалт хоолны дэглэм болон орон нутаг, зан заншилтай холбоотой хоолны онцлогийг нэрлэдэг.	Монгол уламжлалт хоолны давуу, сул тал ба хоорондоо үл зохицох хоол хүнсийг ялгадаг.	Монголчуудын дөрвөн улиралдаа тохируулан хэрэглэж ирсэн хоол хүнс ба суурьшмал амьдралд хэрэглэж буй хоол хүнстэй харьцуулан дүгнэлт хийдэг.	Монголчуудын олон жилийн турш боловсруулж ирсэн өвөрмөц хүнс, сүү цагаан идээний эрүүл мэндийг дэмжих чухал үүрэгтэй болохыг, мөн зарим хоол хүнсийг өөртөө тохируулж хэрэглэх талаар зөвлөмж боловсруулж бусдад таниулдаг.
Зүрх судас, яс сийрэгжилт, хавдар, харшил зэрэг халдварт бус өвчнөөс сэргийлэхэд биеийн жингийн индекс, хүнсний шимт бодисын хэрэгцээ, зохистой хооллолтын үзүүлэх эерэг нөлөөг тодорхойлдог.	Биеийн жингийн индексээ мэдсэнээр өөрийн жин, хоолны дэглэмдээ хяналт тавих боломжтойг тайлбарладаг.	Монгол орны болон бусад орны хүүхдүүдийн хоногийн хоолоор авах илчлэг, шимт бодисын норм хэмжээг харьцуулан тайлбарладаг.	Зүрх судас, хавдар, яс сийрэгжих, харшил зэрэг өвчнүүдээс сэргийлэх гол арга зам нь хоол хүнсний зохистой хэрэглээ, биеийн жинг хянах, зохицуулах, биеийн галбарт тохирсон дасгал хөдөлгөөн хийх зэргээс хамаардаг болохыг хэлэлцдэг.	Зохистой хооллохын давуу талыг хооллох зуршилтай холбон харьцуулж, хүн бүрийн хооллох зуршил өөр байдгаас үүдэлтэй өвчин эмгэгт өртөх эрсдэл байгааг жишээ баримтад үндэслэн тайлбарладаг.

Үнэлгээний нэгж 3. Сэтгэцийн эрүүл мэнд

№	Суралцахуйн зорилт	Суралцахуйн үр дүн
1	9,03.а. Мэргэжил сонголт, түүнтэй холбоотой зөвлөгөө, мэдээлэл авах, бусадтай санал солилцох	Сурагч бусдаас зөвлөгөө мэдээлэл авч, санал солилцох замаар мэргэжил сонгох, янз бүрийн орчин нөхцөлд дасан зохицох аргыг сонгож чаддаг болно.
2	9,03.б. Нийгмийн янз бүрийн орчинд дасан зохицох, бусадтай харилцан ойлголцох	

№	Суралцахуйн үр дүн	Суралцахуйн үр дүнгийн шалгуур
1	Сурагч бусдаас зөвлөгөө мэдээлэл авч, санал солилцох замаар мэргэжил сонгох, янз бүрийн орчин нөхцөлд дасан зохицох аргыг оновчтой сонгож чаддаг болно.	Мэргэжил сонгох, дасан зохицоход шаардлагатай үйлдлийг нөхцөл байдалд тохируулан оновчтой сонгодог.

Гүйцэтгэлийн түвшин

Суралцахуйн үр дүнгийн шалгуур	Гүйцэтгэлийн түвшин			
	I	II	III	IV
Мэргэжил сонгох, дасан зохицоход шаардлагатай үйлдлийг нөхцөл байдалд тохируулан оновчтой сонгодог.	Мэргэжил сонгох, дасан зохицохын тулд хийх үйлдлийн ганц нэг жишээ нэрлэх боловч өгсөн нөхцөлтэй хамааралгүй байх.	Мэргэжил сонгох, дасан зохицохын тулд хийх үйлдлийг өгсөн нөхцөлтэй уялдуулан сонгох оролдлого хийдэг.	Мэргэжил сонгох, дасан зохицохын тулд шаардлагатай үйлдлийн хэд хэдэн хувилбарыг өгсөн нөхцөлтэй уялдуулан сонгодог.	Мэргэжил сонгох, ямар ч нөхцөлд тохируулан дасан зохицох үйлдлийн тохиромжтой хэд хэдэн хувилбарыг оновчтой сонгож, тэдгээрийг сонгосон үндэслэлээ тайлбарладаг.

Үнэлгээний нэгж 4. Хорт зуршил

№	Суралцахуйн зорилт	Суралцахуйн үр дүн
1	9,04.а. Зүрх судасны үйл ажиллагаанд архи, тамхи нөлөөлдөг болохыг хэлэлцэх	Сурагч энэ нэгжийг үзсэний дараа архи тамхины хэрэглээ нь хүний эрүүл мэнд болон эдийн засагт сөргөөр нөлөөлдөг болохыг тодорхойлдог болно.
2	9,04.б. Архи, тамхины эдийн засгийн тооцоолол хийж, сөрөг тайлбарлах	

№	Суралцахуйн үр дүн	Суралцахуйн үр дүнгийн шалгуур
1	Сурагч энэ нэгжийг үзсэний дараа архи тамхины хэрэглээ нь хүний эрүүл мэнд болон эдийн засагт сөргөөр нөлөөлдөг болохыг тодорхойлдог болно.	Архи тамхи хэрэглэснээр хүний эрүүл мэндэд, тухайлбал, зүрх судасны тогтолцоонд үүсэх эрсдэл, өвчлөлийн талаар жишээ баримтад үндэслэн тайлбарладаг.
2		Архи тамхины хэрэглээний эдийн засгийн тооцоололд үндэслэн түүний нийгэм, эдийн засаг, гэр бүлд учруулж байгаа хор нөлөөг тодорхойлдог.

Гүйцэтгэлийн түвшин

Суралцахуйн үр дүнгийн шалгуур	Гүйцэтгэлийн түвшин			
	I	II	III	IV
Архи тамхи хэрэглэснээс хүний эрүүл мэндэд зүрх судасны тогтолцоонд үүсэх эрсдэл, өвчлөлийн талаар жишээ баримтад үндэслэн тайлбарладаг.	Зүрх судасны өвчлөл үүсгэх эрсдэлт хүчин зүйлүүдийг нэрлэдэг.	Архи тамхинаас үүдэлтэй зүрхний шигдээс, цус харвах өвчнөөр өвдсөн хүний тоо баримтыг үзүүлсэн графикт үндэслэн дүгнэлт гаргадаг.	Архи тамхинаас үүдэлтэй зүрхний шигдээс, цус харвалт, захын артерийн судасны өвчлөлийн шалтгаан үр дагаврыг жишээ баримтад үндэслэн тайлбарладаг.	Архи тамхинаас татгалзсанаар зүрх судасны өвчлөлд өртөхгүй байх, өөрийн болон бусдын эрүүл мэндийг хамгаалах талаар санамж, зөвлөмж боловсруулж бусдад түгээдэг.
Архи тамхины хэрэглээний эдийн засгийн тооцоололд үндэслэн түүний нийгэм, эдийн засаг, гэр бүлд учруулж байгаа хор нөлөөг тодорхойлдог.	Архи тамхи нь гэр бүлийн гишүүд болон тухайн гэр бүлийн эдийн засагт ямар хор нөлөө үзүүлдэг болохыг нэрлэдэг.	Ажлын хуудас болон кейс зэрэгт үндэслэн 1 шил архи 1хайрцаг тамхины үнийн тооцоонд үндэслэн өдөрт, сард, жилд зарцуулах эдийн засгийн тооцоолол хийж түүнийг хэрэгцээтэй зүйлд хэрхэн зарцуулж болох талаар дүгнэлт гаргадаг.	Архи тамхинд сар, жилд зарцуулж байгаа эдийн засгийн тооцоололд үндэслэн эрүүл мэнд, гэр бүлийн эдийн засаг, сэтгэл зүйд үзүүлэх нөлөөнд дүн шинжилгээ хийдэг.	Архи тамхи нь хувь хүний эрүүл мэндэд хортой төдийгүй нийгэм, гэр бүл, эдийн засаг, цаг хугацаа, ажлын бүтээмжид нөлөөлж буйг жишээ баримт, нотолгоонд үндэслэн хэлэлцдэг.

ХИЧЭЭЛ, СУРГАЛТЫН ҮР ДҮНГ ҮНЭЛЭХ ШАЛГУУР

Үнэлгээний нэгж 5. Бэлгийн болон нөхөн үржихүйн эрүүл мэнд

№	Суралцахуйн зорилт	Суралцахуйн үр дүн
1	9,05.а. Түгээмэл тохиолддог бэлгийн замаар дамжих халдвар, дамжих зам, шинж тэмдэг, эмчлэгддэг эсэх, урьдчилан сэргийлэлт, халдвар авсан байж болзошгүй тохиолдолд авч хэрэгжүүлэх арга хэмжээг тайлбарлах	- Сурагч өгсөн нөхцөлүүдээс бэлгийн замаар дамжих халдвараас сэргийлэх арга замыг зөв сонгож чаддаг болно. - Бэлгийн амьдралтай холбоотой эрхэмлэх үнэт зүйл нь хүний зан үйлд нөлөөлдөг болохыг жишээ гарган тодорхойлж чаддаг болно. - Нийгмийн сүлжээний давуу, сул талыг тодорхойлон, аюулгүй ашиглах төлөвлөгөөг өгсөн зааврын дагуу боловсруулж чаддаг болно.
2	9,05.б. Бэлгийн амьдрал, нөхөн үржихүйн эрүүл мэндтэй холбогдох өөрийн үнэт зүйл, түүний зан үйлд үзүүлэх нөлөөг тодорхойлж, үнэт зүйл, итгэл үнэмшил, хандлагын ялгаатай байдлыг хүндэтгэхийн ач холбогдлыг ухаарах	
3	9,05.в. Интернэт, нийгмийн сүлжээний эерэг, сөрөг нөлөөг (бусдын анхааралд өртөх, бэлгийн мөлжлөг г.м.) жишээгээр тайлбарлах, интернэт, гар утас, нийгмийн сүлжээг аюулгүй ашиглах төлөвлөгөө боловсруулж хэрэглэх	

№	Суралцахуйн үр дүн	Суралцахуйн үр дүнгийн шалгуур
1	Сурагч өгсөн нөхцөлүүдээс бэлгийн замаар дамжих халдвараас сэргийлэх арга замыг зөв сонгож чаддаг болно.	Янз бүрийн өгөгдлөөс бэлгийн замаар дамжих халдвараас сэргийлэх үйлдлийг ялган сонгодог.
2	Бэлгийн амьдралтай холбоотой эрхэмлэх үнэт зүйл нь хүний зан үйлд нөлөөлдөг болохыг жишээ гарган тодорхойлж чаддаг болно.	Эрхэмлэх үнэт зүйл нь зан үйлийг хэрхэн чиглүүлдэг болохыг тодорхойлдог.
3	Нийгмийн сүлжээний давуу, сул талыг тодорхойлон, аюулгүй ашиглах төлөвлөгөөг өгсөн зааврын дагуу боловсруулж чаддаг болно.	Нийгмийн сүлжээг аюулгүй ашиглах төлөвлөгөө боловсруулдаг.

Гүйцэтгэлийн түвшин

Суралцахуйн үр дүнгийн шалгуур	Гүйцэтгэлийн түвшин			
	I	II	III	IV
Янз бүрийн өгөгдлөөс бэлгийн замаар дамжих халдвараас сэргийлэх үйлдлийг ялган сонгодог.	Өгсөн жагсаалтаас БЗДХ-аас сэргийлэх 1-2 үйлдлийг зөв сонгодог.	Өгсөн жагсаалтаас БЗДХ-аас сэргийлэх 2-3 үйлдлийг зөв сонгодог.	Өгсөн жагсаалтаас БЗДХ-аас сэргийлэх ихэнх үйлдлийг зөв сонгодог.	Өгсөн жагсаалтаас БЗДХ-аас сэргийлэх бүх үйлдлийг зөв сонгодог.
Бэлгийн амьдралтай холбоотой эрхэмлэх үнэт зүйл нь зан үйлийг хэрхэн чиглүүлдэг болохыг тодорхойлдог.	Бэлгийн амьдралтай холбоотой эрхэмлэх үнэт зүйл хүний зан үйлд нөлөөлж байгаа ганц нэг жишээ хэлдэг.	Бэлгийн амьдралтай холбоотой эрхэмлэх үнэт зүйл хүний зан үйлийг чиглүүлж байгааг жишээ баримтаар нотлон тодорхойлохыг оролддог.	Бэлгийн амьдралтай холбоотой эрхэмлэх үнэт зүйл хүний зан үйлийг чиглүүлж байгааг жишээ баримтаар нотлон тодорхойлдог.	Бэлгийн амьдралтай холбоотой эрхэмлэх үнэт зүйл хүний зан үйлийг хэрхэн удирдан чиглүүлж байгааг үндэслэл нотолгоонд суурилан, уялдаа холбоог харуулан тодорхойлдог.

Нийгмийн сүлжээг аюулгүй ашиглах төлөвлөгөө боловсруулдаг.	Нийгмийн сүлжээг аюулгүй ашиглах ганц нэг үйл ажиллагаа нэрлэдэг.	Нийгмийн сүлжээний давуу, сул талыг харгалзах оролдлого хийн, аюулгүй ашиглах 2-3 үйл ажиллагаа боловсруулдаг.	Нийгмийн сүлжээний давуу, сул талыг харгалзан, аюулгүй ашиглах төлөвлөгөөг зорилго, хэрэгжүүлэх үйл ажиллагаа тусган боловсруулдаг.	Нийгмийн сүлжээний давуу, сул талыг харгалзан, аюулгүй ашиглах төлөвлөгөөг зорилго, хэрэгжүүлэх үйл ажиллагаа, эхлэх хугацаа зэргийг тусган боловсруулдаг.
--	---	--	---	--

Үнэлгээний нэгж 6. Аюулгүй байдал, анхны тусламж

№	Суралцахуйн зорилт	Суралцахуйн үр дүн
1	9,06.а. Гэнэтийн осол гэмтлээс сэргийлэх, тохиолдсон үед гарын доорх материал, багаж хэрэгсэл ашиглан анхны тусламж үзүүлэх, яаралтай тусламж дуудах	Сурагч муужрах, хахах, живэх, хамраас цус гоожих, шавжинд хатгуулах, үе мултрах, яс хугарах, шөрмөс сунах, тасрах үед гарын доорх материал ашиглан анхны тусламж яаралтай үзүүлдэг болно.
2	9,06.б. Бага насны болон хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд өөрийнхөө чадах зүйлээр туслах	Сурагч сургуулийн орчинд бага насны болон хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг шатаар зорчих, буух, суух, орох, гарах тохиолдолд боломжоороо тусалдаг болно.

№	Суралцахуйн үр дүн	Суралцахуйн үр дүнгийн шалгуур
1	Сурагч муужрах, хахах, живэх, хамраас цус гоожих, шавжинд хатгуулах, үе мултрах, яс хугарах, шөрмөс сунах, тасрах үед гарын доорх материал ашиглан анхны тусламж яаралтай үзүүлдэг болно.	Сурагч шаардлагатай тохиолдолд гарын доорх материал ашиглан анхны тусламж үзүүлдэг.
2	Сурагч сургуулийн орчинд бага насны болон хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг шатаар зорчих, буух, суух, орох, гарах тохиолдолд боломжоороо тусалдаг болно.	Сурагч шаардлагатай тохиолдолд бага насны болон хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд тусалдаг.

Гүйцэтгэлийн түвшин

Суралцахуйн үр дүнгийн шалгуур	Гүйцэтгэлийн түвшин			
	I	II	III	IV
Сурагч шаардлагатай тохиолдолд гарын доорх материал ашиглан анхны тусламж үзүүлдэг.	Гэнэтийн осол гэмтлүүдийн төрлийг нэрлэдэг.	Шаардлагатай тохиолдолд гарын доорх материал ашиглан анхны тусламж үзүүлэх аргачлалыг тайлбарладаг.	Гэнэтийн осол гарч болох эрсдлийг үнэлж тодорхойлдог.	Гэнэтийн осол гэмтлийн үед анхны тусламж үзүүлэх талаар бусдад зориулан зөвлөмж бичдэг.
Сурагч шаардлагатай тохиолдолд бага насны болон хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд тусалдаг.	Бага насны болон хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд гарч болох хэрэгцээ шаардлагын жагсаалт гаргадаг.	Бага насны болон хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд тохиолдох бэрхшээлүүдийг тоочиж түүнийг шийдвэрлэх арга замуудыг томъёолдог.	Бага насны болон хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд зориулсан орчин бүрдүүлэхэд үнэлгээ хийж дүгнэлт гаргадаг.	Бага насны болон хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд туслах талаар бусдад сурталчилдаг.

БҮРЭН ДУНД БОЛОВСРОЛЫН ТҮВШИН

ЭРҮҮЛ МЭНД

ХИЧЭЭЛ, СУРГАЛТЫН ҮР ДҮНГ ҮНЭЛЭХ ШАЛГУУР

Нэгдүгээр бүлэг - X анги
Хоёрдугаар бүлэг - XI анги
Гуравдугаар бүлэг - XII анги

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ. Х АНГИ

1.1.Х АНГИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ХИЧЭЭЛИЙН СУРАЛЦАХУЙН ҮР ДҮН

Үнэлгээний зорилт	Суралцахуйн үр дүн
Мэдлэг ойлголт	• Хүрээлэн буй орчны бохирдол, дархлаанд нөлөөлөх хүчин зүйлс, хорт хавдрын талаар мэдлэгтэй болно. • Эрүүл мэндэд бичил тэжээлийн дутлын сөрөг нөлөөг мэддэг болно. • Стресс үүсгэгч хүчин зүйлс, түүнд үзүүлэх хариу үйлдлийг тайлбарладаг болно. • Архи тамхины тархи мэдрэл, мэдрэхүйн үйл ажиллагаанд үзүүлэх сөрөг нөлөөлөл, донтолт хэрхэн үүсдэг талаар ойлголттой болно. • Бэлгийн зан үйл, жирэмслэлтээс сэргийлэх арга хэрэгслийн давуу ба сул тал, дотно харилцаан дахь үүрэг, хариуцлагын талаар мэддэг болно. • Замын хөдөлгөөний аюулгүй байдалд нөлөөлөх хүчин зүйлс, хүн, мал, амьтны гоц халдварт өвчин, байгалийн аюулт үзэгдлийн талаар мэдлэгтэй болно.
Чадвар	• Орчны бохирдлыг бууруулах арга замыг нэрлэх, хорт хавдрын эрсдэлт хүчин зүйлсээс зайлсхийх, дархлаа дэмжих арга замыг хэрэгжүүлэх чадвартай болно. • Хоолны дэглэм, дасгал хөдөлгөөний талаарх мэдээлэл, сурталчилгаанд шүүмжлэлтэй ханддаг. • Стрессийг зохицуулах эерэг аргыг хэрэглэж чаддаг болно. • Архи тамхины талаарх аливаа мэдээллийг шүүн тунгаах чадвар эзэмшинэ. • Бэлгийн амьдрал, НҮЭМ-тэй холбоотой мэдээллийн эх сурвалжийг шүүн нягталж, үнэн бодит мэдээллийн эх сурвалжийг ялгаж чаддаг болно. • Замын хөдөлгөөнд аюулгүй байдлыг хангаж оролцох, хүн, мал, амьтны гоц халдварт өвчний хорио цээрийн үед авах арга хэмжээг мэдэх, амьдралдаа хэрэгжүүлэх чадвартай болно.
Хандлага	• Байгаль орчин, эрүүл мэндээ хамгаалах, биеэ чийрэгжүүлэх дадал хэвшилтэй болно. • Баталгаатай хоол хүнс сонгож хэрэглэх талаар бусдад нөлөөлдөг • Стресс үүссэн тухайн тохиолдолд зохицуулдаг, стресст өртсөн бусад хүнд тусалж, дэмжлэг үзүүлэх хандлагатай болно. • Архи тамхинаас татгалзах, буруу мэдээлэлд автахгүй байх хандлага төлөвшүүлнэ. • Дотно харилцаан дахь үүрэг, хариуцлагаа ухамсарладаг болно. • Замын хөдөлгөөнд аюулгүй оролцох, хүн, мал, амьтны гоц халдварт өвчний үед баримтлах журмыг биелүүлэх, хаа явсан газраа өөрийн болон бусдын аюулгүй байдлыг хангах бусдад туслах хандлагатай болно.

1.2. ҮНЭЛГЭЭНИЙ НЭГЖ ТУС БҮРИЙН СУРАЛЦАХУЙН ҮР ДҮНГИЙН ШАЛГУУР, ГҮЙЦЭТГЭЛИЙН ТҮВШИН

Үнэлгээний нэгж 1. Хувийн эрүүл ахуй ба орчны эрүүл мэнд

№	Суралцахуйн зорилт	Суралцахуйн үр дүн
1	10,01.а. Хорт хавдрын нийтлэг шинж тэмдгийг мэдэх, шаардлагатай үед эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэг шинжилгээнд хамрагдаж байхын ач холбогдлыг тайлбарлах	Сурагч хорт хавдрын нийтлэг шинжийг мэдэж, урьдчилан сэргийлэх үзлэг шинжилгээнд өөрийн хүсэлтээр хамрагддаг болно.
2	10,01.б. Нар, ус, агаараар биеэ чийрэгжүүлэх, хоол хүнсээ зөв тохируулан хэрэглэж хорт зуршлаас татгалзах нь хүний дархлааг дэмждэг болохыг тайлбарлах	Сурагч байгалийн хүчин зүйлүүдийн эрүүл мэндэд үзүүлэх эерэг, сөрөг нөлөөллийг хүний дархлаатай холбон тайлбарлаж чаддаг болно.
3	10,01.в. Хүний эрүүл мэндэд сөргөөр нөлөөлөх агаар, хөрс, усны бохирдлыг бууруулах, хор хөнөөлийг багасгах арга замыг нэрлэх, тайлбарлах	

ХИЧЭЭЛ, СУРГАЛТЫН ҮР ДҮНГ ҮНЭЛЭХ ШАЛГУУР

№	Суралцахуйн үр дүн	Суралцахуйн үр дүнгийн шалгуур
1	Сурагч хорт хавдрын нийтлэг шинжийг мэдэж, урьдчилан сэргийлэх үзлэг шинжилгээнд өөрийн хүсэлтээр хамрагддаг болно.	Хорт хавдрын үед илэрч болох нийтлэг шинжийг үндэслэн хавдраас сэргийлэх арга замууд, шинжилгээнд хамрагдахын ач холбогдлыг тайлбарладаг.
2	Сурагч байгалийн хүчин зүйлүүдийн эрүүл мэндэд үзүүлэх эерэг, сөрөг нөлөөллийг хүний дархлаатай холбон тайлбарлаж чаддаг болно.	Эрүүл мэндэд нар, ус, агаар болон хоол хүнсний зөв хэрэглээ, агаар, хөрс, усны бохирдлын үзүүлэх нөлөөллийг хүний дархлаатай холбон тайлбарладаг.

Гүйцэтгэлийн түвшин

Суралцахуйн үр дүнгийн шалгуур	Гүйцэтгэлийн түвшин			
	I	II	III	IV
Хорт хавдрын үед илэрч болох нийтлэг шинжийг үндэслэн хавдраас сэргийлэх арга замууд, шинжилгээнд хамрагдахын ач холбогдлыг тайлбарладаг.	Хорт хавдрын нийтлэг шинж тэмдгээс 3-4-ийг нэрлэдэг.	Хорт хавдар үүсгэгч эрсдэлт хүчин зүйлсийг эх сурвалж ашиглан тодорхойлдог.	Хөх, төмсөг гэмтэх шалтгаан үр дагаврыг судалж, хөх төмсөгөө өөрөө шалгах аргачлалын дагуу үзүүлэн ашиглаж үнэлдэг.	Хорт хавдраас урьдчилан сэргийлэх арга замууд болон эрт илрүүлэг шинжилгээнд хамрагдахын ач холбогдлын талаар зөвлөмж бичиж бусдад түгээдэг.
Эрүүл мэндэд нар, ус, агаар болон хоол хүнсний зөв хэрэглээ, агаар, хөрс, усны бохирдлын үзүүлэх нөлөөллийг хүний дархлаатай холбон тайлбарладаг.	Биеэ чийрэгжүүлэх аргаас 4-5-ыг тоочдог.	Хүний эрүүл мэндэд сөргөөр нөлөөлөх агаар, хөрс, усны бохирдол түүний эх үүсвэрүүд, хор хөнөөлийг дүрсэлсэн зурагт үзүүлэн ашиглан тайлбарлаж, дүн шинжилгээ хийдэг.	Хүний эрүүл мэндэд агаар, хөрс, усны бохирдлын үзүүлэх сөрөг үр дагаврыг хэлэлцэж түүний хор нөлөөллийг бууруулах арга зам, алхмыг тодорхойлдог.	Хоол хүнс, дасгал хөдөлгөөн, хорт зуршил, стресс нь хүний дархлаанд хэрхэн нөлөөлдөг талаарх мэдээлэл, сурталчилгаанд шүүмжлэлтэй хандаж, дархлаагаа дэмжихийн ач холбогдлыг бусдад сурталчилдаг.

Үнэлгээний нэгж 2. Хооллолт ба хөдөлгөөн

№	Суралцахуйн зорилт	Суралцахуйн үр дүн
1	10,02.а. Ажил хөдөлмөр, дасгал хөдөлгөөний онцлогт тохируулан бичил тэжээлийн дутлаас сэргийлж, баталгаатай хоол хүнсийг сонгож хэрэглэх	Сурагч энэ нэгжийг үзсэний дараа эрүүл мэнд, ажил хөдөлмөр, дасгал хөдөлгөөний онцлогт тохируулан хоол хүнсээ зөв сонгон хэрэглэдэг болно.
2	10,02.б. Хоолны дэглэм, дасгал хөдөлгөөний талаарх мэдээлэл, сурталчилгаанд шүүмжлэлтэй хандаж, бусдад эергээр нөлөөлөх	

№	Суралцахуйн үр дүн	Суралцахуйн үр дүнгийн шалгуур
1	Сурагч энэ нэгжийг үзсэний дараа эрүүл мэнд, ажил хөдөлмөр, дасгал хөдөлгөөний онцлогт тохируулан хоол хүнсээ зөв сонгон хэрэглэдэг болно.	Хүний эрүүл мэндэд бичил тэжээл (аминдэм, эрдэс бодис)-ийн дутал, хоолны болон хөдөлгөөний дэглэмийн үзүүлэх эерэг сөрөг нөлөөг тайлбарладаг.
2		Хүний эрүүл мэндэд жин нэмэх, хасах хоолны дэглэм болон дасгал хөдөлгөөний үзүүлэх нөлөөний талаарх мэдээлэл, сурталчилгаанд шүүмжлэлтэй хандахын давуу талыг тодорхойлдог.

Гүйцэтгэлийн түвшин

Суралцахуйн үр дүнгийн шалгуур	Гүйцэтгэлийн түвшин			
	I	II	III	IV
Хүний эрүүл мэндэд бичил тэжээл (амин дэм, эрдэс бодис)-ийн дутал, хоолны болон хөдөлгөөний дэглэмийн үзүүлэх эерэг сөрөг нөлөөг тайлбарладаг.	Бичил тэжээл (амин дэм, эрдэс бодис)-ийн дутал болон хоолны дэглэмээс үүсэж болох өвчнийг нэрлэдэг.	Бичил тэжээл (амин дэм, эрдэс бодис)-ийн дутлаас сэргийлэхэд хоол хүнсний сонголт, зөв хэрэглээ чухал болох талаар эх сурвалж ашиглан тайлбарладаг.	Бичил тэжээл(амин дэм, эрдэс бодис)-ийн дутлын сөрөг нөлөө, хоолны болон дасгал хөдөлгөөний дэглэмийн давуу, сул талыг ялгадаг.	Хоолны дэглэм, дасгал хөдөлгөөний талаарх мэдээлэл, сурталчилгаанд шүүмжлэлтэй хандан дүгнэлт хийдэг.
Хүний эрүүл мэндэд жин нэмэх, хасах хоолны дэглэм болон дасгал хөдөлгөөний үзүүлэх нөлөөний талаарх мэдээлэл, сурталчилгаанд шүүмжлэлтэй хандахын давуу талыг тодорхойлдог.	Хэвлэл мэдээлэл, олон нийтийн дунд тархаж буй хоол болон хөдөлгөөний дэглэмийн талаар өөрийн үзэл бодлоо тайлбарладаг.	Хэвлэл мэдээлэл, цахимаас хоол, хөдөлгөөнтэй холбоотой мэдээлэл цуглуулж цуу яриа, эсвэл үнэн болох талаар дүн шинжилгээ хийдэг.	Богино хугацаанд жин хасах хоолны болон дасгал хөдөлгөөний дэглэм нь эрүүл мэндэд сөрөг нөлөөтэй болохыг жишээ баримтад үндэслэн тодорхойлдог.	Эрүүл мэндтэй холбоотой мэдээлэлд дүн шинжилгээ хийх шалгуур боловсруулж энэхүү шалгуурыг ашиглан зөвлөмж боловсруулдаг.

Үнэлгээний нэгж 3. Сэтгэцийн эрүүл мэнд

№	Суралцахуйн зорилт	Суралцахуйн үр дүн
1	10,03.а. Стресс үүсгэгч хүчин зүйлс, түүнд үзүүлэх хариу үйлдлийг тодорхойлж, дүн шинжилгээ хийх	Сурагч өгөгдсөн нөхцөлд стрессийг даван туулах эерэг аргыг аргачлалын дагуу зөв хэрэглэж байгаагаа харуулна.
2	10,03.б. Стрессийг даван туулах эерэг аргыг хэрэглэж, турших	

№	Суралцахуйн үр дүн	Суралцахуйн үр дүнгийн шалгуур
1	Сурагч өгөгдсөн нөхцөлд стрессийг даван туулах эерэг аргыг аргачлалын дагуу зөв хэрэглэж байгаагаа харуулна.	Стрессийг даван туулах эерэг аргуудыг хэрэглэж чадахаа үг хэллэг болон үйлдлээр харуулдаг.

Гүйцэтгэлийн түвшин

Суралцахуйн үр дүнгийн шалгуур	Гүйцэтгэлийн түвшин			
	I	II	III	IV
Стрессийг даван туулах эерэг аргуудыг хэрэглэж чадахаа үг хэллэг болон үйлдлээр харуулдаг.	Стрессийг даван туулах эерэг аргуудыг нэрлэж, багшийн зааснаар тайлбарладаг.	Стрессийг даван туулах эерэг аргуудыг өөрийн ойлгосноор тайлбарлан, ганц нэг аргыг хэрэглэхийг хичээдэг боловч, үг үйлдэл нь нийцэмжгүй байх.	Стрессийг даван туулах эерэг аргуудыг өөрийн үгээр зөв тайлбарлан, хэд хэдэн аргыг аргачлалын дагуу зөв гүйцэтгэдэг, үг хэллэг, үйлдэл нийцэмжтэй байх.	Стрессийг даван туулах эерэг аргуудын олон хувилбарыг жишээ гарган тайлбарлаж, тэдгээрийг үг үйлдлийн нийцэмжтэйгээр бүрэн гүйцэд, өөртөө итгэлтэйгээр харуулдаг.

ХИЧЭЭЛ, СУРГАЛТЫН ҮР ДҮНГ ҮНЭЛЭХ ШАЛГУУР

Үнэлгээний нэгж 4. Хорт зуршил

№	Суралцахуйн зорилт	Суралцахуйн үр дүн
1	10,04.а. Тархи, мэдрэхүйн эрхтний үйл ажиллагаанд архи, тамхи нөлөөлдөг болохыг хэлэлцэх	Сурагч энэ нэгжийг үзсэний дараа мэдээллийн эх сурвалжид үндэслэн архи тамхины тархи мэдрэхүйн үйл ажиллагаанд үзүүлэх хор уршгийг тодорхойлдог болно.
2	10,04.б. Архи, тамхины талаарх мэдээллийн олон эх сурвалжид дүн шинжилгээ хийх, найз нөхдөдөө үнэн зөв мэдээлэл өгөх	

№	Суралцахуйн үр дүн	Суралцахуйн үр дүнгийн шалгуур
1	Сурагч энэ нэгжийг үзсэний дараа мэдээллийн эх сурвалжид үндэслэн архи, тамхины тархи мэдрэхүйн үйл ажиллагаанд үзүүлэх хор уршгийг тодорхойлдог болно.	Хүний тархи, мэдрэхүйн үйл ажиллагаанд архи, тамхины донтуулах үйлчилгээтэй бодисын үзүүлэх сөрөг нөлөөг тайлбарладаг.

Гүйцэтгэлийн түвшин

Суралцахуйн үр дүнгийн шалгуур	Гүйцэтгэлийн түвшин			
	I	II	III	IV
Хүний тархи, мэдрэхүйн үйл ажиллагаанд архи, тамхины донтуулах үйлчилгээтэй бодисын үзүүлэх сөрөг нөлөөг тайлбарладаг.	Мэдрэхүйн эрхтнүүдэд архи, тамхи нөлөөлснөөс үүдэлтэй илрэх шинжүүдийг нэрлэдэг.	Тамхины донтуулах үйлчилгээг түүний найрлага дахь никотины үйлчлэлтэй холбон тайлбарладаг.	Архи, тамхины мэдрэхүй (хараа, сонсгол, амт, үнэр)-н үйл ажиллагаанд нөлөөлж буй сөрөг нөлөөг жишээ баримт, кэйс үндэслэн тодорхойлдог.	Хорт зуршилд автаж донтох үе шатуудыг тайлбарлаж, архи тамхины талаарх бодит ба цуу яриаг харьцуулан дүгнэлт хийдэг.

Үнэлгээний нэгж 5. Бэлгийн болон нөхөн үржихүйн эрүүл мэнд

№	Суралцахуйн зорилт	Суралцахуйн үр дүн
1	10,05.а. Харилцааны эрх, үүрэг хариуцлагыг ойлгож, хувийн хил хязгаар, хүсэлт хэрэгцээгээ үр дүнтэй аргаар илэрхийлэх, бусдын хил хязгаар, хүсэлт хэрэгцээг хүндэтгэх	Эрх, үүрэг, хүсэлт хэрэгцээ, хил хязгаарыг харгалзан бусадтай үр дүнтэй харилцаж чаддаг болно. Жирэмслэхээс сэргийлэх нийтлэг аргуудын давуу сул талыг харьцуулан, зөв хэрэглээний талаар бусдад тайлбарлаж чаддаг болно. Бэлгийн амьдралын талаарх мэдээллийн эх сурвалжид дүн шинжилгээ хийх замаар найдвартай эсэхийг ялгаж чаддаг болно.
2	10,05.б. Бэлгийн зан үйлийн хэлбэрийн аль нь зөв, буруу болохыг хууль тогтоомж, хүний эрхэд суурилан тайлбарлах; харилцан зөвшилцсон бэлгийн зан үйл нь хувь хүний сонголт болохыг ухаарах	
3	10,05.в. Жирэмслэхээс сэргийлэх арга хэрэгслийн олон арга хэлбэрийг харьцуулах (үр дүнтэй байдал, үзүүлэх нөлөө г.м.), тэдгээрийг хэрхэн хэрэглэх талаар ярилцах, бэлгэвч зөв хэрэглэхийг бодит болон зурагт үзүүлэн дээр үзүүлэх, тайлбарлах	
4	10,05.г. Бэлгийн амьдрал, бэлгийн харилцаа, жендэрийн хэвшмэл ойлголтын талаарх хэвлэл мэдээллийн хэрэгсэлд шүүмжлэлтэй хандах (эерэг, сөрөг нөлөө); мэдээллийн найдвартай эх сурвалжийг тодорхойлох, буруу ташаа мэдээллийг зогсоох	

№	Суралцахуйн үр дүн	Суралцахуйн үр дүнгийн шалгуур
1	Эрх, үүрэг, хүсэлт хэрэгцээ, хил хязгаарыг харгалзан бусадтай зөвшилцөн, үр дүнтэй харилцаж чаддаг болно.	Харилцааны эрх, үүргийн дагуу өөрийн болон бусдын хүсэлт хэрэгцээ, хил хязгаарыг харгалзан харилцан зөвшилцөх замаар хэрхэн үр дүнтэй харилцахыг харуулдаг.
2	Жирэмслэхээс сэргийлэх нийтлэг аргуудын давуу сул талыг харьцуулан, зөв хэрэглээний талаар бусдад тайлбарлаж чаддаг болно.	Жирэмслэхээс сэргийлэх нийтлэг аргуудын давуу сул талд тулгуурлан, тэдгээрийг хэрхэн зөв хэрэглэхийг оновчтой тайлбарладаг.
3	Бэлгийн амьдралын талаарх мэдээллийн эх сурвалжид дүн шинжилгээ хийх замаар найдвар эсэхийг ялгаж чаддаг болно.	Бэлгийн амьдралын талаарх мэдээллийн эх сурвалжийн найдвартай байдлыг тодорхой шалгуурын дагуу эргэцүүлэн, дүн шинжилгээ хийдэг.

Гүйцэтгэлийн түвшин

Суралцахуйн үр дүнгийн шалгуур	Гүйцэтгэлийн түвшин			
	I	II	III	IV
Харилцааны эрх, үүргийн дагуу өөрийн болон бусдын хүсэлт хэрэгцээ, хил хязгаарыг харгалзан харилцан зөвшилцөх замаар хэрхэн үр дүнтэй харилцахыг харуулдаг.	Харилцааны эрх, үүрэг ба харилцан зөвшилцөх нь үр дүнтэй гэдгийг хэлж тайлбарладаг.	Харилцааны эрх, үүргийн дагуу харилцан зөвшилцөх замаар харилцахыг хичээж буйг харуулдаг.	Харилцааны эрх, үүргийн дагуу өөрийн болон бусдын хүсэлт хэрэгцээ, хил хязгаарыг харгалзан, харилцан зөвшилцөх замаар үр дүнтэй харилцахыг тодорхой нөхцөлд харуулдаг.	Харилцааны эрх, үүргийн дагуу өөрийн болон бусдын хүсэлт хэрэгцээ, хил хязгаарыг бүхэлд нь харгалзан, харилцан зөвшилцөж үр дүнтэй харилцахыг дадал болгосноо харуулдаг.
Жирэмслэхээс сэргийлэх нийтлэг аргуудын давуу, сул талд тулгуурлан, тэдгээрийг хэрхэн зөв хэрэглэхийг оновчтой тайлбарладаг.	Жирэмслэхээс сэргийлэх нийтлэг аргуудын давуу, сул тал болон хэрхэн хэрэглэхийг тайлбарладаг.	Жирэмслэхээс сэргийлэх нийтлэг аргуудын давуу сул талд тулгуурлан, зөв хэрэглэх талаар үндэслэлтэй тайлбарлахыг хичээдэг.	Жирэмслэхээс сэргийлэх нийтлэг аргуудын давуу, сул тал болон зөв хэрэглэхийн уялдаа холбоог гарган оновчтой тайлбарладаг.	Жирэмслэхээс сэргийлэх нийтлэг аргуудын давуу, сул тал хэрэглээнд дүгнэлт хийж, оновчтой тайлбарладаг.
Бэлгийн амьдралын талаарх мэдээллийн эх сурвалжийн найдвартай байдлыг тодорхой шалгуурын дагуу эргэцүүлэн, дүн шинжилгээ хийдэг.	Бэлгийн амьдралын талаарх мэдээллийн эх сурвалжийн найдвартай байдлыг тодорхойлох шалгуурыг тайлбарладаг.	Бэлгийн амьдралын талаарх мэдээллийн эх сурвалжийн найдвартай байдлыг тодорхойлох шалгуурын дагуу бодит жишээг эргэцүүлэн, дүн шинжилгээ хийхийг оролддог.	Бэлгийн амьдралын талаарх мэдээллийн эх сурвалжийн найдвартай байдлыг тодорхойлох шалгуурын дагуу хэд хэдэн эх сурвалжийг эргэцүүлэн, асуудал дэвшүүлэн дүн шинжилгээ хийдэг.	Бэлгийн амьдралын талаарх мэдээллийн эх сурвалжийн найдвартай байдлыг тодорхой шалгуурын дагуу хэд хэдэн эх сурвалжийг эргэцүүлэн, дүн шинжилгээ хийж, үнэлгээ дүгнэлт өгдөг.

ХИЧЭЭЛ, СУРГАЛТЫН ҮР ДҮНГ ҮНЭЛЭХ ШАЛГУУР

Үнэлгээний нэгж 6. Аюулгүй байдал, анхны тусламж

№	Суралцахуйн зорилт	Суралцахуйн үр дүн
1	10,06.а. Замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангахад хүмүүсийн зан төлөв нөлөөлдөг болохыг хэлэлцэх	Сурагч замын хөдөлгөөний аюулгүй байдлыг ханган зорчиход хүний зан төлөв нөлөөлдөг болохыг жишээн дээр тайлбарладаг болно.
2	10,06.б. Байгалийн аюулт үзэгдэл болон гоц халдварт өвчний үеийн хорио цээрийн хариу арга хэмжээ авахад оролцох	Сурагч байгалийн аюулт үзэгдэл, гоц халдварт өвчин хорио цээрийн үеийн арга хэмжээнд иргэдийн үүрэг оролцооны ач холбогдлыг эергээр тайлбарладаг болно.

№	Суралцахуйн үр дүн	Суралцахуйн үр дүнгийн шалгуур
1	Сурагч замын хөдөлгөөний аюулгүй байдлыг ханган зорчиход хүний зан төлөв нөлөөлдөг болохыг жишээн дээр тайлбарладаг болно.	Замын хөдөлгөөний аюулгүй байдалд жолооч, зорчигчийн зүгээс нөлөөлөх нөлөөллийг тайлбарладаг.
2	Сурагч байгалийн аюулт үзэгдэл, гоц халдварт өвчин хорио цээрийн үеийн арга хэмжээнд иргэдийн үүрэг оролцооны ач холбогдлыг эергээр тайлбарладаг болно.	Сурагч байгалийн аюултай үзэгдэл, хүн, мал, амьтны гоц халдварт өвчний үед баримтлах журам, хорио цээрийн үед авах арга хэмжээг тайлбарладаг.

Гүйцэтгэлийн түвшин

Суралцахуйн үр дүнгийн шалгуур	Гүйцэтгэлийн түвшин			
	I	II	III	IV
Замын хөдөлгөөний аюулгүй байдалд жолооч, зорчигчийн зүгээс нөлөөлөх нөлөөллийг тайлбарладаг.	Замын хөдөлгөөнд аюулгүй оролцоход нөлөөлөх хүчин зүйлсийг тоочдог.	Замын хөдөлгөөнд аюулгүй оролцоход хүний ааш зан нөлөөлдөг болохыг тайлбарладаг	Замын хөдөлгөөнд оролцож буй хүмүүсийн зан төлөв нас, хүйс зэрэг нь ур чадварт нөлөөлдөг болохыг тайлбарладаг.	Замын хөдөлгөөний аюулгүй байдалд жолооч, зорчигчийн зүгээс нөлөөлөх нөлөөллийг тайлбарладаг.
Сурагч байгалийн аюултай үзэгдэл, хүн, мал, амьтны гоц халдварт өвчний үед баримтлах журам, хорио цээрийн үед авах арга хэмжээг тайлбарладаг.	Байгалийн аюултай үзэгдлийн үед учирч болзошгүй эрсдэлийг тоочдог.	Өөрийн амьдарч буй газар нутагт элбэг тохиолддог өвчний тохиолдол, тархалт, өвчин гаралтын тоонд дүн шинжилгээ хийдэг.	Байгалийн аюултай үзэгдэл, хүн, мал, амьтны гоц халдварт өвчний хорио цээрийн дэглэмийн үед авах арга хэмжээг тодорхойлж дүгнэлт хийдэг.	Хүн, мал, амьтны гоц халдварт өвчний хорио цээрийн дэглэмийн үеийн арга хэмжээг мөрдөхийн ач холбогдлын талаар бусдад сурталчилдаг.

ХОЁРДУГААР ХЭСЭГ. XI АНГИ

2.1. XI АНГИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ХИЧЭЭЛИЙН СУРАЛЦАХУЙН ҮР ДҮН

Үнэлгээний зорилт	Суралцахуйн үр дүн
Мэдлэг ойлголт	- Нийгмийн халдварт өвчин сүрьеэ, хамуу болон орчны эрүүл мэндэд хүнд металлын үзүүлэх сөрөг нөлөө, хор уршгийн талаар мэдлэгтэй болно. - Хоол хүнсний бүтээгдэхүүнээс өөрийн эрүүл мэндэд ашигтайг сонгох талаар мэдлэг ойлголттой болно. - Сэтгэл гутрал, сэтгэл түгшилт үүсгэдэг эрсдэлт хүчин зүйлсийн талаар мэддэг болно. - Хүний бие, сэтгэц, төдийгүй нийгэмд мансууруулах бодисын хор нөлөөг мэддэг болно. - Аюулгүй бэлгийн харилцаа, хүсээгүй жирэмслэлт ба үр хөндөлтийн сөрөг үр дагаврын талаар ойлголттой болно. - Химийн бодисын аюул, хор хөнөөл, хог хаягдлаас үүсэх хорт бодис, гэнэтийн халдлагын талаар мэдлэгтэй болно.
Чадвар	- Нийгмийн халдварт өвчин сүрьеэ, хамуу болон орчны эрүүл мэндэд хүнд металлын үзүүлэх сөрөг нөлөөллөөс өөрсдийн эрүүл мэндээ хамгаалах, урьдчилан сэргийлэх чадвартай болно. - Таргалалт, чихрийн шижин өвчнөөс сэргийлэхийн тулд өөрийн амьдралын хэв маягийг өөрчлөх чадвартай болно. - Сэтгэл гутрал, сэтгэл түгшилт үүсгэдэг эрсдэлт хүчин зүйлээс сэргийлж чаддаг болно. - Мансууруулах бодисын хэрэглээнээс татгалзахад бусдад тусалдаг чадвартай болно. - Жирэмсний шинж тэмдэг, жирэмсэн үеийн хяналтын ач холбогдлын талаар бусдад тайлбарлаж чаддаг болно. - Химийн бодистой зөв харьцах, хог хаягдлаас үүдэлтэй өвчнөөс урьдчилан сэргийлэх, гэнэтийн осолд өртөж болох орчны үнэлгээ хийх, эрсдэлээс зайлсхийх, өөрийгөө хамгаалах чадвартай болно.
Хандлага	- Нийгмийн халдварт өвчнөөс сэргийлэх, өөрийн болон бусдын эрүүл мэндийг хамгаалах, орчны бохирдлыг багасгахад нийгэмд хувь нэмрээ оруулдаг болно. - Өөрийн бие махбодын онцлог, насны бүлэгт тохируулан хоол хүнсээ сонгож сурна. - Сэтгэл түгшилт, сэтгэл гутралд орсон хэн нэгнийг ойлгож, туслах хандлагатай болно. - Мансууруулах бодисыг хэрэглэж туршихгүй, бусдын сөрөг нөлөөнд автахгүй байхыг таниулдаг. - Хүний эрхийн зөрчил, хүчирхийлэлтэй тэмцэхийн чухлыг ухаарч, өөрийн хувь нэмрийг оруулах хандлагатай болно. - Шаардлатай тохиолдолд анхны тусламж үзүүлэх, өөртөө болон бусдад туслах хандлагатай болно.

2.2. ҮНЭЛГЭЭНИЙ НЭГЖ ТУС БҮРИЙН СУРАЛЦАХУЙН ҮР ДҮНГИЙН ШАЛГУУР, ГҮЙЦЭТГЭЛИЙН ТҮВШИН

Үнэлгээний нэгж 1. Хувийн эрүүл ахуй ба орчны эрүүл мэнд

№	Суралцахуйн зорилт	Суралцахуйн үр дүн
1	11,01.а. Хар тугалга, асбест, пестицид зэрэг хүнд металл орчны бохирдолд хүргэдгийг тайлбарлах, дүн шинжилгээ хийх	Сурагч хүний эрүүл мэндэд хүнд металлын үзүүлэх хор нөлөөллийг жишээгээр тайлбарлаж дүн шинжилгээ хийдэг болно.
2	11,01.б. Нийгмийн халдварт өвчин болох сүрьеэ, хамуу өвчний сөрөг нөлөөлөл болон үнэн зөв мэдээллийг бусдад таниулах	Сурагч нийгмийн халдварт өвчний сөрөг нөлөөллийг эх сурвалж ашиглан бусдад тайлбарлаж чаддаг болно.

ХИЧЭЭЛ, СУРГАЛТЫН ҮР ДҮНГ ҮНЭЛЭХ ШАЛГУУР

№	Суралцахуйн үр дүн	Суралцахуйн үр дүнгийн шалгуур
1	Сурагч хүний эрүүл мэндэд хүнд металлын үзүүлэх хор нөлөөллийг жишээгээр тайлбарлаж дүн шинжилгээ хийдэг болно.	Сурагч хүнд металлын эрүүл мэндэд үзүүлэх хор нөлөө түүнээс урьдчилан сэргийлэх алхмуудыг тодорхойлж, дүн шинжилгээ хийдэг.
2	Сурагч нийгмийн халдварт өвчний сөрөг нөлөөллийг эх сурвалж ашиглан бусдад тайлбарлаж чаддаг болно.	Сурагч сүрьеэгийн халдвараас өөрийгөө болон бусдыг хамгаалах арга замуудыг жишээн дээр үндэслэн тайлбарладаг.

Гүйцэтгэлийн түвшин

Суралцахуйн үр дүнгийн шалгуур	Гүйцэтгэлийн түвшин			
	I	II	III	IV
Сурагч хүнд металлын эрүүл мэндэд үзүүлэх хор нөлөө түүнээс урьдчилан сэргийлэх алхмуудыг тодорхойлж, дүн шинжилгээ хийдэг.	Хүнд металлуудын эрүүл мэндэд үзүүлэх хор нөлөөг жагсаан бичдэг.	Хар тугалга, асбест, пестицид зэрэг хүнд металлууд хаана ихээр агуулагддаг болохыг судалж, баримтад дүн шинжилгээ хийдэг.	Хүнд металлын эрүүл мэндэд үзүүлэх хор нөлөө түүнээс урьдчилан сэргийлэх алхмуудыг тодорхойлж, эх сурвалж ашиглан дүгнэлт гаргадаг.	Хүнд металлын эрүүл мэндэд үзүүлэх хор нөлөөний талаар бусдад сурталчилан мэдээллийг түгээдэг.
Сурагч сүрьеэгийн халдвараас өөрийгөө болон бусдыг хамгаалах арга замыг жишээн дээр үндэслэн тайлбарладаг.	Сүрьеэ болон хамуу өвчний нийгэмд үзүүлэх хор нөлөөг дурдсан жагсаалт гаргадаг.	Сүрьеэ болон хамууны хүний эрүүл мэндэд үзүүлэх сөрөг үр дагаврыг судлан эх сурвалж ашиглан тайлбарладаг.	Сүрьеэ өвчин түүнээс хэрхэн урьдчилан сэргийлэх арга замыг шүүн хэлэлцэж дүгнэлт гаргадаг.	Сүрьеэгээс өөрсдийгөө болон бусдыг хамгаалах талаар анги хамт олондоо болон гэр бүлдээ зориулан зөвлөмж бичиж мэдээлэл түгээдэг.

Үнэлгээний нэгж 2. Хооллолт ба хөдөлгөөн

№	Суралцахуйн зорилт	Суралцахуйн үр дүн
1	11,02а. Хоол хүнстэй холбоотой хөтөлбөр, хууль эрх зүйн бичиг баримтад тулгуурлан сургуулийнхаа болон тогтмол үйлчлүүлдэг газрын хоол үйлдвэрлэл, үйлчилгээнд дүн шинжилгээ хийх	Сурагч энэ сэдвийг үзсэний дараа хоол хүнсний илчлэг болон дасгал хөдөлгөөний үе дэх илч зарцуулалтыг харьцуулснаар биеийн жингээ хянадаг болно.
2	11,02.б. Дасгал, хөдөлгөөний үе дэх илч зарцуулалт ба хоолны илчлэгийг харьцуулан, биеийн галбираа үнэлж, засах	

№	Суралцахуйн үр дүн	Суралцахуйн үр дүнгийн шалгуур
1	Сурагч энэ сэдвийг үзсэний дараа хоол хүнсний илчлэг болон дасгал хөдөлгөөний үе дэх илч зарцуулалтыг харьцуулснаар биеийн жингээ хянадаг болно.	Хоол хүнсээр авч буй илчлэг болон дасгал хөдөлгөөнд зарцуулж буй илчлэгийг харьцуулан тооцоолох замаар биеийн жин, галбирыг засах боломжтойг тайлбарладаг.

Гүйцэтгэлийн түвшин

Суралцахуйн үр дүнгийн шалгуур	Гүйцэтгэлийн түвшин			
	I	II	III	IV
Хоол хүнсээр авч буй илчлэг болон хөдөлгөөнд зарцуулж буй илчлэгийг харьцуулан тооцоолох замаар биеийн жин, галбирыг засах боломжтойг тайлбарладаг.	Хүснэгтэн мэдээлэл ашиглан хоол хүнсээр авч байгаа болон өдөр тутмын хөдөлгөөнд зарцуулж байгаа илчлэгийг аль нь их бага байгааг тооцоолдог.	Өөрийн хийсэн тооцооллыг ашиглан хоол хүнс ба дасгал хөдөлгөөний илчлэгийн хамаарал нь таргалах, жин барих, буурахад нөлөөлдгийг тайлбарладаг.	Өдрийн хэрэгцээт хоолны илчлэгийг тооцоолсноор бодисын үндсэн солилцоо ба хөдөлгөөн хоорондын хамаарлыг тайлбарладаг.	Биеийн жин болон галбирыг хоол, дасгал хөдөлгөөнөөр засах боломжтойг жишээ баримтад тулгуурлан тайлбарладаг.

Үнэлгээний нэгж 3. Сэтгэцийн эрүүл мэнд

№	Суралцахуйн зорилт	Суралцахуйн үр дүн
1	11,03.а. Сэтгэл түгшилт үүсгэдэг эрсдэлт хүчин зүйлсийг тодорхойлж, түүнээс урьдчилан сэргийлэх	Сурагч өдөр тутмын амьдралдаа сэтгэл гутрал, сэтгэл түгшилтээс сэргийлэх эерэг аргуудыг аргачлалын дагуу зөв хэрэглэж чаддаг болно.
2	11,03.б. Сэтгэл гутрал үүсгэдэг эрсдэлт хүчин зүйлсийг тодорхойлж, түүнээс урьдчилан сэргийлэх	

№	Суралцахуйн үр дүн	Суралцахуйн үр дүнгийн шалгуур
1	Сурагч өдөр тутмын амьдралдаа сэтгэл гутрал, сэтгэл түгшилтээс сэргийлэх эерэг аргуудыг аргачлалын дагуу зөв хэрэглэж чаддаг болно.	Сэтгэл гутрал, сэтгэл түгшилт үүсгэдэг хүчин зүйлс, илрэх шинж тэмдгийг ялгадаг Сэтгэл гутрал, сэтгэл түгшилтээс сэргийлэх эерэг аргуудыг хэрэглэдэг

Гүйцэтгэлийн түвшин

Суралцахуйн үр дүнгийн шалгуур	Гүйцэтгэлийн түвшин			
	I	II	III	IV
Сэтгэл гутрал, сэтгэл түгшилт үүсгэдэг хүчин зүйлс, илрэх шинж тэмдгийг ялгадаг.	Сэтгэл гутрал, сэтгэл түгшилт үүсгэдэг хүчин зүйл, илрэх шинж тэмдгийг нэрлэх төдий ялгадаг.	Сэтгэл гутрал, сэтгэл түгшилт үүсгэдэг хүчин зүйл, илрэх шинж тэмдгийг жишээ гарган ялгадаг.	Сэтгэл гутрал, сэтгэл түгшилт үүсгэдэг хүчин зүйл, илрэх шинж тэмдгийг үндэслэл нотолгоо гарган ялгах оролдлого хийдэг.	Сэтгэл гутрал, сэтгэл түгшилт үүсгэдэг хүчин зүйл, илрэх шинж тэмдгийг баттай үндэслэл нотолгоо ашиглан ялгадаг.
Сэтгэл гутрал, сэтгэл түгшилтээс сэргийлэх эерэг аргыг хэрэглэдэг.	Сэтгэл гутрал, сэтгэл түгшилтээс сэргийлэх эерэг аргыг хэрхэн хэрэглэхийг тайлбарладаг.	Сэтгэл гутрал, сэтгэл түгшилтээс сэргийлэх эерэг ганцхан аргыг хэрэглэдэг.	Сэтгэл гутрал, сэтгэл түгшилтээс сэргийлэх эерэг 2 аргыг зөв хэрэглэдэг.	Сэтгэл гутрал, сэтгэл түгшилтээс сэргийлэх эерэг 3-аас доошгүй аргыг зөв хэрэглэдэг.

ХИЧЭЭЛ, СУРГАЛТЫН ҮР ДҮНГ ҮНЭЛЭХ ШАЛГУУР

Үнэлгээний нэгж 4. Хорт зуршил

№	Суралцахуйн зорилт	Суралцахуйн үр дүн
1	11,04.а. Мансууруулах төрлийн бодисын бие, сэтгэц, нийгмийн сөрөг үр дагаврыг мэдэх	Сурагч энэ нэгжийг үзсэний дараа эрүүл, аюулгүй амьдрах, эрүүл мэндэд учирч болох эрсдэлээс сэргийлэх зорилгоор мансууруулах бодис хэрэглэхгүй байхын ач холбогдлыг тайлбарладаг болно.
2	11,04.б. Мансууруулах төрлийн бодис хэрэглэхгүй байх итгэл үнэмшилтэй болох	

№	Суралцахуйн үр дүн	Суралцахуйн үр дүнгийн шалгуур
1	Сурагч энэ нэгжийг үзсэний дараа эрүүл, аюулгүй амьдрах, эрүүл мэндэд учирч болох эрсдлээс сэргийлэх зорилгоор мансууруулах бодис хэрэглэхгүй байхын ач холбогдлыг тайлбарладаг болно.	Хүний бие болон сэтгэц, нийгэмд мансууруулах бодисын үзүүлэх хор нөлөөг тайлбарладаг.

Гүйцэтгэлийн түвшин

Суралцахуйн үр дүнгийн шалгуур	Гүйцэтгэлийн түвшин			
	I	II	III	IV
Хүний бие болон сэтгэц, нийгэмд мансууруулах бодисын үзүүлэх хор нөлөөг тайлбарладаг.	Мансууруулах бодис гэж юу болох, түүний сөрөг нөлөөг өөрийн дүгнэлтэд үндэслэн тайлбарладаг.	Мансууруулах бодисын хүний бие, сэтгэц төдийгүй нийгэмд үзүүлэх сөрөг нөлөөг харьцуулан тайлбарладаг.	Мэдээллийн эх сурвалжийг ашиглан мансууруулах бодисын сэтгэц, биед үзүүлэх сөрөг нөлөөллийн талаарх зөв буруу ойлголтыг ялган таньж илрүүлдэг.	Мансууруулах бодисоос татгалзахын тулд юуг мэддэг, юуг чаддаг, ямар итгэл үнэмшилтэй байх талаар бусдад таниулдаг.

Үнэлгээний нэгж 5. Бэлгийн болон нөхөн үржихүйн эрүүл мэнд

№	Суралцахуйн зорилт	Суралцахуйн үр дүн
1	11,05.а. Хэвийн жирэмслэлт, төрөлтийг дэмжих алхмыг тайлбарлаж, ач холбогдлыг ойлгох, эрт жирэмслэлт, төрөлттэй холбоотой эрүүл мэндийн эрсдэл болон үргүйдлийн шалтгааныг тодорхойлох	- Жирэмслэлт, төрөлттэй холбоотой асуудлын шалтгаан, үр дагаврыг жишээ гарган тодорхойлж чаддаг болно. - Хүсээгүй жирэмслэлтийн үед гаргах шийдвэрийн хувилбарт дүн шинжилгээ хийх замаар оновчтой шийдвэр гаргаж чаддаг болно. - Дотно харилцааны кейс ашиглан өөрийн хүсэл, хэрэгцээ, хил хязгаарыг үр дүнтэй илэрхийлж чаддаг болно. - Сургууль, гэр бүл, олон нийтийн газарт хүний эрхийн зөрчилтэй тэмцэхийн ач холбогдлыг бусдад зөв таниулдаг болно
2	11,05.б. Хүсээгүй жирэмслэлт, түүнтэй холбоотой шийдвэрийн хувилбарт дүн шинжилгээ хийж, оновчтой шийдвэр гаргах, хүсээгүй жирэмслэлтэд хүргэх хувь хүний эрсдэлийг тодорхойлох	
3	11,05.в. Хосууд хоорондын харилцаа эрүүл, зөв, илэн далангүй байснаар бэлгийн харилцаа нь аюулгүй, харилцан зөвшилцсон байж чаддагийг тайлбарлах; хүсэл хэрэгцээ, бэлгийн харилцааны хил хязгаарыг оновчтой илэрхийлэх	
4	11,05.г. Хүний эрх, бэлгийн болон жендэрт суурилсан хүчирхийллийн тухай хууль, бодлогод дүн шинжилгээ хийж, түүнтэй холбоотой хувь хүний үнэт зүйлсийг үнэлж, сургууль, гэр, цахим орчин, олон нийтийн газарт хүний эрхийн зөрчил, хүчирхийллийн эсрэг тэмцэхийн чухлыг ухаарах	

№	Суралцахуйн үр дүн	Суралцахуйн үр дүнгийн шалгуур
1	Жирэмслэлт, төрөлттэй холбоотой асуудлын шалтгаан, үр дагаврыг жишээ гарган тодорхойлж чаддаг болно.	- Жирэмслэлт, төрөлтийн үед анхаарах зүйлсийг танин мэдэхийн ач холбогдлыг тайлбарладаг. - Эрт жирэмслэх, эрт хүүхэд төрүүлэх, үргүйдэлтэй холбоотой эрсдэлийг тодорхойлдог.
2	Хүсээгүй жирэмслэлтийн үед гаргах шийдвэрийн хувилбарт дүн шинжилгээ хийх замаар оновчтой шийдвэр гаргаж чаддаг болно.	Хүсээгүй жирэмслэлтийн үед оновчтой шийдвэр гаргадаг.
3	Дотно харилцааны кейс ашиглан өөрийн хүсэл, хэрэгцээ, хил хязгаарыг үр дүнтэй илэрхийлж чаддаг болно.	Дотно харилцааны хүрээнд өөрийн хүсэл, хэрэгцээ, хил хязгаарыг оновчтой илэрхийлдэг.
4	Сургууль, гэр бүл, олон нийтийн газарт хүний эрхийн зөрчилтэй тэмцэхийн ач холбогдлыг бусдад зөв таниулдаг болно.	- Хүний эрхийн зөрчил, хүчирхийлэлтэй тэмцэх арга замыг төлөвлөдөг. - Хүний эрхийн зөрчил, хүчирхийлэлтэй тэмцэхийн ач холбогдлыг таниулах үйлдэл хийдэг.

Гүйцэтгэлийн түвшин

Суралцахуйн үр дүнгийн шалгуур	Гүйцэтгэлийн түвшин			
	I	II	III	IV
Жирэмслэлт, төрөлтийн үед анхаарах зүйлсийг танин мэдэхийн ач холбогдлыг тайлбарладаг.	Жирэмсний хяналтад орохын ач холбогдлыг нэрлэх төдий тайлбарладаг.	Жирэмсний хяналт, төрөлтийн үед анхаарах зүйлсийг танин мэдэхийн ач холбогдлыг жишээ гарган тайлбарладаг.	Жирэмсний хяналт, төрөлтийн үед анхаарах зүйлсийг танин мэдэхийн ач холбогдлыг нотолгоотой тайлбарладаг.	Жирэмсний хяналт, төрөлтийн үед анхаарах зүйлсийг танин мэдэхийн ач холбогдлыг үндэслэл нотолгоотой, уядаа холбоотойгоор тайлбарладаг.
Эрт жирэмслэх, эрт хүүхэд төрүүлэх, үргүйдэлтэй холбоотой эрсдэлийг тодорхойлдог.	Эрт жирэмслэх, эрт хүүхэд төрүүлэх, үргүйдэлтэй холбоотой эрсдэлийг жагсаан тодорхойлдог.	Эрт жирэмслэх, эрт хүүхэд төрүүлэх, үргүйдэлтэй холбоотой эрсдэлийг жишээ гарган тодорхойлдог.	Эрт жирэмслэх, эрт хүүхэд төрүүлэх, үргүйдэлтэй холбоотой эрсдэлийг баримт нотолгоотойгоор тодорхойлдог.	Эрт жирэмслэх, эрт хүүхэд төрүүлэх, үргүйдэлтэй холбоотой эрсдэлийг үндэслэл нотолгоотой, уялдаа холбоотой тодорхойлдог.
Хүсээгүй жирэмслэлтийн үед оновчтой шийдвэр гаргадаг.	Шийдвэрийн хоёроос илүүгүй хувилбар гаргаж, дүн шинжилгээ хийх ганцхан арга ашиглан, шийдвэр гаргадаг.	Шийдвэрийн 3 хувилбар гаргаж, дүн шинжилгээ хийх 2 арга ашиглан, шийдвэр гаргадаг.	Шийдвэрийн 4 хувилбар гаргаж, дүн шинжилгээ хийх 2-3 арга ашиглан, оновчтой шийдвэр гаргадаг.	Шийдвэрийн 5 ба түүнээс хувилбар гаргаж, дүн шинжилгээ хийх 4 арга ашиглан, нөхцөл байдлыг харгалзан оновчтой шийдвэр гаргадаг.
Дотно харилцааны хүрээнд өөрийн хүсэл, хэрэгцээ, хил хязгаарыг оновчтой илэрхийлдэг.	Өөрийн хүсэл, хэрэгцээ, хил хязгаарыг өөртөө итгэлгүй ч хэлж чаддаг.	Өөрийн хүсэл, хэрэгцээ, хил хязгаарыг үг, биеийн хэлэмжээ тохируулан хэлэх оролдлого хийдэг.	Өөрийн хүсэл, хэрэгцээ, хил хязгаарыг үг, биеийн хэлэмжээ тохируулан хэлдэг.	Өөрийн хүсэл, хэрэгцээ, хил хязгаарыг өөртөө итгэлтэйгээр үр дүнтэй илэрхийлдэг.

ХИЧЭЭЛ, СУРГАЛТЫН ҮР ДҮНГ ҮНЭЛЭХ ШАЛГУУР

Хүний эрхийн зөрчил, хүчирхийлэлтэй тэмцэх арга замыг боловсруулдаг.	Хүний эрхийн зөрчил, хүчирхийлэлтэй тэмцэх ганцхан арга замыг нэг өгүүлбэрээр илэрхийлэн боловсруулдаг.	Хүний эрхийн зөрчил, хүчирхийлэлтэй тэмцэх 2 арга замыг хэрхэн хийхийг тусган боловсруулдаг.	Хүний эрхийн зөрчил, хүчирхийлэлтэй тэмцэх 3 арга замыг хэн, юуг, ямар нөөц боломж ашиглан хэрхэн хийхийг тусган боловсруулдаг.	Хүний эрхийн зөрчил, хүчирхийлэлтэй тэмцэх 4 ба түүнээс дээш арга замыг хэн, юуг, ямар нөөц боломж ашиглан хэрхэн хийхийг тусган боловсруулдаг.
Хүний эрхийн зөрчил, хүчирхийлэлтэй тэмцэхийн ач холбогдлыг таниулах үйлдэл хийдэг.	Хүний эрхийн зөрчил, хүчирхийлэлтэй тэмцэхийн ач холбогдлыг нэрлэдэг.	Хүний эрхийн зөрчил, хүчирхийлэлтэй тэмцэхийн ач холбогдлыг кейс ашиглан тайлбарладаг.	Хүний эрхийн зөрчил, хүчирхийлэлтэй тэмцэхийн ач холбогдлыг бусдад таниулах арга замын жишээ гаргадаг.	Хүний эрхийн зөрчил, хүчирхийлэлтэй тэмцэхийн ач холбогдлыг таниулах арга замын 2-3 хувилбар гарган, үйлдэл хийж үзүүлдэг.

Үнэлгээний нэгж 6. Аюулгүй байдал, анхны тусламж

№	Суралцахуйн зорилт	Суралцахуйн үр дүн
1	11,06.а. Химийн бодисыг аюулгүй ашиглах, хордсон тохиолдолд анхны тусламж үзүүлэх	Сурагч химийн бодисын аюул, онцлог, хор нөлөөг ялган химийн бодист хордсон тохиолдолд үзүүлэх анхны тусламжийн талаар тайлбарладаг болно.
2	11,06.б. Гэнэтийн халдлагад өртөж болохуйц орчны үнэлгээ хийх, эрсдэлтэй нөхцөл байдлаас зайлсхийх	Сурагч өөрийн амьдрах орчиндоо гэнэтийн халдлагад өртөж болох эрсдэлт нөхцөл байдалд өөрийнхөө боломжийг ашиглан дүн шинжилгээг хийдэг болно.

№	Суралцахуйн үр дүн	Суралцахуйн үр дүнгийн шалгуур
1	Сурагч химийн бодисын аюул, онцлог, хор нөлөөг ялган химийн бодист хордсон тохиолдолд үзүүлэх анхны тусламжийн талаар тайлбарладаг болно.	Сурагч химийн бодистой зөв харьцаж хордсон тохиолдолд анхны тусламж үзүүлэх аргачлалыг боловсруулж тайлбарладаг.
2	Сурагч өөрийн амьдрах орчиндоо гэнэтийн халдлагад өртөж болох эрсдэлт нөхцөл байдалд өөрийнхөө боломжийг ашиглан дүн шинжилгээг хийдэг болно.	Сурагч гэнэтийн халдлагад өртөж болох орчныг үнэлж, эрсдлээс зайлсхийх арга замуудыг тодорхойлдог.

Гүйцэтгэлийн түвшин

Суралцахуйн үр дүнгийн шалгуур	Гүйцэтгэлийн түвшин			
	I	II	III	IV
Сурагч химийн бодистой зөв харьцаж хордсон тохиолдолд анхны тусламж үзүүлэх аргачлалыг боловсруулж тайлбарладаг.	Химийн бодисыг төрлөөр нь ангилж, онцлог, хор нөлөөгөөр ялган тайлбарладаг.	Химийн бодистой ажиллах аюулгүй ажиллагааны дүрмийг мөрдөөгүйгээс гарах сөрөг үр дагаврыг таамаглан хэлэлцэж дүгнэдэг.	Химийн бодисын тэмдэглэгээг шинжлэн судалж, химийн бодист хордсон тохиолдолд үзүүлэх анхны тусламжийн аргачлалыг боловсруулдаг.	Химийн бодист хордсон тохиолдолд үзүүлэх анхны тусламжийн талаар зөвлөмж бичдэг.

Сурагч гэнэтийн халдлагад өртөж болох орчныг үнэлж, эрсдэлээс зайлсхийх арга замыг тодорхойлдог.	Гэнэтийн халдлагууд, түүний эрсдэлт нөхцөлийг тоочдог.	Өөрийн амьдардаг орчныхоо гэнэтийн халдлагад өртөж болох газруудын зураглалыг гаргаж дүн шинжилгээ хийдэг.	Гэнэтийн халдлага түүний эрсдэлт нөхцөлийг үнэлж, үнэлгээний давуу талыг судлан дүгнэлт хийдэг.	Гэнэтийн халдлагаас сэргийлэх арга замуудыг тодорхойлж бусдад туслан сурталчилгаа хийдэг.
--	--	--	---	---

Гүйцэтгэлийн түвшин

Суралцахуйн үр дүнгийн шалгуур	Гүйцэтгэлийн түвшин			
	I	II	III	IV
Сурагч шаардлагатай тохиолдолд гарын доорх материал ашиглан анхны тусламж үзүүлдэг.	Гэнэтийн осол гэмтлүүдийн төрлийг нэрлэдэг.	Шаардлагатай тохиолдолд гарын доорх материал ашиглан анхны тусламж үзүүлэх аргачлалыг тайлбарладаг.	Гэнэтийн осол гарч болох эрсдлийг үнэлж тодорхойлдог.	Гэнэтийн осол гэмтлийн үед анхны тусламж үзүүлэх талаар бусдад зориулан зөвлөмж бичдэг.
Сурагч шаардлагатай тохиолдолд бага насны болон хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд тусалдаг.	Бага насны болон хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд гарч болох хэрэгцээ шаардлагын жагсаалт гаргадаг.	Бага насны болон хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд тохиолдох бэрхшээлүүдийг тоочиж түүнийг шийдвэрлэх арга замуудыг томъёолдог.	Бага насны болон хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд зориулсан орчин бүрдүүлэхэд үнэлгээ хийж дүгнэлт гаргадаг.	Бага насны болон хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд туслах талаар бусдад сурталчилдаг.

ГУРАВДУГААР ХЭСЭГ. XII АНГИ

3.1. XII АНГИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ХИЧЭЭЛИЙН СУРАЛЦАХУЙН ҮР ДҮН

Үнэлгээний зорилт	Суралцахуйн үр дүн
Мэдлэг ойлголт	- Монгол гэрийн онцлог, дотоод заслыг эрүүл ахуйн шаардлагад нийцүүлэх засах, нийгмийн эрүүл мэндийг дэмжих бодлого, дүрэм журмын талаар мэдлэгтэй болно. - Өдөр тутмын хүнсэндээ баяжуулсан болон зохицуулах үйлчилгээтэй хүнс сонгохын давуу талаар ойлголттой болно. - Сэтгэцийн эрүүл мэндийн тулгамдсан асуудал, сэтгэцийн хувьд эрүүл байхын ач холбогдлын талаар мэддэг болно. - Архи тамхи, мансууруулах бодистой холбоотой хууль эрх зүйн баримт бичгийн талаар ойлголттой болно. - Гэрлэлт, эцэг эхийн үүрэг хариуцлага, бэлгийн хариу үйлдлийн талаар мэддэг болно. - Осол гэмтлээс сэргийлэх, замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль дүрэм, журам, нийгмийн халамж үйлчилгээний талаар мэдлэгтэй болно.
Чадвар	- Монгол гэрийн дотоод заслыг орчин үеийн хөгжилтэй нийцүүлэн засах, уламжлалт ахуйд суралцах, нийгмийн эрүүл мэндийг дэмжих бодлогыг хэрэгжүүлэхэд хувь нэмрээ оруулах, өвчлөлөөс урьдчилан сэргийлэх чадвартай болно. - Генийн өөрчлөлттэй бүтээгдэхүүнийг шошгоос унших, генийн өөрчлөлттэй болон биологийн идэвхт нэмэлт бүтээгдэхүүний талаар үнэлэлт, дүгнэлт өгнө. - Сэтгэцийн хувьд эрүүл байхын ач холбогдлыг бусдад зөвлөж чаддаг болно. - Өөрийгөө ба бусдыг хорт зуршилд өртөхгүй байх, түүнээс сэргийлэх үр чадварыг эзэмшинэ. - Гэр бүл, ирээдүйн амьдралаа төлөвлөж чаддаг болно. - Осол гэмтлээс сэргийлэх, замын хөдөлгөөний аюулгүй байдлыг судалж, иргэний үүргээ биелүүлэх, нийгмийн даатгалд хамрагдах чадвартай болно.
Хандлага	- Уламжлалт ёс заншлаа дээдлэх хандлагатай болно. - Өөрийн эрүүл мэндэд сөрөг нөлөөгүй хүнсийг сонгож хэрэглэдэг, хүнсний нэмэлт бүтээгдэхүүнийг хэрхэн таних талаар бусдад туслан зөвлөнө. - Сэтгэцийн тулгамдсан асуудалтай хүмүүсийг ойлгож, тусалж дэмжих хандлагатай болно. - Хорт зуршилд автахгүй байх эрүүл зан төлөв, хандлагыг төлөвшүүлнэ. - Бэлгийн харилцаанд хосууд харилцан бие биеэ хүндэтгэж, эрх тэгш харилцах нь чухал болохыг ухаарна. - Иргэний үүргээ биелүүлж хэвших, нийгмийн халамж үйлчилгээ хэрэгтэй хүнд сайн дураараа туслах, дэмжлэг үзүүлж сурах хандлагатай болно.

3.2. ҮНЭЛГЭЭНИЙ НЭГЖ ТУС БҮРИЙН СУРАЛЦАХУЙН ҮР ДҮНГИЙН ШАЛГУУР, ГҮЙЦЭТГЭЛИЙН ТҮВШИН

Үнэлгээний нэгж 1. Хувийн эрүүл ахуй ба орчны эрүүл мэнд

№	Суралцахуйн зорилт	Суралцахуйн үр дүн
1	12,01.а. Гэрийн дотоод засал, эрүүл ахуйн шаардлагыг мэдэх	Сурагч гэрийн дотоод засал тохижилт түүнд тавигдах эрүүл ахуйн шаардлага чухал нөлөөтэй болохыг тайлбарладаг болно.
2	12,01.б. Нийгмийн эрүүл мэндийн бодлого, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, дүрэм журам нь эрүүл мэндийг дэмжих, өвчлөлөөс урьдчилан сэргийлэхэд нөлөөлж байгааг тайлбарлах	Сурагч дүрэм, журам нь эрүүл мэндийг дэмжих, өвчлөлөөс урьдчилан сэргийлэхэд нөлөөлдгийг өөрийн үгээр тайлбарладаг болно.

№	Суралцахуйн үр дүн	Суралцахуйн үр дүнгийн шалгуур
1	Сурагч гэрийн дотоод засал тохижилт түүнд тавигдах эрүүл ахуйн шаардлага чухал нөлөөтэй болохыг тайлбарладаг болно.	Сурагч гэрийн дотоод засалд тавигдах эрүүл ахуйн шаардлагыг монгол гэр болон орчин үеийн байртай харьцуулан тайлбарладаг.
2	Сурагч дүрэм, журам нь эрүүл мэндийг дэмжих, өвчлөлөөс урьдчилан сэргийлэхэд нөлөөлдгийг өөрийн үгээр тайлбарладаг болно.	Сурагч дүрэм журам нь эрүүл мэндийг дэмжих, өвчлөлөөс урьдчилан сэргийлэхэд нөлөөлдгийг тайлбарладаг.

Гүйцэтгэлийн түвшин

Суралцахуйн үр дүнгийн шалгуур	Гүйцэтгэлийн түвшин			
	I	II	III	IV
Сурагч гэрийн дотоод засалд тавигдах эрүүл ахуйн шаардлагыг монгол гэр болон орчин үеийн байртай харьцуулан тайлбарладаг.	Гэрийн дотоод засалд тавигдах эрүүл ахуйн шаардлагын жагсаалт гаргадаг.	Гэрийн дотоод заслыг орчин үеийн байрны дотоод зохион байгуулалттай холбон план зураглал хийж зураг дээр тайлбарладаг.	Гэрийн дотоод засал тохижилтыг эрүүл ахуйн шаардлагад нийцүүлэн төлөвлөж, төсөл бичдэг.	Монгол гэрийн доторх тавилга, эд хогшлын зохион байгуулалт, ёс дэгийг эрүүл ахуйн шаардлагад нийцүүлэн тайлбарлаж, дүгнэлт хийдэг.
Сурагч дүрэм журам нь эрүүл мэндийг дэмжих, өвчлөлөөс урьдчилан сэргийлэхэд нөлөөлдгийг тайлбарладаг.	Нийгмийн эрүүл мэндийн бодлогын хүрээнд хийгддэг аян, сургалт сурталчилгаа, уралдаан тэмцээнийг тоочдог.	Эрүүл мэндийг дэмжих дүрэм журмын ач холбогдлыг эх сурвалж ашиглан тайлбарладаг.	Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтэд үнэлэлт, дүгнэлт гаргадаг.	Дүрэм журам нь эрүүл мэндийг дэмжих, өвчлөлөөс урьдчилан сэргийлэхэд нөлөөлдөг талаар бусдад сурталчилан түгээдэг.

Үнэлгээний нэгж 2. Хооллолт ба хөдөлгөөн

№	Суралцахуйн зорилт	Суралцахуйн үр дүн
1	12.02а. Зохицуулах үйлчилгээтэй болон баяжуулсан хүнсийг орон нутгийн онцлогийг харгалзан хэрэглэх	Сурагч энэ нэгжийг үзсэний дараа хүний эрүүл, хэвийн өсөлт хөгжлийг дэмждэг амин дэм, эрдсийн дутлаас сэргийлэх зорилгоор зохицуулах үйлчилгээтэй баяжуулсан хүнсийг сонгон хэрэглэдэг болно.
2	12.02б. Хүнсний нэмэлт, генийн өөрчлөлттэй бүтээгдэхүүний давуу, сул талыг ялган тодорхойлох	Сурагч хүнсний бүтээгдэхүүний шошго ашиглан хүнсний нэмэлт агуулсан болон генийн өөрчлөлттэй бүтээгдэхүүнийг таньж сөрөг үр дагаврыг тодорхойлдог.

№	Суралцахуйн үр дүн	Суралцахуйн үр дүнгийн шалгуур
1	Сурагч энэ нэгжийг үзсэний дараа хүний эрүүл, хэвийн өсөлт хөгжлийг дэмждэг амин дэм, эрдсийн дутагдлаас сэргийлэх зорилгоор зохицуулах үйлчилгээтэй баяжуулсан хүнсийг сонгон хэрэглэдэг болно.	Хүний эрүүл мэндэд зохицуулах үйлчилгээтэй болон баяжуулсан хүнсний үзүүлэх эерэг нөлөөг тодорхойлдог.
2	Сурагч хүнсний бүтээгдэхүүний шошго ашиглан хүнсний нэмэлт агуулсан болон генийн өөрчлөлттэй бүтээгдэхүүнийг таньж сөрөг үр дагаврыг тодорхойлдог.	Хүний эрүүл мэндэд хүнсний нэмэлт болон генийн өөрчлөлттэй хүнсний бүтээгдэхүүний үзүүлэх сөрөг нөлөөг тодорхойлдог.

ХИЧЭЭЛ, СУРГАЛТЫН ҮР ДҮНГ ҮНЭЛЭХ ШАЛГУУР

Гүйцэтгэлийн түвшин

Суралцахуйн үр дүнгийн шалгуур	Гүйцэтгэлийн түвшин			
	I	II	III	IV
Хүний эрүүл мэндэд зохицуулах үйлчилгээтэй болон баяжуулсан хүнсний үзүүлэх эерэг нөлөөг тайлбарладаг.	Зохицуулах болон баяжуулсан хүнсийг таньж мэддэг, ялгааг тайлбарладаг.	Зохицуулах болон баяжуулсан хүнсийг хэрэглэхийн давуу талыг тайлбарладаг.	Баяжуулсан болон зохицуулах үйлчилгээтэй хүнсний бүтээгдэхүүний ангилал, түүнийг хэрэглэхийн эерэг нөлөөг жишээ баримтад үндэслэн тайлбарладаг.	Хүн амын эрдэс, амин дэмийн дутлын судалгааны дүнг үндэслэн хүнсний бүтээгдэхүүнийг бичил шимт бодисуудаар баяжуулахын ач холбогдлыг тайлбарладаг.
Хүний эрүүл мэндэд хүнсний нэмэлт болон генийн өөрчлөлттэй бүтээгдэхүүний үзүүлэх сөрөг нөлөөг тодорхойлдог.	Хүнсний нэмэлт болон генийн өөрчлөлттэй бүтээгдэхүүнийг шошго ашиглан тодорхойлдог.	Шошгоноос хүнсний нэмэлт агуулсан болон генийн өөрчлөлттэй бүтээгдэхүүн аль нь болохыг ялган таньж, тэдгээрийн сул талыг нь тодорхойлдог.	Хүнсний нэмэлт бодисуудыг ангилж, хүний эрүүл мэндэд үзүүлэх ямар сөрөг нөлөөтэй болохыг тодорхойлдог.	Хүнсний нэмэлт бодис агуулсан болон биологийн идэвхт хүнсний нэмэлт бүтээгдэхүүний ялгааг харьцуулан эрүүл мэндэд сөрөг нөлөөгүйг сонгох талаар бусдад зөвлөдөг.

Үнэлгээний нэгж 3. Сэтгэцийн эрүүл мэнд

№	Суралцахуйн зорилт	Суралцахуйн үр дүн
1	12,03.а. Сэтгэцийн эрүүл мэндийн тулгамдсан асуудалтай хүмүүсийг ойлгож, тусалж дэмжих	Сурагч нийгмийн бүхий л орчинд сэтгэцийн тулгамдсан асуудалтай хүнд хэрхэн хандах болон сэтгэл зүйн хувьд эрүүл байхыг уриалж байгаагаа үг, үйлдлээр тодорхой харуулдаг болно.
2	12,03.б. Сэтгэл зүйн хувьд эрүүл байхын ач холбогдлыг бусдад таниулах	

№	Суралцахуйн үр дүн	Суралцахуйн үр дүнгийн шалгуур
1	Сурагч нийгмийн бүхий л орчинд сэтгэцийн тулгамдсан асуудалтай хүнд хэрхэн хандах болон сэтгэл зүйн хувьд эрүүл байхыг уриалж байгаагаа үг, үйлдлээр тодорхой харуулдаг болно.	Сэтгэцийн тулгамдсан асуудалтай хүнийг ойлгож, дэмжиж байгаагаа илэрхийлдэг Сэтгэл зүйн хувьд эрүүл байх талаар уриалах хэрэгцээтэй мэдээлэл өгч, үйлдэл хийдэг

Гүйцэтгэлийн түвшин

Суралцахуйн үр дүнгийн шалгуур	Гүйцэтгэлийн түвшин			
	I	II	III	IV
Сэтгэцийн тулгамдсан асуудалтай хүнийг ойлгож, дэмжиж байгаагаа илэрхийлдэг.	Өгсөн нөхцөлд сэтгэцийн тулгамдсан асуудалтай хүнээс ямар нэгэн зүйл болсон эсэхийг хэрхэн асуухыг тайлбарладаг.	Өгсөн нөхцөлд сэтгэцийн тулгамдсан асуудалтай хүнд тусламж дэмжлэг шаардлагатай эсэхийг асуух оролдлого хийдэг.	Сэтгэцийн тулгамдсан асуудалтай хүн гэж хэнийг хэлэхийг тайлбарлаж, түүнд тусламж дэмжлэг шаардлагатай эсэхийг хэрхэн тодорхой асуухыг харуулдаг.	Сэтгэцийн тулгамдсан асуудалтай хүн гэж хэнийг хэлэх талаар тайлбарлаж, түүнд тусламж дэмжлэг шаардлагатай эсэхийг тодорхой асууж, түүний мэдрэмж, бодол санааг хуваалцан, сонсоход бэлэн байгаагаа илэрхийлдэг.
Сэтгэл зүйн хувьд эрүүл байх талаар уриалах хэрэгцээтэй мэдээлэл өгч, үйлдэл хийдэг.	Сэтгэл зүйн хувьд эрүүл байх хэрэгтэй гэдгийг бусдад хэлдэг боловч өөрөө үйлдэл хийдэггүй.	Сэтгэл зүйн хувьд эрүүл байхын тулд хийж хэвшвэл зохих зүйлсийн талаар бусдад хэлдэг, 1-2 үйлдэл хийдэг.	Сэтгэл зүйн хувьд эрүүл байхын тулд хийж хэвшвэл зохих зүйлсийн талаар бусдад тодорхой мэдээлэл өгдөг, 2-3 үйлдлийг хийж хэвшсэн байх.	Сэтгэл зүйн хувьд эрүүл байхын ач холбогдол, эрүүл байхын тулд хийж хэвшвэл зохих зүйлсийн талаар бусдад хэрэгцээтэй, тодорхой мэдээлэл өгдөг, 3-аас доошгүй үйлдлийг хийж хэвшсэн байх.

Үнэлгээний нэгж 4. Хорт зуршил

№	Суралцахуйн зорилт	Суралцахуйн үр дүн
1	12,04.а. Хорт зуршилтай холбоотой хууль эрх зүйн баримт бичигт дүн шинжилгээ хийх	Хорт зуршилтай холбоотой хууль эрх зүйн баримт бичигт дүн шинжилгээ хийх замаар архи, тамхи, мансууруулах бодис хэрэглэхгүй байхын давуу талуудыг тайлбарладаг болно.
2	12,04.б. Хорт зуршил, мансууруулах төрлийн бодис хэрэглэхгүй байхыг бусдад таниулах	

№	Суралцахуйн үр дүн	Суралцахуйн үр дүнгийн шалгуур
1	Хорт зуршилтай холбоотой хууль эрх зүйн баримт бичигт дүн шинжилгээ хийх замаар архи тамхи, мансууруулах бодис хэрэглэхгүй байхын давуу талыг тодорхойлдог болно.	Хорт зуршил, мансууруулах төрлийн бодисоос татгалзах шалтгааныг хүний эрүүл мэндэд үзүүлж буй сөрөг нөлөө, хууль эрх зүйн заалтууд, хорт зуршил бүхий зан үйлийн талаарх жишээ баримтад үндэслэн тайлбарладаг.

ХИЧЭЭЛ, СУРГАЛТЫН ҮР ДҮНГ ҮНЭЛЭХ ШАЛГУУР

Гүйцэтгэлийн түвшин

Суралцахуйн үр дүнгийн шалгуур	Гүйцэтгэлийн түвшин			
	I	II	III	IV
Хорт зуршил, мансууруулах төрлийн бодисоос татгалзах шалтгааныг хүний эрүүл мэндэд үзүүлж буй сөрөг нөлөө, хууль эрх зүйн заалтууд, хорт зуршил бүхий зан үйлийн талаарх жишээ баримтад үндэслэн тайлбарладаг.	Архи, тамхитай холбоотой тэмдэг, тэмдэглэгээнүүд нь ямар учир утгыг илэрхийлдэг болохыг тайлбарладаг.	Монгол улсад мөрдөж байгаа архи тамхи мансууруулах бодистой холбоотой хууль дүрмийг нэрлэж сургуулийн орчинд хориглосон тэмдэг, тэмдэглэгээ, хуулийн заалтуудыг тайлбарладаг.	Архи тамхи хэрэглэх, худалдах, түүгээр үйлчлэхийг хориглосон газруудыг ялган нэрлэж иргэний ба байгууллагын хүлээх хариуцлагыг тайлбарладаг.	Мансууруулах болон сэтгэц идэвхт бодисын талаарх хууль эрх зүйн баримт бичигт дүн шинжилгээ хийснээр архи тамхины талаарх хууль эрх зүйн баримт бичгээс ялгаатай байгааг харьцуулан тайлбарладаг.

Үнэлгээний нэгж 5. Бэлгийн болон нөхөн үржихүйн эрүүл мэнд

№	Суралцахуйн зорилт	Суралцахуйн үр дүн
1	12,05.а. Гэрлэлтийн сайн сайхан, бэрхшээлтэй зүйлсийг үнэлж, эрх, үүрэг хариуцлагыг тодорхойлж, хайр, тэвчээр, тэгш байдал, харилцан хүндэтгэл чухал болохыг таньж мэдэх	Гэрлэлт ба эцэг эхийн үүрэг хариуцлага, гэрлэх, эцэг эх болоход чухал зүйлсийг жишээ гарган тодорхойлж чаддаг болно. Бэлгийн харилцаа, бэлгийн хариу үйлдэлд хосуудын хүлээх үүрэг хариуцлагыг ухамсарлаж байгаагаа илэрхийлдэг болно. Ирээдүйн амьдралын төлөвлөгөө боловсруулдаг.
2	12,05.б. Эцэг, эхийн үүрэг хариуцлагыг тодорхойлж, сайн эцэг, эх байх тухай өөрсдийн үнэт зүйлс, итгэл үнэмшлийн талаар тунгаан бодож, хүүхэдтэй болоход бэлэн болох нөхцөлийг үнэлэх	
3	12,05.в. Эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн бэлгийн хариу үйлдэл, түүнд нөлөөлөх хүчин зүйлс, (өвчин эмгэг, стресс, бэлгийн хүчирхийлэл, эм хэрэглэх, хорт зуршил, гэмтэл) үүсч болох асуудал бэрхшээлийг тодорхойлох, тусламж хүсэх	
4	12,05.г. Бэлгийн харилцаа нь таашаалтай, аюулгүй байх, түүнд хосууд хариуцлага хүлээх ёстойг ойлгож ухаарах	
5	12,05.д. Бэлгийн амьдралтай холбоотой мэдлэг, үнэт зүйл, хандлага, чадвараа ашиглан ирээдүйн амьдралаа төлөвлөх	

№	Суралцахуйн үр дүн	Суралцахуйн үр дүнгийн шалгуур
1	Гэрлэлт ба эцэг эхийн үүрэг хариуцлага, гэрлэх, эцэг эх болоход чухал зүйлсийг жишээ гарган тодорхойлж чаддаг болно.	Гэрлэлт ба эцэг эхийн үүрэг хариуцлага, хийж сурвал зохих зүйлсийг тодорхойлдог.
2	Бэлгийн харилцаа, бэлгийн хариу үйлдэлд хосуудын хүлээх үүрэг хариуцлагыг ухамсарлаж байгаагаа илэрхийлдэг болно.	Бэлгийн харилцаа, бэлгийн хариу үйлдэлд хүлээх үүрэг хариуцлагаа ухамсарласан хүний хийх үйлдлийг мэддэг, дагаж мөрдөхөд бэлэн байдаг.
3	Ирээдүйн амьдралын төлөвлөгөө боловсруулдаг болно.	Ирээдүйн амьдралын зорилго, түүндээ хүрэх алхмаа тодорхой, хэрэгжих боломжтой бодитой үйл ажиллагааг төлөвлөдөг.

Гүйцэтгэлийн түвшин

Суралцахуйн үр дүнгийн шалгуур	Гүйцэтгэлийн түвшин			
	I	II	III	IV
Гэрлэлт ба эцэг эхийн үүрэг хариуцлага, хийж сурвал зохих зүйлсийг тодорхойлдог.	Гэрлэсэн хос, эцэг эхийн хүлээх үүрэг хариуцлага, хийж сурвал зохих зүйлээс ганц нэг жишээ хэлдэг.	Гэрлэсэн хос, эцэг эхийн хүлээх үүрэг хариуцлага, хийж сурвал зохих зарим зүйлийг тодорхойлдог.	Гэрлэсэн хос, эцэг эхийн хүлээх үүрэг хариуцлага, хийж сурвал зохих ихэнх зүйлийг тодорхойлдог.	Гэрлэсэн хос, эцэг эхийн хүлээх үүрэг хариуцлага, хийж сурвал зохих бүх зүйлийг тодорхойлдог.
Бэлгийн харилцаа, бэлгийн хариу үйлдэлдээ хүлээх үүрэг хариуцлагаа ухамсарласан хүний хийх зүйлийг мэддэг, дагаж мөрдөхөд бэлэн байдаг.	Адил тэгш эрхтэй байх, харилцан бие биеэ хүндэтгэх, эрсдэлээс сэргийлэх, хамтдаа хариуцлага хүлээх ёстой зэрэг үүрэг хариуцлагаас ганц нэгийг нэрлэдэг бөгөөд мөрдөхөд бэлэн биш.	Адил тэгш эрхтэй байх, харилцан бие биеэ хүндэтгэх, эрсдэлээс сэргийлэх, хамтдаа хариуцлага хүлээх ёстой зэрэг үүрэг хариуцлагаас 2-3-ыг нэрлэдэг бөгөөд мөрдөхөд бэлэн гэдэгтээ итгэлтэй бус.	Адил тэгш эрхтэй байх, харилцан бие биеэ хүндэтгэх, эрсдэлээс сэргийлэх, хамтдаа хариуцлага хүлээх ёстой зэрэг үүрэг хариуцлагаас 2-3-ыг нэрлэдэг бөгөөд мөрдөхөд бэлэн.	Адил тэгш эрхтэй байх, харилцан бие биеэ хүндэтгэх, эрсдэлээс сэргийлэх, хамтдаа хариуцлага хүлээх ёстой гэдгийн учир шалтгааны тайлбарлаж, шаардлагатай тохиолдолд эдгээрийг өөртөө итгэлтэй мөрддөг.
Ирээдүйн амьдралын зорилго, түүнд хүрэх алхам нь тодорхой, хэрэгжих боломжтой бодитой үйл ажиллагааг төлөвлөдөг.	Ирээдүйн амьдралын зорилго, түүнд хүрэх алхам нь тодорхой бус, цаг хугацааны хувьд хэрэгжих боломжгүй байх.	Ирээдүйн амьдралын зорилго, түүнд хүрэх алхам, үйл ажиллагааны зарим хэсэг нь тодорхой бус.	Ирээдүйн амьдралын зорилго, түүнд хүрэх алхам нь тодорхой, хийх үйл ажиллагааг оновчтой төлөвлөх оролдлого хийдэг.	Ирээдүйн амьдралын зорилго нь тодорхой, түүнд хүрэх алхам логик дэс дараалалтай, хийх үйл ажиллагаа нь оновчтой, цаг хугацааны хувьд хэрэгжих боломжтой.

Үнэлгээний нэгж 6. Аюулгүй байдал, анхны тусламж

№	Суралцахуйн зорилт	Суралцахуйн үр дүн
1	12,06.а. Осол гэмтлээс сэргийлэх хууль тогтоомж, дүрэм журам баримтлах	Сурагч осол гэмтлээс сэргийлэх хууль тогтоомж, дүрэм, журам баримтлах нь урьдчилан тохиолдож болох эрсдэлээс сэргийлэхэд нөлөөлдгийг иргэний эрх үүрэгтэй холбон өөрийн үгээр тайлбарладаг болно.
2	12,06.б. Жирэмсэн болон хөхүүл эхчүүд, бага насны хүүхэд нийгмийн халамж, даатгалын үйлчилгээ авах заалтыг судлах	Сурагч жирэмсэн болон хөхүүл хүүхэдтэй эхчүүд, бага насны хүүхэд нийгмийн халамж үйлчилгээ авах түүнд хамрагдахын ач холбогдлын талаар сурталчилдаг.

ХИЧЭЭЛ, СУРГАЛТЫН ҮР ДҮНГ ҮНЭЛЭХ ШАЛГУУР

№	Суралцахуйн үр дүн	Суралцахуйн үр дүнгийн шалгуур
1	Сурагч осол гэмтлээс сэргийлэх хууль тогтоомж, дүрэм, журам баримтлах нь урьдчилан тохиолдож болох эрсдэлээс сэргийлэхэд нөлөөлдгийг иргэний эрх үүрэгтэй холбон өөрийн үгээр тайлбарладаг болно.	Сурагч осол гэмтлээс сэргийлэх хууль тогтоомж, дүрэм журам нь тохиолдож болох эрсдэлээс сэргийлэхэд нөлөөлдгийг тайлбарладаг.
2	Сурагч жирэмсэн болон хөхүүл хүүхэдтэй эхчүүд, бага насны хүүхэд нийгмийн халамж үйлчилгээ авах түүнд хамрагдахын ач холбогдлын талаар сурталчилдаг.	Сурагч жирэмсэн болон хөхүүл хүүхэдтэй эхчүүд, бага насны хүүхдийн авах нийгмийн халамж, даатгалын үйлчилгээний талаар тайлбарладаг.

Гүйцэтгэлийн түвшин

Суралцахуйн үр дүнгийн шалгуур	Гүйцэтгэлийн түвшин			
	I	II	III	IV
Сурагч осол гэмтлээс сэргийлэх хууль тогтоомж, дүрэм журам нь тохиолдож болох эрсдэлээс сэргийлэхэд нөлөөлдгийг тайлбарладаг.	Зам тээврийн осол гэмтэл гардаг шалтгаан, эрсдэлт хүчин зүйлүүдийг нэрлэж, шаардлагатай тохиолдолд ямар хууль тогтоомж, дүрэм журам үйлчилдэг болохыг тоочдог.	Осол гэмтлээс сэргийлэх болон замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль, дүрмийг судалж, иргэний эрх, үүрэгтэй холбон тайлбарладаг.	Зам тээврийн ослын үзүүлэлтийг эх сурвалж ашиглан графикаар илэрхийлэн дүгнэлт гаргадаг.	Зам тээврийн ослоос урьдчилан сэргийлэх зорилгоор хэлэлцүүлэг хийж бусдад сурталчилдаг.
Сурагч жирэмсэн болон хөхүүл хүүхэдтэй эхчүүд, бага насны хүүхдийн авах нийгмийн халамж, даатгалын үйлчилгээний талаар тайлбарладаг.	Нийгмийн халамжийн үйлчилгээний төрлийг нэрлэдэг.	Эрүүл мэндийн даатгалын төрлүүдийг жагсааж холбогдох баримт бичгийг судалж дүн шинжилгээ хийдэг.	Нийгмийн халамж зайлшгүй шаардлагатай хүнд хэрхэн дэмжлэг үзүүлэх талаар төсөл бичиж хэлэлцүүлдэг.	Нийгмийн халамж, нийгмийн халамжийн үйлчилгээ, эрүүл мэндийн болон бусад даатгал, жирэмсэн болон хөхүүл хүүхэдтэй эхчүүдэд олгох тэтгэмж түүнд хамрагдахын ач холбогдлын талаар бусдад зөвлөн сурталчилдаг.



“ЕБС-ийн Эрүүл мэндийн хичээл, сургалтын үр дүнг үнэлэх шалгуур”-ыг боловсруулсан ажлын хэсэг:

Ч.Байгалмаа	МУБИС, БСС-ийн багш, доктор (Ph.D)
Б.Болорцэцэг	Нийслэлийн ЕБ-ын 1 дүгээр сургуулийн багш, зөвлөх
Ц.Дийдэрмаа	Нийслэлийн ЕБ-ын 47 дугаар сургуулийн багш, зөвлөх

Хөндлөнгийн шинжээч:

Э.Мөнгөнтулга	МУБИС, МБУС-ийн багш, доктор (Ph.D)
---------------	-------------------------------------

Техникийн редактор:

Д.Энхжаргал	Боловсролын үнэлгээний төвийн ахлах мэргэжилтэн, магистр
-------------	--

Хэвлэлийн эх бэлтгэсэн дизайнер:

Э.Сансартуяа	“Хас дизайн пресс” ХХК-ийн дизайнер
Л.Алтансүх	Боловсролын үнэлгээний төвийн ахлах мэргэжилтэн



БОЛОВСРОЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ ЯАМ
БОЛОВСРОЛЫН ҮНЭЛГЭЭНИЙ ТӨВ

БОЛОВСРОЛЫН ҮНЭЛГЭЭНИЙ ТӨВ

Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг, 6-р хороо
Энхтайваны өргөн чөлөө, Арслантай гүүр
“ОЮУНЫ УНДРАА” группийн байр

Утас: 70119498, 70118485
И-мэйл: info@eecs.mn